





# **ЕСҮС ХРИСТ ЧУУЛГАНЫГ ХАЙРЛАСАН**

**Виллиам Майкдоналд**

# **CHRIST LOVED THE CHURCH**

**William MacDonald**

# ЕСҮС ХРИСТ ЧУУЛГАНЫГ ХАЙРЛАСАН

## Суралцагчдад өгөх зөвлөмж

Чуулган гэхээр хүмүүс элч нарын эрин үеийн дараа улс орнуудад хөгжин цэцэглэж эхэлсэн Ромын эзэнт гүрний шашны тэргүүн Канстантины тэргүүлсэн, өнөө үед Ромын католик, Грекийн үнэн алдартан, Америкийн сүмүүд болон уламжлалт бус өөр бусад бүлэглэлүүдийг багтаасан өргөн хэмжээний шашны нарийн тогтолцоо мэтээр дүрсэлдэг. Гэвч Шинэ Гэрээнд “Чуулган”-ыг чухам ийм утгаар өгүүлсэн гэж үү? Бурханы хувьд чуулган гэж юу вэ? Анх үүсэхдээ ямар байсан бэ? Өнөө үед ямар байх ёстой вэ?

Энэ талаар Библид чухам юу өгүүлдэгийг бид уг цуврал хичээлээр үзэх болно. Зарим хүнд энд илэрхийлэгдэх бодол санаанууд эрс эргэлт хийхэд хүргэх цоо шинэ ойлголт байхад, зарим нь удаан хугацаанд мэддэг байсан зүйлээ эндээс олж харах байх. Юутай ч “Эзэн ийн айлдав” гэсэн онцгой эрх мэдэл бүхий үгстэй дахин дахин таарсан бүх хүн нэгийг бодохгүй байхын аргагүй биз ээ. Энэхүү цуврал хичээл танд ивээл болох болтугай.

## **Таны үзэх хичээлүүд:**

1. Христийн бие болох чуулган ..... 1
2. Чуулганы тухай агуу үнэнүүд ..... 7
3. Орон нутгийн чуулган ..... 12
4. Христийн тэргүүлэл ..... 19
5. Чуулган дахь Ариун Сүнс ..... 26
6. Чуулган дахь сахилгажуулалт ..... 32
7. Чуулганы өсөлт ..... 37
8. Бурханаар томилогдсон Бурханы тахилч .. 46
9. Бурханы өмнө очих нь ..... 56
10. Харгалзагчид ..... 65
11. Үйлчлэгчид ..... 72
12. Бидний өмнөөс ..... 82

# ХРИСТИЙН БИЕ БОЛОХ ЧУУЛГАН

“Христ чуулганыг хайрлаад түүний төлөө Өөрийгөө өгсний адил...” (Ефес 5:25) бид ч бас чуулганыг хайрлаж өөрсдийгөө түүнд зориулах ёстой. Газар дээрх Христийн чуулганыг өсгөн хөгжүүлж, цэцэглүүлэн, ялуулахын тулд өөрсдийгөө золиослож, үнэнчээр, хайраар, баяр хөөртэй үйлчлэлээр бид өөрсдийгөө чуулганд бүрэн зориулах ёстой.

Энэхүү цуврал хичээлийн гол зорилго нь “Христийн бие болох чуулган”-ы гол шинж чанар ба байр суурийн удирдлага болсон Шинэ Гэрээний зарим чухал зарчмуудыг үзэж судлахад оршино. Эхлээд даяар чуулгантай холбоотой агуу, үл өөрчлөгдөх зарчмуудаас үзэж дараа нь эдгээр зарчмуудыг нэгж чуулган бүр ажил амьдрал дээрээ хэрхэн гэрчлэн харуулахыг үзнэ.

Юуны өмнө, чуулганы байдлыг түүнд хамрагдаж буй итгэгч хүмүүсийн байдалтай, өөрөөр хэлбэл, үнэний амьд гэрч болох ёстой. Тухайн чуулганы итгэгчидтэй салшгүй холбоотой гэдгийг онцлон тэмдэглэх хэрэгтэй. Үүнийг бид уг цуврал хичээлийн турш онцлон үзэх болно.

Одоо, даяар чуулган гэж чухам юу болохыг тодорхойлон үзэцгээе.

## **Чуулган гэж юу вэ**

Шинэ Гэрээнд чуулган хэмээн орчуулагдсан үг бол *ekklesia* буюу “цуглаан”, “дуудагдсан хэсэг хүмүүс” “чуулган” гэсэн утгатай грек үг юм. Израиль үндэстнийг Стефан чухам энэ үгээр дүрслэн “цөл дэх цуглаанд” (Үйлс 7:38) гэсэн

байдаг. Үйлс номонд, Ефест цугларсан олныг бас чухам энэ үгээр дүрсэлжээ (Үйлс 19:32,39,41). Гэвч *ekklesia* гэсэн энэ үг Шинэ Гэрээнд Эзэн Есүс Христэд итгэсэн итгэгч хүмүүсийг дүрслэхэд нийтлэг хэрэглэгдсэн байдаг. Тиймээс ч элч Паул “*Бурхан Өөрийн цусаар Өөртөө худалдаж авсан Бурханы чуулганыг...*” (Үйлс 20:28) гэжээ. Агуу элч Паул, Коринт хотын итгэгчдэд хандан бичсэн анхныхаа захидалд дэлхий ертөнцийг иудейчүүд, грекчүүд (харь үндэстэнүүд - орч), Бурханы чуулган хэмээн гурав хуваасан байдаг (1 Коринт 10:32). Мөн түүнчлэн, өөрөө итгэгч болохоосоо өмнө хавчиж байсан бүлэг хүмүүсээ Бурханы чуулган хэмээн тодорхойлж байжээ (1 Коринт 15:9).

Чуулганыг байгууллага биш харин амьд бие махбодь гэж хэлэх нь их бий. Энэ бол чуулганыг амьгүй албан байгууллага гэхээс илүү амьд нэгж гэсэн санаа юм. Чуулган бол Христийн амийг хуваалцсан бүх хүний нөхөрлөл, Ариун Сүнсээр эвлэлдэн нэгдсэн итгэгч хүмүүсийн амьд холбоо ажээ.

Шинэ Гэрээнд чуулганыг олон янзаар нэрлэн дүрсэлдэг ба чуулган гэж чухам юу болохыг ойлгохын тулд түүнийг нэрлэсэн нэр тус бүрийн ач холбогдлыг авч үзэх нь чухал.

### **1. Хонин сүрэг (Иохан 10:16).**

Еврей үндэстнүүд хонины хашаа бол чуулган нь хонин сүрэг юм. Иохан 10:16-д Эзэн Есүс “*Энэ хашаан дахь хонин сүргээс өөр хонин сүрэг Надад бий. Би тэднийг бас авчрах ёстой. Тэд Миний дууг сонсоно. Тэгээд тэд нэг хоньчинтой нэг хонин сүрэг болно*” гэжээ. Хонин сүрэг гэдэг нь Сайн Хоньчин Эзэнийхээ дууг сонсож хойноос нь дуулгавартай даган, Түүний хайр халамж доор хамтдаа амьдардаг итгэгч хүмүүс юм (Иохан 10:3-4).



## **2. Бурханы тариалангийн талбай (1 Коринт 3:9)**

Чуулган бол Өөрийн суу алдарын үр жимсийг дотор нь ургуулахаар төлөвлөсөн Бурханы тариалангийн талбай юм. Үр жимс ургуулах тухай санаа чухам эндээс гарсан ажээ.

## **3. Бурханы барилга (1 Коринт 3:9)**

Барилга гэсэн энэ үг Бурханы бүтээн байгуулж байгаа барилгын ажлыг дүрсэлж байна. Тэрээр чуулган дээр амьд чулуунуудыг нэмэн өрсөөр байгаа (1 Петр 2:5). Түүний ингэж их чухалчлан үзэж байгаа барилгын ажилд бидний амьдрал үнэнчээр зариулагдах нь үнэхээр чухал ажээ.

## **4. Бурханы сүм (1 Коринт 3:16)**

Сүм гэдэг үг бидэнд юуны өмнө, магтаал хүндэтгэлийг бодогдуулж, өнөө үед Бурхан зөвхөн чуулганы гишүүдээс магтаал хүндэтгэл хүртдэгийг сануулдаг.

## **5. Христийн бие (Ефес 1:22-23)**

Бие бол тухайн хүний гадаад болон дотоод байдлыг илэрхийлдэг зүйл. Тиймээс, Эзэн Бурхан Өөрийгөө өнөөгийн дэлхий ертөнцөд Христийн биеэр дамжуулан илэрхийлэхээр шийдсэн ажээ. Энэхүү агуу үнэнийг нэгэнт ойлгож мэдсэн итгэгч хүн чуулганыг бага ач холбогдолтой зүйл мэтээр бодож хэзээ ч чадахгүй ба харин Христийн биеийн эрхэм дээд сонирхолд өөрийгөө эргэлт буцалтгүй зориулдаг.

## **6. Шинэ хүн (Ефес 2:15)**

Энд шинэ бүтээл гэсэн санаа илэрхийлэгдэж байна. Еврей болон харь үндэстнүүдийн хоорондын том ялгаа чуулган дотор арилан үгүй болж Бурхан аль алийг нь шинэ, нэг хүн болгодог.

## **7. Бурханы орших газар (Ефес 2:22)**

Энэ үг өнөө үед Бурхан Хуучин Гэрээний үе шиг сүм, асар гэх мэт материаллаг зүйл дотор биш харин итгэгч хүмүүсийн чуулган дотор оршдог гэсэн үнэнийг илэрхийлж байна.

## **8. Христийн сүйт бүсгүй (Ефес 5:25-27, 2 Коринт 11:2)**

Чуулганыг сүйт бүсгүй гэсэн нь хайр сэтгэлийн санааг илэрхийлж байна. *“Нөхрүүд ээ, Христ чуулганыг хайрлаад түүний төлөө Өөрийгөө өгсний адил эхнэрүүдээ хайрла. Тэр чуулганыг үгээр дамжуулан усанд угааж цэвэрлэн, ариусгаад түүнийг ямар ч толбогүй, ямар ч үрчлээсгүй бөгөөд тиймэрхүү ямар ч зүйлгүй, харин ариун, гэм зэмгүй байлган Өөрийнхөө өмнө алдарт чуулган болгох гэсэн ажээ”* Христ нэгэнт чуулганыг хайрлаж түүний төлөө Өөрийгөө өгсөн аваас чуулган нь Түүнийг хайрлах сүйт бүсгүйн хайраар дүүрэх нь мэдээж.

## **9. Бурханы гэр бүл (1 Тимот 3:15)**

Гэрийн эзэн хүн гэр бүлдээ эмх цэгц, дэг журмыг тогтоодог. Энэ эмх цэгцийг 1 Тимот 3:15-д *“Бурханы чуулган болох Бурханы гэр бүл дотор хүн биеэ яаж авч явах ёстойг чамд мэдүүлэхийн тулд бичлээ”* гэжээ. Дэг журмын тухай 1 Петр 4:17-д *“Яагаад гэвэл шүүлт Бурханы гэр бүлээс эхлэх цаг нь болжээ”* гэсэн байдаг.

## **10. Үнэний багана ба суурь (1 Тимот 3:15)**

Эрт цагт багана нь барилгын тулгуур болохоос гадна зар түгээх самбар болон ашиглагддаг байжээ. Багана нь олонд түгээх тунхагийн гол хэрэгсэл болдог байв. Харин “суурь” хэмээн орчуулагдсан үг нь хаалт, хамгаалалт буюу тулгуур гэсэн утгатай. Ингэж Бурхан чуулганыг Түүний үнэнийг тунхаглах, тулж дэмжих, хамгаалах нэгж болгохоор тогтоосон ажээ. Тиймээс, итгэгч бид Бурханы хүсэл ба зорилгын гол өрнөл дунд байхын тулд чуулганы өсөлт болон сүнслэг байдлын сайн сайханд өөрсдийн дээд зэргийн хүчин чармайлтыг зориулах ёстой.

## Чуулганы эрхэм зорилго

Сайн мэдээ дэлгэрүүлэхийг өөрийн эрхэм зорилго хэмээн сайрхадаг боловч чуулгантай ямар ч холбоогүй байх үзэл баримталдаг хүн өнөөдөр олон бий. Элч Паулын үйлчлэл нь нэгдүгээрт, *“Христийн нэвтэршгүй баялгийг харь үндэстэнд тунхаглаж,”* (Ефес 3:8), мөн *“нууцын үйлчлэлийн үүрэг нь юу болохыг [бүгдэд] мэдүүлэх...”* буюу чуулганы агуу үнэн дээр суурилуулах гэсэн хоёр хэсгээс бүрдэж байсан (Ефес 3:9).

## Чуулганы эх үүсэл

Чуулганы эхэн үед бурханлаг, агуу хүмүүс бусдаасаа тод ялгарч байсан. Чуулганыг Хуучин Гэрээний израилийн үргэлжлэл хэмээн үздэг хүн олон байсан ч зарим хүн түүнийг Хуучин Гэрээний үед байгаагүй харин Шинэ Гэрээнээс үүсэн бий болсон гэдэгт бат итгэдэг байжээ. Хоёр дахь үзэл санааг дэмжих гурван зүйл бий:

- Ефес номын 3:4-5-д элч Паул чуулганыг *“өөр үеийнхэнд, хүний хөвгүүдэд мэдэгдээгүй боловч эдүгээ Сүнс дотор Түүний ариун элч нар ба эш үзүүлэгчдэд илчлэгдсэн...”* нууц гэсэн байдаг. Тэрээр 9-р ишлэлд чуулганыг дахин *“Бурханы дотор үеэс үед нууцлагдаж байсан”* нууц гэжээ (бас Колоссай 1:26, Ром 16:25,26 –ааг үзнэ үү). Ийнхүү Шинэ Гэрээний элч нар ба эш үзүүлэгчид гарч ирэх хүртэл Бурхан чуулганыг Хуучин Гэрээний үед нууцалж байсан ажээ.
- Эзэн Есүс, Матай 16:18-д *“Энэ хадан дээр Би Өөрийн чуулганыг босгох”* болно гэсэн байдаг. Өөрөөр хэлбэл, Энэ үгийг хэлж байсан тэр үед чуулган хараахан бий болоогүй байжээ.
- Паул, Ефес 4:8-11-т үхлээс амилаад дээш өргөгдсөн Христ чуулганд бэлгүүдийг өгсөн хэмээн дахин онцлон өгүүлжээ. Тиймээс энэ нь, хэрэв чуулган Есүсийг дээш өргөгдөхөөс өмнө оршин байсан бол түүнийг сурган боловсруулахын тулд бэлгүүд өгөгдөх шаардлагагүй байсныг баттай илтгэж байна.

Чуулган зөвхөн Шинэ Гэрээний үед үүссэн төдийгүй тодруулбал Пентекостын өдөр бий болсон гэдэгт бид итгэдэг. Христийн бие Ариун Сүнсний батисмаар үүсэн бий болсон (1 Коринт 12:13). Тэгвэл Ариун Сүнсний баптисм чухам хэзээ болсоныг тодорхой хэлж болох уу? Үйлс 1:5-д Эзэн Есүс дээш өргөгдөхийнхөө өмнө элч нарт *“та нар ойрын өдрүүдэд Ариун Сүнсээр баптисм хүртэх болно”* хэмээн амлажээ. Пентекостын өдөр *“тэд бүгд Ариун Сүнсээр дүүрч, мөнөөх Сүнсээр дамжуулан өгөгдсөнийг харь хэлээр ярьж эхлэв.”* (Үйлс 2:4). Үйлс номын 5-р бүлгийн 11-р ишлэл гэхэд чуулган хэдийнээ бүрэлдэн тогтсоныг уншиж болно. Учир нь тэнд *“Бүх чуулган болон энэ бүхнийг сонссон бүхэн үлэмжийн айдаст автав”* гэжээ.

Энэ бүхэн чуулган чухам Пентекостын өдөр мэндэлснийг харуулж буй мэт байна.

## ЧУУЛГАНЫ ТУХАЙ АГУУ ҮНЭНҮҮД

Бурханы чуулгантай холбоотой олон гайхамшигтай үнэнүүдийг Шинэ Гэрээний Үйлс ном болон Паулын захидлуудад өгүүлсэн байдаг. Энэ бүлэгт бид илүү чухал ач холбогдолтой долоон үнэнийг товч тайлбарлаж дараа дараагийн бүлгүүдэд дэлгэрүүлж үзэх болно.

### **Христийн бие бол ганц юм**

Ефес 4:4-т өгүүлснээр ганц л чуулган байдаг ажээ. Янз бүрийн нөхцөл байдлууд үүнийг үгүйсгэдэг мэт боловч цорын ганц амьд Бурхантай холбоотой, бүх итгэгчдийг хамруулсан бие энэ дэлхий дээр цор ганц байдаг нь үнэн юм. Хэдийгээр уг чуулган нүдэнд харагдахуйцаар оршин байдаггүй ч Ариун Сүнсний хүчээр ердийн бие болон бүрэлддэг аж.

### **Уг биеийн тэргүүн нь Христ юм**

Элч Паул чуулганыг хүний биетэй зүйрлүүлж (Ефес 5:23, Колоссай 1:18) уг биеийн тэргүүн буюу толгой нь болсон Есүс газар дээрх өөрийн биеийг тэнгэрт удирдан ажиллуулдагийг бидэнд заасан аж. Толгой гэдэг эрх мэдэл, удирдлага, оюун ухааны суурь юм. Толгой болон их бие нэг амьдрал, нэг сонирхол, нэг хэтийн төлвөөр амьдардаг. Бие үгүй бол толгой бүрэн гүйцэд байхгүйн адил чуулган үгүй бол Христ бүрэн гүйцэд байж чадахгүй. Тиймээс Ефес 1:23-т Христийн бие болсон чуулган нь *“Түүний бие буюу бүхний дотор бүгдийг Дүүргэгчийн дүүрэн байдал нь мөн”* гэжээ. Энэ нь итгэгч хүнд гүн бишрэл, магтаал хүндэтгэлийг төрүүлдэг.

### **Итгэгч бүх хүн энэ биеийн эрхтнүүд юм**

Аливаа хүн Есүст итгэж аврагдсан даруйдаа Христийн биеийн нэг эрхтэн болж чуулган дээр нэмэгддэг (Үйлс 2:47). Ийм гишүүнчлэл гарал угсаа, арьсны өнгө, яс үндэс, зан ааш, соёл, нийгмийн байдал, хэл яриа, шашин шүтлэгийн бүх хил

хязгаараас үл хамаарах ажээ.

Паул, Христийн биеийн эрхтнүүдийн тухай өгүүлсэн сонгодог хэсэгтээ (1 Коринт 12:12-26) бие олон эрхтэнтэйг (12-14-р ишлэлүүд), эрхтэн бүр өөр өөрийн үүрэгтэйг (15-17-р ишлэлүүд), бүхэл биеийн сайн сайхан байдал бүх эрхтнүүд нийлэн хэрхэн хамт ажиллахаас шалтгаалдагийг (21-23-р ишлэлүүд) сануулсан байдаг. Биеийн бүх эрхтнүүд нэг нэгэндээ хэрэгтэй учраас нэг талаас атаархах, дургүйцэх (15-17-р ишлэлүүд) нөгөө талаас бардамнах, нэг нэгнээсээ үл хамаарах (21-р ишлэл) байдлууд гарах шалтаг үгүй юм. Эрхтэн бүр нэгэн биеийн гишүүн учир харилцан нэг нэгнээ халамжилж, хайрлан өрөвдөж, хамтдаа баярлан баясах ёстой (23-26-р ишлэлүүд).

### **Чуулганд Христийг Ариун Сүнс төлөөлдөг**

Эзэн Есүс тэнгэрт өргөгдсөнийхөө дараа Ариун Сүнсийг Өөрийн төлөөлөгч болгон газар руу илгээсэн (Иохан 14:16,26). Ариун Сүнс итгэгчдийг магтаал хүндэтгэл рүү хэрхэн удирдан чиглүүлдэгээс Түүний үйл ажиллагааг харж болно (Ефес 2:18). Тэрээр итгэгчдийн залбирлыг өдөөж (Ром 8:26-27), номлолыг хүчирхэгжүүлж (1 Тесалоник 1:5), итгэгчдийн үйл ажиллагааг эерэг (Үйлс 13:2) ба сөрөг (Үйлс 16:6-7) байдлаар удирдан чиглүүлж, чуулганд харгалзагчдыг бий болгож (Үйлс 20:28), чуулганы өсөлт ба үр нөлөөг нэмэгдүүлэх сүнслэг бэлгүүдийг өгч (Ефес 4:11), итгэгчдийг бүх үнэн рүү удирддаг (Иохан 16:13).

### **Бурханы чуулган бол ариун юм**

Бурхан бүх үндэстнүүдээс хүмүүсийг Өөрийн нэрээр, Өөртөө дууддаг. Тэднийг гэм нүгэлт дэлхийгээс Өөртөө зориулан тусгаарлаж, ариун байдлыг бодитоор шингээсэн амьдралаар амьдрахыг хүсдэг (1 Коринт 3:17). Чуулган зөвхөн ийм маягаар ялзарч муудсан дэлхийд ариун Бурханыг төлөөлж чадна.

### **Чуулганыг босгон байгуулахын тулд сүнслэг бэлгүүд өгөгддөг**

Чуулган сүнсээр болон тоогоор өсөх нь Эзэний хүсэл юм.

Тиймээс ч үхлээс амилсан Есүс сүнслэг бэлгүүдийг чуулганд өгсөн аж (Ефес 4:11). Сүнслэг бэлгүүд гэдэг нь чуулганыг босгон байгуулахад тустай онцгой сүнслэг бэлгүүдийг хүлээн авсан хүмүүс юм. Эдгээр бэлгүүд нь Ефес 4:11-д бичигдсэнээр: элч, эш үзүүлэгч, сайн мэдээг тунхаглагч, пастор ба багш хийх бэлэг авъяасууд ажээ.<sup>1</sup>

Элч болон эш үзүүлэгч нь анх чуулганыг үндэслэн байгуулахад нэн тэргүүнд хэрэгтэй байсан аж (Ефес 2:20). Чуулганы суурь нэгэнтээ тавигдсаны дараа элч болон Шинэ Гэрээний эш үзүүлэгчийн хэрэгцээ аяндаа үгүй болсон агаад эдгээр сүнслэг бэлгүүд анх хэрэглэгдэж байсан тэр утгаараа хэрэглэгдэхээ больсон юм.<sup>2</sup>

Гэвч бидний дунд авралын зар тараагч, пастор, багш нар байсаар байгаа. Авралын зар тараагч хүн дэлхийгээр явж, сайн мэдээ тарааж, гэм нүгэлт хүмүүсийг Христ рүү хөтөлж дараа нь тэднийг тухайн орон нутгийн чуулганы нөхөрлөлд оруулж өгдөг. Харин пастор хүн тэднийг [хонинуудыг] тэжээх, урам зориг өгөх, бузар муугаас хамгаалах зэргээр асран халамжилдаг. Багш хүн Бурханы Үгийг ойлгомжтой байдлаар дэлгэн харуулж, Бичээсийн сургаал номлолуудыг тэнцвэртэйгээр заан таниулдаг.

Эдгээр сүнслэг бэлгүүд ийм байдлаар үйл ажиллагаагаа явуулахад чуулган өсөж, ариун хүмүүс ариун итгэл дээрээ барьж босгогддог. Сүнслэг бэлгүүд бол чуулганыг өргөжүүлэн тэлэх зорилгоор өгөгддөг Бурханы хангамж юм.

---

<sup>1</sup> 1 Коринт 12:8-10-т сүнслэг өөр бэлгүүдийг нэрлэсэн байдаг. Эдгээр нь: Мэргэн ухааны үг, мэдлэгийн үг, итгэл, эдгээх бэлэг, гайхамшгийг үйлдэх, эш үзүүлэх, сүнснүүдийг ялгах чадвар, олон хэлээр ярих чадвар, хэлүүдийг тайлбарлах чадвар юм. Сүнслэг бэлгүүдийн энэ хоёр төрлийн жагсаалт хоорондоо үл зөрчилдөх аж. Ефес номын 4-р бүлэгт дурьдагдсан сүнслэг бэлгүүд нь авралын зар тараах, сургах эсвэл пастор хийх ажлуудад бүх амьдралаа зориулсан хүмүүс байсан бол 1 Коринт номын 12-р бүлэгт дурьдагдсан сүнслэг бэлгүүд хэн нэгэн хүнээр хязгаарлагдаагүй харин Ариун Сүнсний хэзээ ч, Христийн биеийн аль ч гишүүнд өгч болох авъяас билэг буюу чадвар юм. Жишээлбэл: итгэгч ямар ч хүн багш биш атал сүнсээр удирдуулаад “мэргэн ухааны үг”-ийг эсвэл “мэдлэгийн үг”-ийг өгч болно. Мөн авралын зар тараагч биш атал хэн нэгнийг Христ рүү хандуулсан өөр нэгэн байж болно.

Элч Паул 1 Коринт 12:28-д элч, эш үзүүлэгч, багш болон гайхамшигийг үйлдэх, эдгээх, туслах, удирдах, олон янзын хэлээр ярих сүнслэг бэлгүүдийн тухай дахиад өгүүлжээ. Эндээс, өнөөгийн бидэнд гайхамшигт мөн чанарыг агуулсан сүнслэг бэлгүүд байсаар байгаа юу гэсэн асуулт зайлшгүй урган гарч ирнэ. Бурхан тэр үед сайн мэдээний дэлгэрүүлэлтийг баталгаажуулахын тулд тэмдэг ба гайхамшгуудыг ашигладаг байсан тухай Еврей 2:4-т өгүүлсэн байдаг. Тэр үед Бурханы Үг хэвлэгдэн гараагүй байсан. Библи бүрэн бүтнээрээ хэвлэгдэн гармагц дээрх гайхамшгуудын хэрэгцээ үгүй болсон гэж олон хүн үздэг. Библид энэ асуудал тодорхой өгүүлэгдээгүй аж. Бид ерөнхийдөө эдгээр сүнслэг бэлгүүдийг өнөөгийн бидэнд байхгүй гэж үздэг ч эдгээрийг Сүнс, нэн ялангуяа Библи өргөн хүрээгээр хэвлэгдээгүй газруудад хэрэглэх эрхгүй гэж хэлж чадахгүй. Аль ч тохиолдолд, гайхамшигт мөн чанарыг агуулсан сүнслэг бэлгүүдийн аль нэгийг өөртөө байгаа гэж хэлж буй хүн түүнийг Үгийн зааврын дагуу хэрэглэхэд анхаарах ёстой (жишээ нь: Олон янзын хэлээр ярих чадварыг 1 Коринт 14-т заасны дагуу ашиглах).<sup>2</sup> Нөгөө талаар, Эзэнээс томилогдсон хүнийг элч гэж үзвэл өнөөгийн бидэнд элч хүн байгаа нь эргэлзээгүй. Мөн түүнчлэн энэ утгаар авч үзвэл, гэм нүгэл хийгээд хүчирхийлэлийн эсрэг Эзэн Бурханыг дуудан хашгирах хүмүүс буюу эш үзүүлэгчид ч бас бидний дунд байгаа аж. Гэвч бид, эдгээр хүмүүст анхны элч нарт өгөгдсөн тэр эрх мэдэл бий гэдгийг эсвэл эдгээр эш үзүүлэгчид Шинэ Гэрээний эш үзүүлэгчдийн адил шууд болон бадрангуй илчлэлийг ярьж чадна гэдгийг үгүйсгэдэг.

## **Итгэгч бүх хүн Бурханы тахилч юм**

Чуулгантай холбоотой үнэнүүдийн сүүлчийнх бол итгэгч бүх хүн тахилч гэсэн үнэн юм (1 Петр 2:5-9). Хуучин Гэрээний үед зөвхөн нэг хэсэг хүмүүс л тахилч хийх эрхтэй байсан ба энэ нь Леви овог болон Аароны гэр бүл байв (Египетээс гарсан нь 28:1). Харин өнөө үед бусдаасаа ялгарсан, өвөрмөц өмсгөлтэй, онцгой эрх дархтай хүмүүс гэж байхгүй. Бурханы бүх хүүхэд Бурханы тахилч хэмээх эрхэм нэрийн онцгой эрх ба үүрэг хариуцлагыг үүрсэн тахилчид юм.

## **Чуулганы ирээдүйн хувь заяа**

Чуулган хараахан баригдаж дуусаагүй гэдгийг бид өмнө нь өгүүлсэн. Хэн нэгэн хүн аврагдах бүрд чуулган дээр нэг амьд чулуу нэмэгддэг. Уг барилга алх дөшний дуугүйгээр чимээгүйхэн өндөрссөөр, Ариун Сүнс өдөр бүр чуулган дээр аврагдсан хүмүүсийг нэмсээр байгаа ажээ (Үйлс 2:47).

Удахгүй, нэг л өдөр барилгын ажил дуусах болно.



Сүүлчийн чулуу нэмэгдэн тавигдахад Эзэн Есүс агаар мандалд гарч ирнэ. Тэнгэрлэг их соронзонд татагдах адил чуулган Аврагч Эзэнтэй уулзан золгохоор дээш өргөгдөөд дараа нь Аврагч Эзэнтэй хамт бүгд Эцэгийн гэрт байх олон өрөө рүү буцах болно. “...тийнхүү Эзэнтэй үргэлж хамт байх болно” (1 Тесалоник 4:17).

Есүс Христтэй үүрд хамт байх төдийгүй газар дээрх ажил үйлчлэлээрээ олж авсан Түүний суу алдрыг хуваалцан хүртэх нь чуулганы ерөөлт хувь юм (Иохан 17:22).

Чуулган нь өнө мөнхөд Бурханы суу алдрыг үүрд гэрчлэх заяатай аж. “Христ Есүс дотор бидэнд хандсан энэрлээр Өөрийн нигүүлслийн хэмжээлшгүй баялгийг ирэх үеүдэд үзүүлэхийн тулд юм” (Ефес 2:7).

Тэр болтол чуулган газар дээрх Бурханы шилдэг бүтээл буюу Бурханы олон янзын мэргэн ухааныг тэнгэрлэг газар дахь захирагчид болон эрх мэдэлтнүүдэд мэдүүлэх үзүүлэн таниулах материал байх болно (Ефес 3:10). Тиймээс итгэгч хүн бүр чуулганд маш их ач холбогдол өгөхийн зэрэгцээ чуулганыг өргөжүүлэн тэлж, сургаж боловсруулахыг итгэгч хүний үйлчлэлийнхээ эн тэргүүний зорилт болгох ёстой.

## ОРОН НУТГИЙН ЧУУЛГАН

### Орон нутгийн чуулган гэж юу вэ?

Бид өмнөх бүлгүүдэд даяар буюу бас “үл үзэгдэх чуулган”, “Христийн нууцархаг бие” гэгддэг чуулганы тухай ярилцсан.

Үүнээс гадна Шинэ Гэрээнд тухайн газар нутгийн итгэгч хүмүүсээс бүрдсэн орон нутгийн чуулганы тухай бас өгүүлдэг. Тиймээс ч, Иерусалим, Коринт, Ром зэрэг хот суурин газрууд дахь чуулган буюу цуглаануудын тухай бичсэн аж. Эдгээр чуулганууд тухайн орон нутаг дахь Бурханы чуулганы илэрхийлэл болж байжээ. Чуулган бүр өөр хоорондоо нөхөрлөж, бүгд Христийн удирдлаганд захирагддаг байсан ч тус бүрдээ бие даасан, бусад чуулгануудаас хараат бус оршин тогтнодог байв.

### 1. Орон нутгийн чуулганы тодорхойлолт

Шинэ Гэрээний чуулган чухам ямар байх ёстой талаар олон жилийн турш маргасаар ирсэн ба тодорхой шинж тэмдэг эсвэл хэдэн шаардлагуудыг жагсаагаад хэрэв хэсэг бүлэг итгэгч хүмүүс эдгээр шаардлагыг хангаж байвал тэднийг чуулган мөн хэмээн тооцсоор ирсэн ажээ.

1593 онд Хенри Берроу чуулганы нийтлэг тодорхойлолт ямар байж болох талаар өгүүлж “Жинхэнэ ёсоор, зөв зохистойгоор байгуулагдсан Христийн чуулган гэж өөрсдийн чин үнэнээр магтан хүндэлдэг, үгийг нь хэзээд дуулгавартай дагахад бэлэн байдаг Христийн нэрээр цугласан, итгэгч бус хүмүүсээс ангид, итгэмжит хүмүүсийн нөхөрлөл юм. Тэд бол ах дүүгийн барилдлагатай ариун хүмүүсийн нэгдэл бөгөөд хүн тус бүр өөрт нь Бурханы тушаасан бүрийг, Өөрийн Ариун Үгнээс илчлэн мэдүүлсэн бүхнийг юунд ч хүлэгдэхгүйгээр чөлөөтэй хэрэгжүүлэхийн төлөө бат зогсдог.” гэсэн байдаг.

Үүнээс илүү нарийн шаардлага бүхий өөр бусад тодорхойлолтууд гарч байсан ч эцэст нь аль нэг урсгал эсвэл бүлэг хүмүүс л зөвхөн тэдгээр шаардлагуудыг хангаж чадахаар болж байжээ.

## **2. Шинэ Гэрээний чиг шугам**

Эндээс нэг чухал асуулт урган гарч байна. Орон нутгийн чуулганд зайлшгүй шаардагдах наад захын зүйлсийг Шинэ Гэрээнд нэрлэсэн байдаг уу? Итгэгч хүн бүр Шинэ Гэрээний жинхэнэ чуулганыг хуурамч чуулганаас ялгаж чадахаар жинхэнэ чуулганы шинж тэмдгүүдийг нарийн өгүүлсэн байдаг уу?

Гол учир шалтгаан энэ биш гэж бодож байна. Жинхэнэ чуулганыг тодорхой хэв загвараар хэмждэг эсвэл тодорхой заасан цугларалтуудыг хийж байгаа эсэхээр хэмждэг бол чуулган ямар ч сүнслэг байдлын оролцоогүйгээр аяндаа шууд байгуулагдах байсан. Тэгвэл чуулган гэдэг сүнсээр үхмэл бардамнал зүйл болох байсан биз ээ. Ийм чуулганы байр суурь зөв байж болох ч итгэгчдийнх нь байр байдал эсрэгээр байх байсан.

Харин Шинэ Гэрээний чиг шугам ийм аж. Шинэ Гэрээнд итгэгч хүн бүр Бурханы нигүүлслээр даяар чуулганы гишүүн болдгийг итгэгч бүх хүнд сургадаг. Түүнээс гадна, итгэгч хүмүүс чуулганы агуу үнэнүүдийг илчлэн харуулахуйцаар хамтдаа цуглан чуулах ёстойг бүх итгэгчдэд уриалдаг. Зарим цуглаанууд Христийн биеийг төлөөлөхдөө муу байхад зарим цуглаан үүнийг илүү итгэмжтэйгээр илэрхийлдэг. Христийн биеийг төгс илэрхийлэн харуулж чадах чуулган гэж үгүй.

Тиймээс “Хэрэв та нар зарим нэг тодорхой шаардлагуудыг хангавал чуулган болж чадна” гэсэн ягшмал арга зүйг дагах хэрэггүй. Бичээсийн хэл бол нигүүлслийн хэл юм. Тухайлбал: “Чуулган бол итгэгч та бүхэн юм. Тиймээс энэ үнэнийг дэлхий ертөнцөд зөв илэрхийлэн харуулж чадахаар цуглагтүн”. Нигүүлслийн дор орших хүсэл эрмэлзлэлийн их хүч бол Аврагчийг хайрлах хайр бөгөөд энэ хайр бидэнд Христийн биеийн дүр зургийг эргэн тойрондоо зөв зохистойгоор харуулах хүсэл сэтгэлийг

төрүүлдэг.

### **3. Товч тойм**

Товчхондоо, орон нутгийн чуулган гэдэг даяар чуулганы нэг жижиг загвар байх ёстой. Христийн бие болсон чуулганы агуу үнэнүүдтэй зөрчилдөх ямар ч зүйлийг *хийдээгүй* байх ёстой. Самуел Ридаутын хэлсэнчлэн “Чуулганы мөн чанар хийгээд эв нэгдэл бүгдэд харагдаж, мэддэгдэг байх ёстой. Чуулган бол Христийн бие мөн, Ариун Сүнсээр бий болсон, Ариун Сүнсний оршдог газар, алдаршуулагдсан итгэгч хүн бүр гишүүн нь бөгөөд Христтэй болон нэг нэгэнтэйгээ эвлэлдэн нэгдсэн, Эзэний ирэлт итгэл найдвар нь болдог, Христийн нэр бол чуулганы цорын ганц нэр гэдэг нь бусдад харагддаг, мэдэгддэг байх ёстой. Цаашилбал, чуулган нь Христийн биеийн бодит үзмэр байх ёстой”

Тэгвэл, хэрэв орон нутгийн чуулган даяар чуулганы хэв загвар байх ёстой бол Христийн биеийн тухай агуу үнэнүүдийг ямар байдлаар, яаж гэрчлэх ёстой вэ? Бид үүнтэй холбоотой үндсэн долоон үнэнийг үзсэн. Эдгээр нь, чуулган бол:

- нэг бие юм.
- Христ бол тэргүүн нь юм.
- итгэгч бүх хүн гишүүд нь юм.
- чуулган дотор Христийг Ариун Сүнс төлөөлдөг.
- Бурханы чуулган ариун юм.
- чуулганыг босгон байгуулахын тулд сүнслэг бэлгүүд өгөгддөг.
- итгэгч бүх хүн Бурханы тахилч гэсэн үнэнүүд юм.

Тиймээс, эдгээр үнэнийг нэг нэгээр нь авч үзэн орон нутгийн чуулганууд эдгээрийг дэлхий ертөнцөд чухам яаж харуулах ёстойг тогтоон шийдэх нь бидний одоогийн зорилго болж байна.

### **Нэг бие гэсэн үнэн**

Орон нутгийн чуулганы гэрчлэн харуулахад анхаарах ёстой эхний үнэн бол нэг л бие байдаг гэсэн үнэн юм. Тэгвэл

энэ үнэнийг итгэгч хүмүүс яаж харуулах вэ?

### **1. Ямар нэртэй байх вэ?**

Чуулганд түүнийг бусад итгэгч хүмүүсээс салгаж тусгаарлахааргүй нэр авч ашиглах нь юуны өмнө чухал гэдэг нь мэдээж. Коринт хотын чуулганы зарим хүн “Би Паулынх”, “Би Аполынх” эсвэл “Би Христийнх” гэцгээдэг байсан. Паул ийм байдлыг эсэргүүцэн дургүйцэж “Христ хуваагдсан гэж үү?” хэмээн зэмлэсэн байдаг (1 Коринт 1:10-17).

Өнөө үед итгэгчид улс орон, шашны тэргүүнүүд, зан үйл эсвэл чуулганы засаглалын хэлбэр зэргээр нэрлэсэн урсгалуудад хуваагддаг болсон. Энэ бүхэн Христийн биеийн нэгдмэл байдлыг илт үгүйсгэж буй хэрэг юм.

Библид Бурханы хүүхдүүдийг ерөнхийд нь “итгэгчид” (Үйлс 5:14), “дагалдагчид” (Үйлс 9:1), “ариун хүмүүс” (Ефес 1:1), мөн “ах дүүс” (Иаков 2:1) гэж нэрлэсэн байдаг. Энгийн нэг итгэгч хүн гэхээс өөр нэр зүүхгүй амьдарна гэдэг зарим итгэгч хүнд хамгийн хэцүү даалгавар байж магадгүй. Итгэгч хүмүүсийн ихэнх нь өнөөдөр ямар нэгэн зохион байгуулалттай чуулганд харъяалагдаж Библид өгөгдсөн нэрсээс өөр нэр зүүх ёстой гэж боддог. Бурханы хүүхэд гэдгээс өөр нэр зүүхээс татгалзсан хүмүүс бусад итгэгчдээс хүртэл зэмлэл хүртэж итгэгчдийн дунд үл ойлгогдох хүн болж хувирдаг.

Зөвхөн Бичээсийн дагуу зөв нэрээр нэрлэгдэх нь мэдээж хангалтгүй. Библийн хэллэгийг тууштай чанд хэрэглэх боловч сүнсээрээ хэт явцуурхдаг байж болох талтай. Жишээ нь: Коринт хотын зарим итгэгчид өөрсдийгөө “Би Христийнх” гэж байсан. Тэд зөв нэр зүүсэндээ бардамнадаг байсан байж болох ч үнэндээ бол тэд бусад жинхэнэ итгэгчдийг оруулахгүйгээр зөвхөн өөрсдийгөө Христийнх гэсэн хэрэг байлаа. Паул өөрт нь болон мөн Аполд үнэнч байсан хүмүүсийг буруутгасны адил тэднийг ч бас буруутгасан юм.

## 2. Тэгвэл урсгалуудыг юу гэх вэ?

Салбар урсгал чиглэлүүдийг Бичээсийн дагуу зүйл мөн үү гэсэн эргэлзээ төрүүлсэн асуулт гарч ирэхэд Эзэн Есүс итгэгчдийн тодорхой нэг хэсгийг илүү их адисласан гэх эсэргүүцэл ирдэг. Энэ үнэн гэдгийг хүлээн зөвшөөрөх ёстой ч Эзэний адислал бүх зүйлийг сайшаан зөвшөөрч буй тэнгэрлэг сайшаалтын илэрхийлэл биш гэдгийг бид мартаж болохгүй. Хэдийгээр Эзэний Үгийг тараах үйлс алдаа мадагтай, дутагдалтай хийгддэг ч Эзэн Өөрийн Үгийг эрхэмлэн дээдэлдэг. Хэрэв Эзэн Бурхан төгс төгөлдөр зүйл оршин байгаа газрыг л ивээн адисладаг бол ямар ч ивээл адислал гэж байхгүй байсан биз ээ. Тиймээс, Эзэний гараар адислагдсан бүлэг хүмүүс байлаа гэхэд Эзэн тэдний хийж буй бүх зүйлийг адисласан гэсэн үг биш юм. Үгийг дамжуулагчаас дамжин ирж буй үг нь илүү агуу билээ.

Чуулганы хуваагдалд Эзэн хэрхэн ханддагийг 1 Коринт 3:4-өөс тодорхой харж болно. *“Учир нь нэг нь “Би Паулынх” гэхэд, нөгөө нь “Би Аполлынх” гэж буй та нар тийм хүмүүс (махан биеийн дагуу) биш үү?”*(Галат 2:11-15 ).

Чуулган дотроо хагарч хуваагдах нь ихээхэн хорон муу зүйлийг дагуулдаг. Энэ нь чуулганы нөхөрлөлд хиймэл саад бэрхшээлийг бий болгодог. Мөн сүнслэг авъяас бэлэгтэй хүмүүсийн үйл хөдлөлийг хязгаарлаж чуулганы бүх хүнд хүрч болох байсан тэдний үйлчлэлийг цөөхөн хүнээр хязгаарладаг (3 Иохан 9-10). Бас “Аль чуулган нь зөв юм бэ?” гэсэн асуултыг итгэгч бус хүмүүст төрүүлж тэднийг будлиулдаг (2 Петр 2:2).

Маркус Рэйнсфорд “Итгэгчдийн төлөө залбирах Эзэний залбирал” гэдэг өөрийн бичсэн алдартай номондоо: “Миний хувьд шашны янз бүрийн бүлэглэл ба урсгалууд бол Бурханы чуулганы ил харагдаж буй эв нэгдлийг болж өгвөл их сэвтүүлэх, түүнд аль болох ихээр саад болох гэсэн муу ёрын сүнсний оролдлогын үр дагавар гэж боддог бөгөөд эдгээр нь бидний сүнслэг бардамнал, хувиа хичээсэн зан, ихэрхэг байдал, гэм нүгэл дээр үндэслэсэн байдаг.

“Эзэн Бурхан биднийг өршөөж, хагарал хуваагдлыг маань

засаж залруулах болтугай! Гадаад ертөнцөд итгэгч хүмүүсийн хоорондын ялгаанаас илүү их далим өгдөг зүйл гэж байхгүй. Бурханы ил чуулганы бүлэглэл ба урсгалуудад харъяалагддаг эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн хоорондын хэрүүл маргаан дэлхий ертөнцөд хамгийн их саад болдог зүйл байсаар ирсэн. Тэд итгэгч хүмүүсийг ажиглан харж, “Хараач, тэд нэг нэгнээ хичнээн их хайрлана вэ” гэхийн оронд “Тэд нэг нэгнээ яаж гоочлохыг хараач, нэг нэгнээ яаж шүүж байгааг, яаж хорлож байгааг хар даа” гэдэг” гэжээ.

### **3. Жинхэнэ эв нэгдэл**

Христийн биеийн эв нэгдлийг гэрчлэн харуулахаар шийдсэн итгэгч хүмүүс чуулганы хуваагдлаас хол байхын хажуугаар Бурханы бүх хүүхдийг жигд хайрлах сэтгэлээ хадгална гэдэг хэцүү.

“Notes on Pentateuch” номын зохиолч К. Макинтош ийн бичиж байжээ: “Хамгийн ярвигтай зүйл бол тусгаар байдлыг нигүүлсэл, номхон дөлгөөн зан ба хүлцэнгүй байдлуудтай хослуулах явдал буюу өөр хэн нэгний хэлсэнчлэн “уудам сэтгэлийг жижиг хүрээнд байлгах” явдал юм. Энэ бол үнэхээр хэцүү хэрэг. Үнэн нь хичнээн хатуу, гуйвшгүй байх тусам биднийг тойрсон хүрээ улам жижиг болж багасах хандлагатай болдог ба уужим сэтгэл, халуун хайрыг хэвээр хадгалахын тулд бидэнд нигүүлслийн асар их хүч хэрэгтэй болдог. Бид үнэний төлөө тэмцэх хэдий ч нигүүлсэх сэтгэлийг үл харуулах аваас бидний гэрчлэл хэт нэг талыг барьсан, сонирхол татахааргүй зүйл байх болно. Харин үнэнийг золиослон байж нигүүлслэх сэтгэлийг харуулахыг хичээвэл энэ нь эцэстээ, ямар ч үнэ цэнэгүй зүйл болж хувирдаг алдартай дур зоргоор авирлах явдлын илэрхийлэл болно.”

Энэ тухай В. Гриффит Томас “Үйлчлэлийн ажил ба амьдрал” номондоо ийнхүү бичжээ: “Гол зарчмууд нь гуйвшгүй, тэнгэрлэг үнэн дээр бат суурилагдах ёстой ч Христийн төлөө хичээнгүйлэн амьдарч, хөдөлмөрлөж байгаа хүмүүст хайр энэрэлийг аль болох өргөн хүрээгээр хүртээх ёстой. Индианчуудын дунд нэг ёсны элч гэгдэж байсан Миннесотын ариун гэгээнтэн ахлагч Випплийн

хэлсэн үгийг би мартаж чаддаггүй юм. Тэрээр “Би гучин жилийн турш өөрөөсөө ондоо хүмүүсийн нүүрнээс Христийн дүрийг олж харахыг хичээж байна” гэсэн юм.”

Христийн биеийн эв нэгдлийн бодит илэрхийлэл өнөө үед олонтаа сонсогдох болсон дэлхийн хэмжээний янз бүрийн хөдөлгөөнүүдээс харагдах ёсгүй. Иймэрхүү нэгдэл, холбоо зөвлөл зэрэг нь Бичээсийн агуу үнэнүүдээс ухарч буулт хийх тохиолдолд л амжилт олдог. Христ онгон эмэгтэйгээс төрсөн, хүн биеэр гэм зэмгүй амьдарсан, бусдын төлөө өөрийгөө золиослон үхсэн, махан биеэр үхлээс амилсан, тэнгэрт өргөгдөн өргөмжлөгдсөн мөн дахин буцаж ирнэ гэсэн үнэнүүдийг няцаадаг хүмүүстэй нэгдсэн итгэгчдийн цуглаан Аврагч Эзэнээ үгүйсгэж буй хэрэг юм.

Христэд итгэгчдийн нэгдлийн жинхэнэ үндэс суурь бол Христ болон Түүний Үгэнд өөрсдийгөө зориулах нийтлэг зориулалт юм. Түүнийг алдаршуулах нь бидний зүрх сэтгэлийн агуу их хүсэл байх ёстой. Тэгвэл бид хамтдаа нийлэн нэгдэж, тэгвэл Түүний залбирал биелэх болно: “*Бид нэг байдгийн адил тэднийг нэг байлгахын тулд...*” (Иохан 17:22). Гриффит Томасын хэлсэнчлэн “Христэд итгэгчдийн нэгдлийг далайн түрлэгтэй заримдаа зүйрлэсэн байдаг. Далайн түрлэгний дараа эрэг дээр ус их хэмжээний элсээр тусгаарлагдан энд тэнд тогтож үлддэг. Маш хүчтэй түрлэг хуйлран орж ирээд бүгдийг нь нөмрөн авах үед энд тэнд тогтсон ус хоорондоо нийлдэг. Бидний зүрх сэтгэлийн тусгаарлалт буюу золгүй хуваагдал ч бас ийм байх ёстой бөгөөд ийм ч байх болно. Эзэн Бурханы хайрын агуу их түрлэг итгэгч хүн бүрийн амьдрал уруу гүн нэвтрэн ороход хайрын гүн их далайгаас бид тэнгэрлэг хайр, баяр хөөр ба амар тайвны шилдэг хэлбэрийг мөнхөд ойлгож мэдэх болно.”

Тэр болтол орон нутгийн чуулганууд Христэд ертөнцийн ихэнх хэсгийн харуулж чаддаггүй Христийн биеийн эв нэгдлийг гэрчлэн харуулахад анхаарах ёстой. Ингэхдээ итгэгч бүх хүн сүнс, зарчим ба үйл хэргээрээ нэг гэдгийг хүлээн зөвшөөрснөөр Христийн биеийн эв нэгдлийг гэрчлэн харуулж чадна.



## ХРИСТИЙН ТЭРГҮҮЛЭЛ

### **Христ бол тэргүүн юм**

Христ бол биеийн тэргүүн юм. Орон нутгийн чуулганы гэрчлэн харуулах ёстой хоёр дахь үнэн бол энэ. Үүнийг өнөөдөр итгэгч хүмүүс чухам яаж гэрчлэн харуулах вэ? Юутай ч хэн нэгэн хүнийг чуулганы тэргүүн мөн хэмээн хүлээн зөвшөөрөх ёсгүй нь мэдээж. Энэ үнэнийг илт гуйвуулдаг нэг хэлбэр бол өөрийгөө газар дээрх Христийн биеийн түр зуурын тэргүүн хэмээн мэдэгддэг шашны томоохон тогтолцооны тэргүүнүүд юм. Ихэнх итгэгчид энэ санаархал хичнээн мунхаг болохыг харж мэддэг ч, Христ итгэлт ертөнцийн бараг хэсэг тус бүрд хорон муугийн хүү зальжин аргаар нэвтрэн орсон байдаг аж.

Есүс Христ бол чуулганы тэргүүн мөн гэдгийг харуулахын тулд чуулганы үйл ажиллагаануудыг удирдах, шийдвэр гаргахад нөлөөлөх, чуулганы бусад бүх жижиг үйл ажиллагаанд оролцох боломжийг Түүнд олгох ёстой. Энэ санаа олон хүнд бүрхэг, бодит амьдралаас хол зүйл мэт санагддаг. Тэнгэрт байгаа Эзэн газар дээрх чуулганыг яаж удирдах билээ? Үүнд өгөх хариулт амархан. Өөрийнх нь хүсэл юу болохыг мэдэх хүсэлтэй, түүнийг нь тэвчээртэй хүлээж чаддаг хүмүүст Эзэн Есүс хүслээ тодорхой мэдүүлж өгдөг. Итгэгчдийн зүгээс Түүний хүслийг мэдэхийн тулд сүнслэг байдлаа маш ихээр хадгалах хэрэгтэй болдог нь үнэн. Аливаа хэргийг өөрийн гарт авч, өөрөө төлөвлөгөө зохиох нь илүү хялбар байх нь мэдээж. Гэвч Шинэ Гэрээний зарчмуудыг Шинэ Гэрээний хүчээр хэрэгжүүлэх ёстой гэдгийг санах нь зүйтэй бөгөөд хамааралтай байдал, залбирал болон тэвчээрээр хүлээх хүсэлгүй хүмүүст чуулганы агуу Тэргүүн энэ газар дээр орон нутгийн чуулгануудыг хэрхэн удирдан чиглүүлж буйг харах завшаан хэзээ ч олдохгүй.

Тиймээс, Христийн удирдлагад амаараа үйлчлэх нэг

хэрэг харин үүнийг бодит амьдрал дээр хүлээн зөвшөөрнө гэдэг тэс өөр хэрэг гэдгийг энд онцлон тэмдэглэх нь зүйтэй болов уу. Христ бол чуулганы тэргүүн мөн гэсэн үнэний төлөө амиа өгөхөөс ч буцахгүй мэт боловч цуглаан дотор жинхэнэ дарангуйлагч мэт авирлаж энэхүү үнэнийг бодит амьдрал дээрээ үгүйсгэдэг хүмүүс бий. Чуулган дотор албан ёсны цол хэргэмгүй боловч хатуу ширүүнээр захиран ноёрхдог нэг буюу хэсэг бүлэг хүмүүс байх нь ч бий. Диотреф чухамдаа ийм хүн байсан (3 Иохан 9-10). Тэрээр нэр хүндэд шунадаг нэгэн байв. Иохан шиг бурханлаг хүмүүсийг балмад үгээр, зүй бусаар буруутгадаг, бүрханлаг хүмүүсийг хүлээн авдаггүй, хүлээн авахыг хүсэгчдэд хориглодог, тэднийг чуулганаас хөөдөг байсан. Энэ бол Христийг чуулганы тэргүүн мөн гэсэн үнэнийг илт үгүйсгэж буй хэрэг юм.

Чуулганы удирдлагын зөвлөлийн талаар хэдэн үг нэмж хэлэх хэрэгтэй болов уу. Удирдлагын зөвлөл гэж үйл ажиллагаа ба эрх мэдлийн төв гэсэн үг юм. Чуулганы удирдлагын зөвлөл Тэргүүн нь заларч буй газарт буюу тэнгэрт байдаг. Орон нутгийн чуулган нь ганц буюу хэсэг бүлэг цуглаануудыг хянан удирддаг зөвлөл, хороо эсвэл санваартнууд гэх мэт хянан удирдах байгууллагын хараанд байнга байх ёсгүй. Цуглаан тус бүр шууд чуулганы Тэргүүний өмнө хариуцлага хүлээхийн зэрэгцээ энэхүү үнэнийг үгүйсгэдэггүй, үгүйсгэх зүйл ч хийдэггүй байх ёстой.

### **Итгэгчдийг хүлээн авах бодлого**

Итгэгч бүх хүн чуулган буюу Христийн биеийн гишүүн юм. Энэ бол өмнө заасанчлан чуулгантай холбоотой гурав дахь үнэн. Үүнийг алдаа мадаггүй, үнэнч итгэлтэйгээр илэрхийлэн харуулах нь цуглаануудын үүрэг. Цуглааны заадаг зүйлс, хийдэг ажлын аль нь ч Христ итгэлт бүх хүний нэгдмэл нэг байдлыг үгүйсгэх ёсгүй. Орон нутгийн чуулган үүнийг хэрхэн хэрэгжүүлж буйг мэдэхийн тулд бусад итгэгчдийг чуулганахаа нөхөрлөлд хүлээн авах ямар бодлого баримталдагийг харахад болно. Үүнийг ерөнхийд нь итгэгчдийг хүлээн авах бодлого гэдэг ба уг бодлогын журам тодорхой ажээ.

## **1. Ерөнхий журам**

Цуглаан нь Христийн хүлээн авсан бүх хүнийг хүлээн авах ёстой. Энэ бол ерөнхий журам. *“Тиймээс мөн Христ та нарыг Бурханы алдрын төлөө хүлээн авсны адил бие биеэ хүлээж авагтун”* (Ром 15:7). Тухайн хүнийг Христийн бие хэдийнээ хүлээн авсан гэсэн бодит үнэн чуулганы жинхэнэ нөхөрлөлд багтах үндэс болдог. Орон нутгийн чуулган түүнийг өөрийнхөө дунд урин оруулж байгаа нь зүгээр л дээрх бодит үнэнийг амьдрал дээр илэрхийлэн харуулж буй хэрэг юм.

## **2. Журманд үл захирагдах зүйлс**

Гэвч энэ журманд захирагдахгүй зүйлс гэж бас бий. Шинэ Гэрээний сургаалын цаана гурван төрлийн нэмэлт шаардлага агуулагдсан байдаг. Чуулганы нөхөрлөлд хүлээн авагдах хүн ариун амьдралаар амьдардаг байх ёстой (1 Коринт 5:11,10:21). Шалиг завхай, шунахай, хуурамч, шүтээн шүтэгч, архичин эсвэл хахууль авагч гэх мэт хүмүүсийг хүлээн авах тохиолдолд чуулганы ариун байдалд муугаар нөлөөлөх нь мэдээж. Үүний зэрэгцээ, тухайн цаг үед орон нутгийн өөр чуулганаас шийтгэл хүртсэн хүнийг хүлээн авах нь нэн зохисгүй аж (1 Коринт 5:13). Ингэх нь Христийн биеийн нэгдмэл байдлыг эвдсэн хэрэг болно (Ефес 4:4). Чуулганаас хөөгдсөн хүний Эзэнтэй болон Түүний хүмүүстэй нөхөрлөх нөхөрлөл сэргээгдэх хүртэл түүнийг харь үндэстэн, татвар хураагч хэмээн тооцох ёстой (Матай 18:17).

Эцэст нь, тухайн хүн Христийн сургаалд туйлбартай байх ёстой (2 Иохан 10) *“Хэрэв хэн нэгэн нь та нар уруу ирэхдээ энэ сургаалыг авчрахгүй бол, түүнийг гэртээ бүү оруул. Түүнтэй мэндэлж болохгүй”* Тэгвэл Христийн сургаал гэж чухам юу вэ, үүнд юу багтах вэ гэсэн асуулт гарч ирнэ. Дээрх ишлэлд энэ санааг тайлбарлаагүй боловч Христийн сургаал гэдэгт Түүний хүн бие болон ажил үйлс тухайлбал, Түүний тэнгэрлэг чанар, онгон эмэгтэйгээс төрсөн төрөлт, гэм нүгэлгүй амьдрал, бусдын өмнөөс өөрийгөө золиосолсон үхэл, оршуулалт, амилалт, өргөмжлөл ба дахин ирэлттэй холбоотой агуу үнэнүүд багтана.

Энэ бүхнийг эцэст нь товчлон дүгнэвэл, орон нутгийн чуулган нь ариун амьдралаар амьдардаг, бусад цуглаанаас хөөгдөөгүй, сургаал номлолд туйлбартай, сүнсээр дахин төрсөн итгэгч бүх хүнийг өөрийн чуулганы нөхөрлөлд хүлээн авах ёстой ажээ.

### **3. Бусад заавар**

Итгэгч хүнийг чуулганы нөхөрлөлд хүлээн авахтай холбоотой өөр зааврууд бас Бичээсүүдэд бий. Орон нутгийн цуглаан нь:

- Итгэлээр сул хүнийг хүлээн авах ёстой (Ром 14:1). Үүнд, хэт ёсорхог хүмүүс багтана. Жишээлбэл, цагаан хоолтон хүн үүнээсээ болоод хасагдах ёсгүй.
- Аливаа хүнийг алагчилж ялгаварлахгүйгээр хүлээн авах ёстой (Иаков 2:1-5). Библид баян хүнд онцгой хүндэтгэл үзүүлж, ядуу хүнийг гадуурхахгүй байхыг сануулдаг. Энэ нь мөн яс үндэс, нийгмийн байдал ба ёс заншилд хамаарна. Ялгаварлан гадуурхах үзэл бол Христэд үзэл биш юм.
- Аливаа хүний мэдлэгийг биш харин амьдралыг харж хүлээн авах ёстой (Үйлс 9:26-38). Итгэгчдийн нөхөрлөл хувь хүний мэдлэгээс биш харин түүний мэддэг Хүнээс хамаарах ёстой. Тиймээс ч, хэдийгээр Аполын мэдлэг дутагдалтай байсан ч түүнийг Ефесийн чуулган хүлээн авсан юм (Үйлс 18:24-28).
- Аливаа хүнийг зан үйл сахисан эсэхийг биш харин амьдралыг нь харж хүлээн авах ёстой. Баптисмыг цуглаанд орох үүд хаалга гэж хэлсэн зүйл хаана ч байхгүй. Хэдийгээр итгэгч бүх хүн баптисм хүртэх ёстой нь үнэн боловч (Матай 28:19) чуулганы нөхөрлөлд орохын тулд баптисм хүртэх ёстой гэвэл Үгээс зөрсөн хэрэг болно.
- Аливаа хүний хийсэн үйлчлэлийг биш харин амьдралыг харж хүлээн авах ёстой. Христ итгэлт үйлчлэлийн цар

хүрээний талаар санал нийлэхгүй байна гэдэг тухайн хүнийг орон нутгийн чуулганы нөхөрлөлд хүлээн авахгүй байх шалтаг болох ёсгүй. Самаричууд Эзэн Есүсийг Иерусалим уруу явж байгааг мэдсэн учир хүлээн аваагүй тухай Лук 9:53-т өгүүлсэн байдаг. Тэд тэнгэрлэг зарчмыг биш харин шашны сект үзлийг үндэслэл болгосон ажээ.

- Аливаа хүнийг аврагдахаасаа өмнө ямар хүн байснаас үл хамааран хүлээн авах ёстой. Элч Паул өмнө нь итгэгчдийг хавчин гадуурхагч байсан боловч чуулган түүнийг өнгөрсөн явдлаас нь үл хамааран хүлээн авсан (Үйлс 9:27-28). Онесим гэгч эр урд нь хулгайч байсан боловч Паул түүнийг хүлээн авахыг Филимонд уриалсан байдаг (Филимон 12,15,17). Хэрэв цуглаан өмнө нь архичин, луйварчин, нийгмээс гадуурхагддаг байсан итгэгч хүмүүсийн өмнө хаалгаа хаавал өөрийн жинхэнэ мөн чанарыг гэж зүгээр л нэг олон нийтийн клуб болох болно.
- Итгэгчдийг баяр хөөртэйгөөр Эзэн дотор хүлээн авах ёстой (Филиппой 2:29). Христийн биеийн хамгийн сул дорой нэгэнд бид яаж хандана Эзэнд Өөрт нь тэгж хандана. *“Үнэнээр Би та нарт хэлье. Та нар эдгээр ах дүүсийн маань нэгэнд нь, тэр байтугай хамгийн дордод нь тийнхүү хандсан бол Надад хийсэн хэрэг”* (Матай 25:40).

#### **4. Тухайн хүн аврагдсан эсэхийг яаж мэдэх вэ?**

Эндээс “Тухайн хүн аврагдсан эсэхийг, чуулганы нөхөрлөлд орох эрхтэй эсэхийг цуглаан яаж мэдэх вэ?” гэсэн асуулт гарч ирнэ. Үүнийг мэдэж болох наад тал нь таван арга бий.

Нэгдүгээрт, тодорхойлолт хэрэглэж болно (Ром 16:1). Нэг цуглаанаас нөгөө цуглаан руу шилжиж буй хүн өөрийнх нь итгэл ба сүнслэг амьдралыг гэрчилсэн тодорхойлолтыг өөрийн хуучин цуглаанаас гаргуулан авч явбал гарч болзошгүй хүндрэл ба эвгүй байдлаас зайлсхийж чадна.

Хоёрдугаарт, хоёр буюу гурван гэрчийн гэрчлэлээр хүлээн авч болно (Матай 18:16). Тухайн хүнийг тэр орон нутгийн чуулганы хоёр буюу гурван хүн таньдаг бол түүнийг тэдний зөвлөмжөөр чуулган хүлээн авч болох талтай.

Ганц хүний гэрчлэлээр, гэхдээ тэр хүн цуглааны итгэлийг олсон хүн бол хүлээн авч бас болно. Элч Паул Ромын ариун хүмүүст Фойбег (Ром 16:1), Филиппойн чуулганд Епафродитыг (Филиппой 2:28-30) хүлээн авахыг зөвлөж байсан.

Христийн зарцын тухайд ямар нэр хүндтэй байх нь бас ач холбогдолтой (2 Коринт 3:1-2). Элч Паул Коринт хотын чуулганд Эзэн Есүсийн элч гэдгээрээ алдартай байсан тул тэр чуулган түүнээс тодорхойлолт нэхэх шаардлагагүй байсан.

Цуглаан өөрөө сайн асуун шалгааж, нягтлан шалгаж болох талтай. Энэ тохиолдолд цуглаан, магадгүй ахлагчдаараа дамжуулан тухайн хүний Христ доторхи итгэлийн талаар лавлан, өөрт нь байгаа итгэл найдвар юун дээр үндэслэгдсэнийг асууж болох юм (1 Петр 3:15). Ингээд, түүнийг үнэхээр Христийнх мөн гэдэг нь үндэслэлтэйгээр батлагдсаны дараа чуулгандаа хүлээн авч болно.

## **5. Нийтлэг бэрхшээл**

Хүлээн авалтын тухай өгүүлсэн энэ бүлгийг дуусгахийн өмнө энэ сэдэвтэй холбоотойгоор урган гардаг нийтлэг өөр гурван асуултыг авч үзэцгээе.

Аливаа хүн аврагдсан эсэхийг шүүх эрх чуулганд бий юу? Энэ бол чуулганы зөвхөн эрх ч биш бас ариун үүрэг юм. Христ итгэлт хүмүүсийг үл итгэгч хүмүүстэй нэг буулганд орж болохгүй гэсэн байдаг (2 Коринт 6:14,17). Тиймээс Бурханы хүмүүсийн дүнд орохыг хүсэж буй хүний сүнслэг байдлыг ухаалаг арга замаар олж мэдэхийг тэднээс хүсэх нь зүй зохистой ажээ.

Чуулганы хүлээн авсан хүн чуулганд удаа дараа алдаатай буруу зүйл зааж сургавал яах вэ? Тэгвэл түүний заасан

зүйлсийг Бурханы Үгээр олны өмнө няцаах ёстой (1 Тимот 5:20). Шинэ Гэрээний чуулган нээлттэй Библийн хүрээнд л үйл ажиллагаагаа явуулж чадна. Чуулган алдааг илрүүлж, итгэлийг хамгаалах чадвартай бурханлаг ахлагчидтай байх ёстой (Тит 1:9).

Чуулганы хүлээн авсан хүн дараа нь цуглаанд тогтмол бус оролцох эсвэл огт ирэхгүй байвал яах вэ? Юуны өмнө, нөхөрлөл нь нийтлэг нэг зүйлийг хуваалцахыг хэлнэ гэдгийг тодорхой хэлж ойлгуулах ёстой. Чуулганы нөхөрлөлд орсон хүн цуглааны амьдралд нэвтрэн орж, үүрэг хариуцлагын ачаанаас үүрэлцэж, ажил үйлсэд хамрагдан оролцох ёстой. Хатуухан хэлэхэд, хэрэв тухайн хүн долоо хоногт ганц удаа үйлчлэлд оролцдог бол үнэндээ чуулганы нөхөрлөлд ороогүй хэрэг. Чуулганаар хүлээн авагдсан боловч ганц ч удаа чуулганд буцаж ирээгүй хүний хувьд тэр хүн өөрөө хариуцлага хүлээнэ. Чуулганы тухайд түүнд өөрийн итгэмжит болон сүнслэг байдлуудыг харуулах үүрэгтэй харин тухайн хүн үнэнд дуулгавартай захирагдах үүрэгтэй.

Хүлээн авалтын тухай энэ сэдэв нилээн ярвигтай зүйл бөгөөд бид зөвхөн илүү чухал зарим хэсгүүдийг л хөндөн ярилцлаа.

## ЧУУЛГАН ДАХЬ АРИУН СҮНС

Ариун Сүнс чуулганд Христийг төлөөлдөг гэсэн амин чухал үнэнийг орон нутгийн чуулган өөрийн мөрдөж буй дүрэм журам, үйлдэж буй ажил үйлсээр байнга батлан харуулах ёстой. Өнгөц харахад уг бодит үнэн, өмнө та бидний ярилцсан Христ бол чуулганы Тэргүүн мөн гэсэн номлолтой зөрчилдөх мэт ажээ. Гэвч аль аль нь үнэн юм. Христ нь чуулганы Тэргүүн мөн. Харин Ариун Сүнсийг газар дээр Өөрийг нь төлөөлөх Төлөөлөгч болгон томилсон аж. Тиймээс, Бурханы Сүнсэнд зүй ёсных нь байр суурийг тавьж өгөх нь орон нутгийн чуулганы үүрэг.

### **Бодит удирдлага (Үйлс 13:1-4)**

Цуглаан нь, олон нийтэд гэрчлэл хийх газраа сонгох, хурал цуглаан зохион байгуулах, Бурханы Үгийг хүмүүний ямар арга хэрэгслээр дамжуулахаа олж тогтоох, чуулганы сан хөмрөгийн зарцуулалт эсвэл бурханлаг сахилгажуулалт зэрэг бүх төрлийн ажил хэрэгтээ Ариун Сүнсний удирдлагыг хайх ёстой.

### **Ариун Сүнс бол хэмжээлшгүй эрх мэдэлтэй юм (1 Коринт 12:11)**

Орон нутгийн чуулган Ариун Сүнс хэмжээлшгүй эрх мэдэлтэй гэдгийг ойлгон хүлээн зөвшөөрөх ёстой. Энэ бол, Ариун Сүнс Өөрийн хүссэн зүйлийг хийж чадна, хэдийгээр Бурханы Үгтэй зөрчилдөх зүйл хэзээ ч хийхгүй боловч бүх зүйлийг үргэлж ганц арга замаар хийдэггүй гэсэн үг юм. Бичээсүүдэд Ариун Сүнсийг гал, тос, ус, салхи гэсэн үгээр дүрсэлдэг ба эдгээр үг нь байнгын хөдөлгөөнд оршдог, урьдчилан таамаглах аргагүй зүйлсийн илэрхийлэл ажээ. Тиймээс ухаалаг итгэгч хүн Ариун Сүнсэнд энэ тэнгэрлэг онцгой эрхийнхээ дагуу ажиллах боломж олгож чадахаар уян хатан байж чаддаг байх ёстой.



Эртний чуулганд байдал ийм л байсан боловч аажимдаа хүмүүс албаны бус энгийн чөлөөтэй цугларалтуудад тааламжгүй хандах болсон. Тиймээс янз бүрийн хяналтуудыг нэмж, албан ёсны зан үйл зэргийг хэрэгжүүлэх болжээ. Үүний дүнд Ариун Сүнс бөхөж, чуулган хүч чадлаа алдах болов.

### **Сүнсийг бөхөөх нь (1 Тесалоник 5:19)**

Ариун Сүнсний эрх чөлөөнөөс хүмүүний удирдлагад шилжсэн энэ шилжилтийг Жэймс Денни уран үгээр дүрслэн өгүүлсэн байдаг. Эрхэм Деннигийн бичсэн энэ нийтлэл судалгааны сайн материал болж чадахыг уншигч та олж мэдэх болно. “Сүнсийг бүү бөхөө” (1 Тесалоник 5:19) гэсэн энэ ишлэлтэй холбогдуулан Денни ийн бичжээ:

“Пентекостын өдөр чуулганд Ариун Сүнс анх бууж ирэх үед тэнд байсан хүн бүрийн дээр хэлүүд тус тусдаа үзэгдэн, тэнд байсан хүмүүсийн ам Бурханы хүчирхэг үйлсийг тунхаглан ярихаар нээгдсэн юм. Энэхүү агуу бэлгийг хүлээн авсан хүнийг гал цогтой гэж, шууд утгаараа Сүнсээр буцалсан хүн хэмээн дүрсэлсэн байдаг. Эртний тэр өдрүүдийн энэхүү шинэ төрөлт үнэхээр шинэ төрөлт байсан ба хүмүүний сүнс, оюун бодол болон сэтгэл санаанд дүрэлзэн ассан нь өнөөг хүртэл тун хачирхалтай зүйл байсаар ирсэн. Энэ нь шинэ хүчүүдийг мэдрэх мэдрэмж, Бурханы тухай шинэ зөн хараа, шинэ ариун хайр, Ариун Бичээсийг ойлгох шинэ ойлголт, хүний амьдралын шинэ утга учир, мөн заримдаа аагтай, оргилуун ярианы шинэ эрч хүч зэргийг авчирсан юм.

Элч Паул Коринт хотын итгэгчдэд хандан бичсэн анхныхаа захидалд анхны итгэгчдийн цуглаан ямар байсныг дүрсэлжээ. Тэдний дунд амаа хамхисан хүн ганц ч байгаагүй. Хамтдаа цуглан нийлэх үед хүн бүрт дуулал, илчлэл, зөгнөл, тайлбар өгөгддөг байсан. Ариун Сүнс хүн бүрт илэрхийлэгдэж, хүн бүр сүнсээр дүрэлзэн асахад бэлэн байв. Тэр үед Христэд итгэгч болно, элч нарын сайн мэдээг хүлээн авна гэдэг жижиг зүйл байгаагүй. Тэдний төрөлх бүх мөн чанарыг орвонгоор нь эргүүлсэн зүйл байсан ба тэд тэр чигээрээ өөрчлөгдөж, бүгд бадрангуй

сэтгэлийн гал дөлтэй, шинэ амьтай, шинэ бүтээл болж байсан.

“Хүний төрөлх мөн чанартай огт адилгүй энэ байдал таагүй байдал үүсгэх нь дамжиггүй. Итгэгч хүн хэдийгээр Ариун Сүнсний бэлгийг хүлээн авсан ч хүн хэвээрээ байхын зэрэгцээ эгэл хүнтэй адилгүйгээр янз бүрийн дэмий хоосон, мунхаг, хувиа хичээсэн, нэр төр хөөсөн зүйлстэй тэмцэлдэх ёстой болж байв. Түүний урам зориг эхэндээ төрөлхийн алдаа дутагдлыг нь арилгахын оронд улам дордуулах мэт харагдуулж болох байлаа. Эхэн үеийн чуулганд хүн бүрд үг хэлэх эрх байсан бөгөөд дуугүй байх нь зарим үед илүү дээр байвч энэ нь тухайн хүнийг ярихаас өөр аргагүй байдалд хүргэдэг байжээ. Мөн түүнчлэн, ухаант нэгнийг гүн санаа алдуулахад хүргэхээр магтаал хүндэтгэл, залбирал, уриалга зэргийг тасалдуулахад хүргэдэг байв. Ухаант гэгддэг хүмүүс, өөрийгөө ухаантай хэмээн боддог хүмүүс сүнслэг бэлгийг тийнхүү ашиглахыг дэмжихгүй байх хандлага гаргаж байв. Тэд цээжин дотроо зүрх нь шатаж буй, дотор нь дүрэлзэн байгаа их галыг гадагш гаргахаас нааш санаа үл амрах тийм хүнд “Биеэ барь. Биеэ бага зэрэг барьж сурах хэрэгтэй, Эрүүл ухаантай хүн ийм байдлаар аашлах нь зохисгүй” гэдэг байв.

“Тесалоникийн чуулганд иймэрхүү нөхцөл байдал элбэг тохиолддог байсанд эргэлзэх зүйл үгүй. Нас болон зан аашны ялгаа ийм байдал үүсэх гол шалтгаан болж байсан нь гарцаагүй. Ахимаг насны болон флегматик (ноомой даруу - орч) хүмүүсийн тоо залуу халуун, гал цогтой хүмүүсийн тооноос их байсан нь мэдээж. Гэвч амьдралын туршлага ба зан аашнаас тогтдог мэргэн ухаанд гал цогтой бадрангуй сүнстэй харьцуулахад дутагдал бий. Ийм мэргэн ухаан хөндий хүйтэн, мохоо байдаг. Өөрийгөө түгээж чаддаггүй, ямар ч зүйлийг галдан асааж, түгээн тарааж чаддаггүй. Хүний сэтгэлийг урам зоригоор дүүргэн асааж чаддаггүй. Тиймээс гал дөлтэй үгнээс урган гарсан урам зориг дээр хүйтэн ус асгаж үл болно. “Сүнсийг бүү бөхөө” гэдэг үгийн утга чухам энэ аж. Уг тушаалаас үзэхэд сүнсийг бөхөөх боломжтой ажээ. Хүйтэн харц, дээрэнгүй үг, дуугаа хураах, үл тоомсорлох зэрэг нь сүнсийг бөхөөдөг агаад хайр

найргүй шүүмжлэл ч бас сүнснийг бөхөөнө.

Шинээр гал түлэхэд утаа их гардгийг хүн бүр мэднэ. Гэвч утааг арилгахын тулд гал дээр ус хийх биш харин гал өөрөө бүрэн асаж утаагүй болохыг хүлээх хэрэгтэй. Хэрэв та ухаалаг хүн бол галыг шилгээх, үлээх зэргээр бүрэн асахад нь туслаж болох ч зөнд нь орхиж өөрөө бүрэн асахыг хүлээх нь бүр ч ухаалаг хэрэг болно. Гал шиг дүрэлзэн ассан хичээл зүтгэлтэй дагалдагчтай учирсан хүн үүнтэй адил ухаалаг зүйл хийх ёстой. Түүнээс гарч буй утаа нүд хорсгож болох ч тэвчиж чадвал утаа удахгүй арилж, халуун дулаан илч нь үлдэнэ. Тиймээс сайн сайхан зүйлийн төлөө дүрэлзэн асах урам зориг буюу бадрангуй халуун сэтгэл бол дэлхий дээрх хамгийн дээд зэргийн зүйл юм. Ийм зүрх сэтгэлтэй хүн сайн мэдлэггүй, туршлагагүй, алдаа дутагдал гаргадаг, амьдрал зарим хүний гэгээн найдварт хязгаарлалт тавьсан байдгийг огт хардаггүй байж болно. Гэвч энэ нь Бурханаас ирсэн, өндөр үнэтэй, бусдад амархан нөлөөлдөг, сүнслэг хүчний хувьд дэлхийн мэргэн ухаанаас хавьгүй их ашиг тустай зүйл юм.

“Сүнснийг бөхөөж болох арга замуудаас би энд цухас дурдлаа. Чуулганы түүхэнд Сүнсний эсрэг тэмцсэн удаа дараалсан олон тэмцэл байсан нь гунигтай. Элч Паул “Эзэний Сүнс хаана оршино тэнд эрх чөлөө оршдог” гэж өөр нэг захидалдаа бичсэн байдаг. Гэвч эрх чөлөө нь нийгэмд аюултай ажээ. Зарим талаараа эрх чөлөө нь эмх цэгцтэй дайсагналцах агаад эмх цэгц сахиулагчид эрх чөлөөнд тийм ч таатай бус ханддаг. Тиймээс өнө эртний тэр үед эмх цэгцтэй байдлын тусын тулд Сүнсний эрх чөлөөг чуулганд хязгаарладаг байв. Бичээст өгүүлдэг шиг “Аароны таяг бусад сүнслэг бэлгүүдийг залгисан мэт” болсон аж. Чуулганы ахлагчид жирийн гишүүдээсээ тусгаарлагдсан бүхэл бүтэн анги давхарга болж хувирсан ба чуулганыг барьж босгоход зориулагдсан сүнслэг бэлгүүд зөвхөн тэднээр хязгаарлагдах болжээ. Ийнхүү зөвхөн тэд сайн мэдээний нигүүлсэл ба үнэний үйлчлэгч мөн, ард олон зөвхөн тэднээр дамжуулан Ариун Сүнстэй холбоо тогтоож чадна гэгддэг аймшигт үзэл санаа үүсэн гарч, ягшмал сургаал болон номлогдох болсон. Энгийн үгээр хэлэхэд,

Христэд итгэгч хүмүүс магтаал хүндэтгэл өргөхөөр хамтдаа цуглах үед Сүнс бөхөж байлаа. Итгэгч ах дүүсийн зүрх сэтгэлд дүрэлзэн ассан галыг унтраах гал сөнөөгч бий болжээ. Магтаал хүндэтгэл ба залбирал, эсвэл гал цогтой уриалгыг болон тэнгэрлэг үйлчлэлийг явуулах эмх цэгц ба ёс журмыг эвдэн, саад болох ёсгүй байлаа.... Энэ нь эртний Христэд итгэгчдийн магтаал хүндэтгэлийг бууруулсан нөхцөл байдал байсан ба харамсалтай нь өнөө үед ч ихэнх газарт оршин байсаар байгаа ажээ. Үүнээс бидэнд ашиг унасан уу? Үгүй гэж бодож байна. Энэ байдал үргэлж тэвчишгүй байдлыг авчирсаар ирсэн.

Тиймээс, цуглаанууд нь бичээсийн дагуу бус дүрэм журам, хэвшсэн хөтөлбөр, зан үйл эсвэл сүмийн ёслол зэргээр Ариун Сүнсийг хэзээ ч чөдөрлөх ёсгүй. Цугларалт тодорхой цагт өндөрлөх ёстой, үйлчлэл тодорхой зан үйлийг заавал дагах ёстой гэх мэт хатуу ойлголтуудад Сүнс хичнээн их гомддог бол! Иймэрхүү дэг журмууд зөвхөн Сүнсний хүчийг алдахад хүргэнэ.

### **Өнөө үед Ариун Сүнс хүссэнээ хийж чаддаг уу**

Хэрэв өнөө үед орон нутгийн цуглаанууд Ариун Сүнсэнд Тэнгэрлэг Удирдагчийн ёсоор үнэхээр түшиглэж чаддаг бол ямар байх байсан бол гэж бид өөрсдөөсөө асуух ёстой. Иймэрхүү төгс байдал ямар байж болохыг К. Макинтош тод томруунаар ийн дүрслэн бичжээ:

“Цуглааны хүн бүр илт Ариун Сүнсээр удирдуулж, зөвхөн Есүс дээр цугладаг байсан бол цуглааныг уйтгартай, нүсэр, ашиг тус багатай, ядаргаатай зүйл хэмээн дургүйцэх шаардлага гарахгүй, зүгээр л залбирах, үг хэлэхийн тулд л үг хэлэх номлолуудын завсар зайг дүүргэх гэж магтан дууны ном гартаа барих шаардлагагүй байх байсан. Хүн бүр Эзэний оршихуй дотор өөр өөрийн эзлэх байрыг мэддэг, сүнслэг авьяастай сав тус бүр дүүргэгдсэн, тохирсон, Эзэнийхээ гарт ашиглагддаг, нүд бүр Эзэн Есүсийн зүг ширтсэн, зүрх сэтгэл бүр Түүнд автагдсан байхсан. Библийн номуудын аль нэг бүлгийг уншлаа гэхэд энэ нь Бурханы Өөрийнх нь дуу хоолой болж, нэг үг хэллээ гэхэд зүрх сэтгэлд агуу их хүчээр ярих байсан. Залбирлаа гэхэд энэ нь

залбирагч хүнийг Бурханы оршихуйн өмнө аваачиж, магтан дуу дууллаа гэхэд энэ нь сэтгэл сүнсийг Эзэн Бурхан өөд өргөж, тэнгэрлэг босоо ятгын утсыг татах мэт болох байсан. Бидэнд Бурханы ариунаас ариун газарт орсон мэт сэтгэгдэл төрж, дахин хэзээ ч гарч явахгүйгээр Эзэний сэнтийн өмнө зогсон магтаал хүндэтгэл өргөх үеийн сайхныг урьдчилан мэдрүүлэх байсан.”

## ЧУУЛГАН ДАХЬ САХИЛГАЖУУЛАЛТ

Хэрэв орон нутгийн цуглааныг Бурханы чуулганы нарийн хэв загвар гэвэл цуглаан нь тав дахь амин чухал үнэнийг гэрчлэн харуулах ёстой. Бурханы чуулган бол ариун юм. Тэгвэл энэ ариун байдлыг яаж бодит амьдрал дээр харуулах вэ?

### **Урьдчилан сэргийлэх нь эмчилж эдгээхээс дээр**

Юуны өмнө цуглаан нь өөрийн гишүүдийн бурханлаг амьдралаар дамжуулан ариун байдлыг илтгэн харуулж чадна. Энэ бол үндсэн чухал зүйл. Бурхан бодит ариун байдлыг хүсдэг (1 Тесалоник 4:3). Тиймээс ч Шинэ Гэрээнд чуулгантай холбоотой үнэнүүдийг аль нэг хэсэгтээ тусад нь өгөөгүй харин оронд нь, чуулгантай холбоотой үнэнүүдийг Шинэ Гэрээний энд тэнд, итгэгч хүний ариун амьдралын тухай бодит удирдамж заавартай хамт тараан бичсэн аж. Эзэн гадна талдаа цэвэр, чуулганы амьдрал нь зөв хүмүүсийг биш харин амьдралаараа үнэнийг гэрчлэн харуулдаг хүмүүсийг хүсдэг.

Тиймээс, орон нутгийн чуулган Библийн сургаалыг сайн заадаг байх ёстой. Ингэхдээ Библийн энд тэндээс шүүрэн авсан ишлэлүүдийг биш харин Бурханы Үгийг дэс дараатай, системтэй заах хэрэгтэй. Ариун хүмүүс зөвхөн ийм замаар Бурханы бүх Үгийг Бурханы өгөх *тэнцвэртэй байдлаар* хүлээн авч чадна. Хэдийгээр зөв, системтэй номлол цуглаанд гэм нүглийг сануулж түүнээс урьдчилан сэргийлж чадах ч цуглаан бүрт ямар нэг хэмжээгээр сахилгажуулах арга хэмжээ авах хэрэг зайлшгүй гардаг. Цуглааны амар тайван байдалд эсвэл олон нийтэд гэрчлэх гэрчлэлд муугаар нөлөөлөх гэм нүгэл гарч ирэх бүрд цуглаан хатуу арга хэмжээ авдаг байх ёстой. Шүүлт нь Бурханы гэр бүл дотор явагдах учиртай (1 Петр 4:17).

## **Арга хэмжээ авах учир шалтгаанууд**

Хоёр гол зорилгоор сахилгажуулах арга хэмжээг авдаг: 1-рт, үнэндээ сүнсээр дахин төрөөгүй боловч өөрсдийгөө итгэгч гэдэг хүмүүсийг илрүүлж чуулганы нөхөрлөлөөс, чуулганаас гаргах. Ийм хүмүүс ямар байдгийг 1 Иохан 2:19-т дүрсэлсэн ажээ. 2-рт, алдаа гаргасан итгэгч хүний, Эзэнтэй болон тухайн орон нутгийн чуулгантай харьцах харьцааг сэргээх замаар арга хэмжээ авах. Итгэгч хүнд авах сахилгажуулах арга хэмжээ эцсийнх биш харин үргэлж, түүний сүнсийг эдгээх арга хэрэгсэл байх ёстой.

## **Сахилгажуулалтын хэр хэмжээ**

Шинэ Гэрээнд сахилгажуулалтын олон хэр хэмжээг дүрсэлсэн байдаг. Итгэгч ах дүүс нэг нэгнийхээ эсрэг гэм хийх тохиолдолд эхлээд гэм хийсэн хүнтэй хувьчлан уулзаж ярих ёстой. Хэрэв сонсохгүй бол хоёр буюу гурван хүнтэй хамт очиж ярилцана. Хамт олны энэ гэрчлэлийг сонсож хүлээн авахгүй бол түүний асуудлыг чуулганд ярина. Сүүлийн энэ арга хэмжээ бүтэлгүйтвэл тухайн хүнийг харь үндэстэн буюу татвар хураагч хэмээн тооцно (Матай 18:15-17).

Сахилгажуулалтын өөр нэг хэлбэр бол сануулга юм (1 Тесалоник 5:14). Үүнийг, Эзэн дотор өөрийнх нь дээр тавьсан хүмүүст захирагдахаас татгалздаг дуулгаваргүй хүмүүст хэрэглэнэ. Библид хоёр төрлийн хүнээс тухайлбал, эмх журамгүй (2 Тесалоник 3:11,14-15), мөн хагарал гаргагч (Ром 16:17) хүмүүсээс зайлсхийх тухай өгүүлсэн байдаг. Эмх журамгүй хүн ажил хөдөлмөр эрхлэхээс татгалздаг бол нөгөөх нь материаллаг ашиг сонирхолын төлөө мөн өөрийн араас бусдыг дагуулахын тулд Бурханы хүмүүс дунд хагарал гаргадаг.

Тэрс үзэлтэн хүнээс анхны болон хоёр дахь сануулгын дараа татгалзах ёстой (Тит 3:10). (Тухайн хүнийг чуулганаас зайлуулах эсвэл хатуувтар арга хэмжээ авах эсэх нь тодорхой биш ажээ.)

Эцэст нь сахилгажуулалтын тун чанга хэлбэр бий. Энэ

бол чуулганаас хөөх хэлбэр юм (1 Коринт 5:11,13). Үүнийг завхайрагч, шунахай, хиймэл шүтээн шүтэгч, хараал урсгагч, архичин болон хахууль авагч хүмүүст хэрэглэнэ.

## **Үнэн зөв нотлох баримттай байхын чухал ач холбогдол**

Сахилгажуулах арга хэмжээн дээр анхаарч үзэх нэг чухал зүйл бол тухайн хэргийг баттай нотлох баримт дээр үндэслэн шударгаар шүүх явдал юм. Үүнтэй холбоотой ерөнхий зарчмуудыг К. Макинтош ийн дүгнэн бичжээ:

“Бид, хоёр болон гурван гэрчийн мэдүүлэггүйгээр хэнийг ч оюун бодолдоо эсвэл үйлдлээрээ шүүх ёсгүй. Итгэл хүлээсэн, ёс журамтай нэг хүний гэрчлэл ямар нэг дүгнэлт хийх хангалттай үндэслэл болж чадахгүй. Бид аль нэг хэргийг, итгэдэг хүн маань баталсан учир үнэн зүйл хэмээн үнэмшиж болох ч Бурхан биднээс илүү ухаалаг билээ. Нэг хүний гэрчлэл нарийн зөв, үнэн байж, тэр хүн дэлхий ертөнцөд худал зүйл ярихгүй, эсвэл хэн нэгний эсрэг худал мэдүүлэг өгөхгүй байж болох ч гэрчийн мэдүүлгийг “хоёр буюу гурван хүний гэрчлэл дээр” үндэслэнэ гэсэн тэнгэрлэг зарчмыг баримтлах ёстой.

Энэ зарчмыг Бурханы чуулган илүү хичээнгүй дагадаг болоосой! Сахилгажуулалтын бүх хэлбэр, түүний тухайн хүний зан чанар эсвэл нэр хүндэд нөлөөлөх нөлөөллийн үнэ цэнийг тооцошгүй юм. Чуулган ямар ч үед аливаа хэргийг дүгнэхдээ эсвэл арга хэмжээ авахдаа зохих ёсны нотлох баримтыг шаргуу шаардах ёстой. Хэрэв тийм нотлох баримт гарч ирэхгүй бол бүгд Бурханыг итгэлтэйгээр, тэвчээртэйгээр хүлээх хэрэгтэй бөгөөд Бурхан хэрэгтэй зүйлийг заавал гаргаж өгөх болно.

Жишээлбэл, хэрэв итгэгч хүмүүсийн цуглаанд ёс суртахуунгүй байдал эсвэл сургаал номлолын чанартай алдаа гарвал, үүнийг ганцхан хүн мэдсэн, тэр хүн үүндээ бат итгэлтэй байвал яах вэ? Тэгвэл Бурхан өөр гэрчлэх зүйлийг өгтөл хүлээх ёстой. Ингэж хүлээхгүйгээр ямар нэг зүйл хийх нь Бурханы Үгэнд маш тодорхой олон дахин өгүүлсэн тэнгэрлэг зарчмыг зөрчсөн хэрэг болно. Өөрийнх нь



мэдүүлгийн дагуу ямар нэг зүйл хийгээгүйн улмаас мэдүүлэг өгсөн хүн гомдох ёстой юу? Мэдээж үгүй. Үнэндээ бол өөрийнх нь үгийг батлах өөр нэг буюу хэд хэдэн хүн гарч ирэхээс нааш хэргийг ганцаараа ярих ёсгүй. Чуулган ганц хүний мэдүүлгийн дагуу арга хэмжээ авахгүй байх нь бусдад хайхрамжгүй, идэвхгүй мэт үзэгдэхгүй юу? Үгүй. Чуулган тэнгэрлэг зарлиг тушаалын дагуу л үйлдэж байгаа нь тэр.

Бодит ач холбогдолтой энэхүү зарчмын хэрэгжүүлэлтийг зөвхөн итгэгчдийг сахилгажуулах хэрэг эсвэл Эзэний чуулгантай холбоотой хэргүүдээр хязгаарлалгүй харин бүх дэлхий дахинд хэрэгжүүлэх ёстой. Тэнгэрлэгээр тогтоогдсон нотлох баримтны тоо хэмжээгүйгээр хэн нэгнийг шүүх эсвэл дүгнэлт хийхийг бид өөрсөддөө хэзээ ч зөвшөөрч болохгүй. Нотлох баримт гарч ирэхгүй байх тохиолдолд ямар нэг хэргийг шүүх шаардлагатай болбол Бурхан өөрийн тогтоосон цагт бидэнд шаардлагатай нотлох баримтыг гаргаж өгнө. Бид хилсээр гүтгэгдсэн нэг хүний хэргийг мэднэ. Хэрэв түүнийг буруутгасан хүн ганц мэдрэмж дээрээ үндэслэлгүй өөр нэг буюу хэд хэдэн зүйл дээр тулгуурласан бол түүнд ял тулгахгүй байж болох байсан.

### **Сахилгажуулалтыг яаж хэрэгжүүлэх вэ**

Энэ сэдэвтэй холбоотой, анхаарч үзвэл зохих өөр нэг асуудал бол сахилгажуулалтыг хэрэгжүүлэх арга барил юм. Жишээлбэл, сахилгажуулалтыг хийхдээ өөрөө бас соригдохгүйн тулд өөрийгөө хянаж дөлгөөн байдлаар хийх ёстой (Галат 6:1). Мөн түүнчлэн алагчилж болохгүй. Жишээлбэл, бурууг үйлдсэн хүн бидэнтэй цусан төрлийн ямар нэг холбоотой байлаа гэхэд гаргах шийдвэрт маань огт нөлөөлөх ёсгүй. Хүндтэй хүн гээд тал засаж болохгүй (Дэд хууль 1:17, Иаков 2:1).

Чуулганаас хөөх тухай асуудал хэн нэгний шийдвэр биш харин бүх цуглааны шийдвэр байна (2 Коринт 2:6). Сахилгажуулалтын ийм төрлийн арга хэмжээг ямар байдлаар хийх тухай өгүүлсэн К. Макинтошийн номоос дахин нэг удаа иш татая. Тэрээр ийн бичжээ: “Хэн нэгнийг Эзэний ширээнээс зайлуулахаас илүү ноцтой, сэтгэл өвтгөсөн зүйл гэж үгүй. Энэ нь цуглааны хувьд эцсийн

бөгөөд аргагүй эрхэнд хийгдэх зүйл байх ёстой бөгөөд үүнийг эмтэрсэн сэтгэлээр, нулимстай нүдээр хийх учиртай. Харамсалтай нь үүнийг эсэргээр нь хийх явдал хичнээн их байна вэ! Туйлын ноцтой энэ ариун үүрэг тухайн хүнийг чуулганы нөхөрлөлөөс зайлуулсаныг зарлах энгийн зар төдийхөн болох нь их болсон ажээ. Ийм байдлаар хийгдэж байгаа сахилгажуулалт алдаа гаргасан хүн эсвэл бүхэл цуглаанд хүчтэй нөлөөлөхгүй байгаад гайхах зүйл үгүй.

Тэгвэл, чуулганаас хөөх энэ сахилгажуулалтыг яаж хийх ёстой вэ? 1 Коринт номын 5-р бүлэгт заасан ёсоор хийнэ. Хэргийг тэвчээртэйгээр тал талаас нь авч үзэн, бүх талаас нь ярилцаж тодорхой болгосны дараа цуглааны тусгай хуралдааныг зарлан хуралдуулах ёстой. Боломжтой бол цуглааны бүх гишүүн хуралд оролцохдоо өөрсдийгөө чин үнэнээр шүүн цэгнэж Бурханы өмнө гэм нүглээ тавих нигүүлслийг эрж, гэм нүглийн өргөлөөс хүртэнэ. Цуглаан хэргийг шүүн ярилцахын тулд цуглахгүй. Христ болон Түүний чуулганы ашиг сонирхолын төлөө ажилладаг хүмүүс хэргийг нарийн шалгаж, нотлох бүх баримтыг цуглуулсаны дараа бузар мууг үйлдэгч этгээдийг өөрсдийнхөө дундаас зайлуулах гунигтай арга хэмжээг харуусах сэтгэлээр, төлөв даруу байдлаар авах зорилгоор бүх цуглааныг дуудан хуралдуулна. Энэ бол Эзэний тушаалыг дуулгавартай даган биелүүлэх ариун үйлдэл юм.”

Эцэст нь хэлэхэд, итгэгч хүмүүс ах дүүгийнхээ үйлдсэн гэм нүгэл болон сахилгажуулалтын арга хэмжээг бусдад зарлан ярих биш харин гадны хүмүүсийн нүднээс далд байлгаж “ариун бүрээсээр” бүрэх ёстой.

## **Дүгнэлт**

Цуглаан нь гэм нүгэл илчлэгдэх үед зоригтой арга хэмжээ авч чадвал Бурханы ариун сүмийн жинхэнэ шинж чанарыг хадгалж чадна. Шинэ Гэрээнд итгэгч хүн бүр амьдарч буй газрынхаа Христийн чуулгантай холбогдох ёстойг заасан байдгийг энд нэмж хэлэх нь зүйтэй болов уу. Эс бөгөөс тухайн итгэгч цуглааны сахилгажуулалтаас ангид эрх чөлөөтэй байх ба ийм эрх чөлөө нь хувь хүнд тун аюултай юм.

## ЧУУЛГАНЫ ӨСӨЛТ

Орон нутгийн чуулганы авч хэрэгжүүлэх ёстой, чуулгантай холбоотой өөр нэг үнэн бий. Энэ бол сүнслэг бэлгүүд чуулганыг босгон байгуулахын тулд өгөгддөг гэсэн үнэн юм. Босгон байгуулалт гэдэг нь өсөлт ба өргөжин тэлэлттэй холбоотой тул бид энэ удаа чуулганыг өргөжүүлэн тэлэх Бурханы төлөвлөгөөний талаар ярилцах болно.

Өнөө үед Бурхан чуулганаар дамжуулан Христэч итгэлийг газар дэлхий дээр дэлгэрүүлэн тараахыг хүсдэг. Тиймээс чуулган бүр өргөжин тэлэхэд, шинэ сонсогчдыг олж авахад, өөрийгөө сурталчилан таниулахад, өөр цуглаануудыг үүсгэн байгуулахад анхаарах ёстой.

Өмнөх бүлгүүдэд дурьдсанчлан чуулганы Тэргүүн болох Есүс чуулганыг сүнслэг бэлгүүдээр хангасан ба эдгээр бэлгүүдийг зөв ашиглах үед чуулган өсөж хөгждөг.

### **Өнөө үеийн сүнслэг бэлгүүд**

Анх чуулганд элч, эш үзүүлэгч, сайн мэдээ тунхаглагч, пастор ба багш хийх гэсэн таван сүнслэг бэлэг өгөгдсөн тухай бид өмнө үзсэн. Эхний хоёр нь юуны өмнө чуулганыг үндэслэн байгуулахад зориулагдсан ба Бурханы Үг бичгийн хэлбэрээр бүрэн өгөгдөх үед тэдгээрийн хэрэгцээ аяндаа үгүй болсон тухай бид ярьсан.

Энэ бол, өнөөгийн бидэнд авралын зар тараагч, пастор ба багш хийх гэсэн гурван бэлэг авьяас бий гэсэн үг. Одоо бүгдээрээ сүнслэг бэлгүүдийн зорилго ба тэдгээрийн гүйцэтгэх үүргүүдийг үзэцгээе.

## Сүнслэг бэлгүүд яах гэж өгөгддөг вэ

Ефес номын 4:12-13-т сүнслэг бэлгүүдийн зорилгуудыг ийн гаргаж тавьжээ. “Эдгээр нь ариун хүмүүсийг үйлчлэлийн ажилд бэлтгэж, Христийн биеийг байгуулахын тулд юм. Бид бүгд итгэл хийгээд Бурханы Хүүг мэдэх мэдлэгийн нэгдэл хүртэл, төлөвшсөн хүн болтол, Христийн дүүрэн байдлын чанарын хэмжээнд хүртэл ингэх ажээ”.


Өнгөц уншихад эдгээр сүнслэг бэлэг 1) ариун хүмүүсийг төгөлдөржүүлэх, 2) сайн мэдээний үйлчлэгчийг ажиллуулах, 3) Христийн биеийг босгон байгуулах гэсэн гурван өөр зорилгоор өгөгдсөн гэж дүгнэж болохоор байна. Гэвч сайн уншиж үзвэл үгүй аж.

Уг сүнслэг бэлгүүд гурван өөр зорилгоор биш харин ганц зорилгоор өгөгдсөн агаад энэ нь ариун хүмүүсийг итгэл дээр барьж босгоход, хариуд нь тэд Христийн биеийг тоо болон сүнсээр өсгөхийн тулд сайн мэдээний үйлчлэлийн ажилд бэлтгэгдэх ажээ.

## Уг үнэнийг дүрслэн үзүүлэх нь

Уг үнэнийг 1-р зургаар дүрслэн харуулж болно. Тойргийн гол хэсэгт байгаа жижиг хар тойргийг багшлах буюу заах бэлэг авьяас гэж бодъё: Тэрээр эргэн тойрондоо байгаа хүмүүсийг төгс болгохын тулд (өөрөөр хэлбэл, итгэл дээр барьж босгохын тулд), дараа нь тэднийг бусдад үйлчлүүлэхийн тулд тэдэнд хүрч үйлчилдэг. Чуулган ийм маягаар өсөж хөгжин, өргөжин тэлдэг. Энэ бол аль болох богино хугацаанд олон тооны хүнд сайн мэдээг хүргэх тэнгэрлэг аргачлал юм.


1-р зургаар



Авралын зар тараагчид, пастор болон багш нар дээрх загварын дагуу бусдад үйлчлэх, хүмүүст хүрч тэднийг сургаж, бэлтгэхэд байнга анхаардаг байх ёстой.

Хэдийгээр итгэгч хүн бүр авралын зар тараах, пастор болон багш хийх бэлэг авьяасгүй ч христэч үйлчлэлд хамрагдах ёстой. Чуулганы гишүүн бүр магтаал хүндэтгэл өргөгч, хүмүүсийн сүнс сэтгэлийг байлдан дагуулагч, Библи судлалын сурагч, христэч итгэлийг суртчилагч байх ёстой.

Энэ чухал ажил үүргийн талаар цааш нь 2 Тимот 2:2-т ийн бичжээ. *“Олон гэрч нарын өмнө надаас сонссон зүйлсийг бусдад заах чадвартай итгэмжит хүмүүст даатга.”* Үүнийг 2-р зургаар дахин дүрслэн харуулъя:




Ийм төлөвлөгөөний ашиг тус илт харагдах болно. Уг төлөвлөгөөг хэрэгжүүлсний дүнд Христэч итгэл өргөжин тэлнэ. Итгэгч хувь хүмүүс Бурханаас заяасан үүрэгт ажлаа хийж гүйцэтгэх замаар бүрэн дүүрэн боловсорно. Бүрэн дүүрэн боловсорсон тэд өнөө үед дэлхийд их дэлгэрсэн буруу урсгалын сургаал номлолд автагдах нь багасна. Ингэж өргөжин тэлж, бүрэн дүүрэн боловсорсон чуулган, газар дээр Христийн биеийг илүү сайн, нарийн зөв төлөөлөх ажээ.

### **Христ итгэлт ертөнцөд элбэг тохиолддог тогтолцоо**

Үүний эсрэг тогтолцоо өнөөдөр Христ итгэлт ертөнцөд элбэг тохиолдох болсон. Энэхүү тогтолцоо нь нэг хүнийг сүмийн үйлчлэгчээр сонгодог. Сонгогдсон тэр хүн номлол зааж, итгэгчдэд баптисм хүртээж, Эзэний зоогийг удирдан явуулахын зэрэгцээ сүмийн бусад үүргийг гүйцэтгэдэг. Цугларсан олон түүний номлолыг долоо хоног бүр ирж итгэмжтэйгээр сонсдог боловч харамсалтай нь уг номлогчид ажлаа хийх боломж олгон мөнгө төлдөг хэмээн боддог тул өөрсдөө ямар нэг байдлаар сүмийн үйл ажиллагаанд идэвхтэй оролцох хүсэлгүй байдаг. Товчхондоо, тэд Бурханы Үгтэй өөрийн биеэр маш бага танилцдаг ба зүгээр л номлол амтлагчид болж хувирдаг аж. Үүний гол аюул бол тэд авралын зар тараах орчны хамгийн захад байрлах агаад *“...давалгаанд энд тэнд шидээгдэн, аливаа номлолын салхи, хүмүүсийн ов мэх болон зальхай хуйвалдааны башир арганд.....”* (Ефес 4:14) автдаг хүүхэд хэвээр үлддэг.

Уг тогтолцоог 3-р зургаар харуулъя:

### 3-р зургаар



Энэ зургаас үзвэл чуулганы үйлчлэлийг эрхлэн явуулдаг нэг хүн байх агаад бусад нь үйлчлэлд хариуцлагатайгаар оролцох боловч дараа нь сонссон зүйлийнхээ талаар ямар нэг зүйл хийх хэрэгтэй гэж нэг их бодохгүйгээр өөр өөрсдийн ажил амьдрал уруу буцан ордог ажээ. Ийм нөхцөлд ганц үйлчлэгчийн хийж чадах зүйл хязгаартай байх нь мэдээж. Нөгөө талаар, хэрэв цуглааны бүх хүн Эзэний төлөө идэвхтэй ажилладаг бол гайхалтай хөгжил дэвшилд хүрч болно.

Александр Макларен энэ тухай ийн бичжээ: “Чуулганы номлолыг албан ёсны нэг хэсэг хүмүүсээр хязгаарлах нь хор уршигтай гэж би боддог. Яагаад заавал ганц хүн байнга ярьж, заах чадвартай олон хүн түүнийг сонсоод эсвэл сонссон дүр үзүүлээд зүгээр суух ёстой гэж? Би хүчээр хувьсгал хийхийг үзэн яддаг. Мөн улс төрийн ч, шашны ч ямар нэг байгууллагыг хүчээр татан буулгах ёстой, цаг нь болсон гэдэгт итгэдэггүй. Үүний оронд, хэрэв бидний сүнслэг амьдралын түвшин нэмэгдэх аваас шинэ хэлбэр аяндаа үүсэн тогтож *“Эцсийн өдрүүдэд хүн төрөлхтний*

дээр *Би Өөрийн Сүнсийг цутгана*” (Үйлс 2:17) гэсэн Христэд үзлийн ардчилалын агуу уг зарчим аяндаа биелэлээ олох болно гэж боддог”.

## **Санваартаны тогтолцоо**

Ганц хүний үйлчлэлийн тухай энэ ярианаас “Санваартаны тогтолцоог юу гэх вэ? Энэ нь Бичээсийн дагуу тогтолцоо мөн үү? гэсэн асуулт гарч ирнэ. Энэ асуултанд тохирох хариултыг хайцгаая.

Санваартан гэдэг нь Бурханы үйлчлэлд хүмүүсээр томилогдсон тусгай хүмүүсийн анги давхрагыг хэлэх ба ихэвчлэн ийм хүмүүст номлол заах, сургах, баптисм хийх мөн Эзэний зоогийг зохион байгуулах эрх мэдлүүд өгөгдсөн байдаг.

Санваартан байсан хүмүүсийн дунд Христийн гарамгай дагалдагч бөгөөд Түүний ажил үйлсэд гайхамшигтайгаар ашиглагдсан хүн олон байсаар ирснийг бид дуртайяа хүлээн зөвшөөрдөг. Ийм олон хүнд мөн тэдний амаар болон бичгээр хийсэн олон ажил үйлчлэлд бид зүй ёсоор талархах ёстой. Эзэн Есүс дотор ийм итгэгч хүмүүсийг бид ах дүүгийн ёсоор тэврэн авахад бэлэн.

Гэвч, Шинэ Гэрээнд санваартаны тухай санаа байхгүй гэдэг бодит үнэнтэй бид шударгаар нүүр тулах ёстой. Христийн чуулганыг хариуцсан нэг хүний тухай Шинэ Гэрээнд өгүүлсэн зүйл хаана ч байхгүй.

## **Шинэ Гэрээнд юу гэж заадаг вэ?**

Санваартаны тухай санаа Шинэ Гэрээнд огт байхгүйгээс гадна энэ санаа Шинэ Гэрээний заадаг сургаал номлолтой зөрчилддөг гэж бид боддог.

Нэгдүгээрт, итгэгч бүх хүн тахилч гэсэн зарчмыг зөрчиж байна (1 Петр 2:5,9). Хуучин Гэрээний үед хүнийг Эзэн Бурхантай холбон зуучилдаг тусгай бүлэг хүмүүс гэж байсан. Харин Христэд итгэлд бол итгэгч хүн бүр тахилч бөгөөд хүн бүр тахилч хүний бүх эрх үүргийг эдэлдэг. Гэвч бодит амьдрал дээр нэг хүний үйлчлэл магтаал хүндэтгэлийн



амыг барьж, итгэгч тахилчдын үйлчлэлд саад учруулж байна.

Хоёрдугаарт, санваартаны тогтолцоо нь үйлчлэлийг дураараа ганц буюу албаны хэсэг хүмүүсээр хязгаарлах замаар чуулганд сүнслэг бэлгүүдийг ашиглахад саад болдог (1 Коринт 12 ба 14).

Дахин хэлэхэд санваартаны тогтолцоо нь сүм цуглааны зан үйлийг зөвхөн тахилчаар хязгаарладаг агаад Бичээсүүдэд үүнийг дэмжсэн зүйл огт байхгүй. Санваартаны тогтолцоог зайлшгүй дагалддаг тогтмол цалинтай сүмийн үйлчлэлийн зарчим нь өндөр албан тушаалын нэг буюу хэд хэдэн хүний өмнө заавал хариуцлага хүлээхэд хүргэдэг. Уг өндөр албан тушаалтан сүнслэг бус, хуурмаг амжилт ололтын хэм хэмжигдэхүүнийг шаардах замаар санваартанд шахалт дарамт үзүүлж болно.

Жишээлбэл, жилийн хугацаанд сүмд шинээр нэмэгдэж ирсэн хүмүүсийн тоогоор тухайн санваартаны ажлын үр дүнг дүгнэх хандлага нийтлэг байдаг. Энэ бол ажил үйлчлэлийг хэмжих жинхэнэ хэмжүүр биш төдийгүй бусдаас илүү их зүйл хийж буй мэт харагдуулахын тулд Христийг хүлээн авах арга хэмжээний хэм хэмжигдэхүүнийг бууруулах буюу үүнийг үл анзаарахад хүргэдэг. Христийн зарц хүн ийм зүйлүүдэд боогдож, чөдөрлөгдөх ёсгүй. Харин Эзэн дээр үргэлж эрх чөлөөтэй байх ёстой (Галат 1:10).

Санваартаны тогтолцоо нь хүмүүсийг Эзэний нэрээр биш харин хэн нэгэн хүн дээр цуглуулах аюултай байдаг. Хэрэв тухайн хүн цуглаанд хүмүүсийг татах гайхалтай хүч болдог бол түүнийг цуглаанаас холдон явахад цуглаан хүмүүсийг татах зүйлгүй болно. Нөгөө талаар, хэрэв ариун хүмүүс Эзэн дээр цуглардаг бол тэнд Эзэн байгаа учир тэд үнэнч итгэлтэй байх болно. Онол дээр биш гэхэд бодит амьдрал дээр санваартанууд Христийн удирдлагын тухайн үнэнийг бүдгэрүүлэх буюу (Ефес 1:22) зарим тохиолдолд бүр мөсөн үгүйсгэх нь бий.

Шинэ Гэрээний харгалзагчийг өнөө үеийн санваартантай

адил гэсэн маргаан гарч болох юм. Тэгвэл үүнд өгөх хариулт бий. Шинэ Гэрээ аль нэг чуулган эсвэл хэсэг чуулганы дээр ганц харгалзагчийг биш харин хэд хэдэн харгалзагчийг тавьж байсан (Филиппой 1:1).

Санваартаны албыг хашдаг олон хүн тухайн сүмд зориулсан Христийн авьяас бэлэгтэй хүмүүс байдгийг үгүйсгэх аргагүй. Гэвч тэд хүмүүний томилгоо эсвэл зан үйлээр биш харин Эзэн Есүсийн Өөрийнх нь хүчээр авьяас бэлэгтэй болсон. Тэд ариун хүмүүсийг өөрсдөөсөө хамааралтай болгохын тулд биш харин тэднийг Эзэнд үйлчлэх идэвхтэй үйлчлэлд зориулан барьж босгох үүрэгтэй. Бид номынхоо энэ бүлэгт Бурханаар дуудагдаагүй хүмүүсийг хүмүүний зан үйлээр гаргаж тавихын муу уршигийг илчилж, харуулахыг зорив.

Эцэст нь хэлэхэд, чуулганы сургаал номлол заах үйлчлэлийг ганц хүн хариуцах үед хяналт тавих, тэнцвэртэй байдлыг хадгалах тогтолцоо байхгүй болох ба сургаал номлол өөрөө бузар муу болдоггүй юм гэхэд Бичээсийг ганц талыг баримтлан тайлбарлах аюул гарч ирдэг. Нөгөө талаар, Ариун Сүнс олон янзын сүнслэг бэлгүүдээр дамжуулан чуулганд чөлөөтэй ярих үед үнэнг олон талаас нь ярих боломж гарч, итгэгчид Бичээсийг Бичээстэй хичээнгүйлэн харьцуулан судлах тул алдаа гарах магадлал маш их багасах болно.

## **Дүгнэлт**

Тэгэхээр, заримдаа санваартаны тогтолцоог төлөөлж буй үйлчлэгч хүмүүсээс маш их ивээл урсан гарч ирдэг ч энэ нь зөвхөн Бурханы төлөвлөсөн дээд зэргийн сайн зүйлд төдийгүй чуулганы сонирхолд ноцтой хөнөөл учруулж болно гэж бид боддог.

Бурхан ариун хүмүүсийг үйлчлэлд бэлтгэх зорилгоор сайн мэдээний үйлчлэгч хүмүүст сүнслэг бэлгүүдийг өгдөг. Хариуд нь ариун хүмүүс сайн мэдээний үйлчлэгчийн ажлыг хийхийн тулд илгээгддэг. Энэхүү чухал зарчмыг орон нутгийн чуулганууд ойлгож мэддэг, үүнийг чөлөөтэй хөгжихөд ямар нэгэн байдлаар саад хийдэггүй байх ёстой.

Итгэгч хүмүүс ингэж үйлчлэх үед аврагдаагүй хүмүүс аврагдаж, ариун хүмүүс боловсорч, шинэ цуглаанууд үүсэн бий болох болно.

# БУРХАНААР ТОМИЛОГДСОН БУРХАНЫ ТАХИЛЧ

## Тахилч итгэгчид

Уг номын эхэнд бидний жагсаан бичсэн чуулгантай холбоотой үнэнүүдийн долоо дахь буюу хамгийн сүүлчийнх бол бүх итгэгчид Бурханы тахилч гэсэн үнэн юм. Орон нутгийн цуглаан бүр өөр ямар нэг тахилчын тогтолцооноос татгалзахын зэрэгцээ энэ ариун албаны эдлэх эрх ба үүргийг ганцаараа болон хамт олноороо эдлэн, хэрэгжүүлэхийг итгэгч хүн бүрд уриалж уг үнэнийг бодит амьдрал дээр гэрчлэн харуулдаг байх ёстой.

## 1. Эсрэг тал

Хуучин Гэрээнд Мосегийн хуулиар Леви овог болон Аароны гэр бүлийг израиль үндэстний тахилчаар тохоон томилсон байдаг (Египетээс гарсан нь 29:9). Тэд тусгай өмсгөл өмсдөг, онцгой эрх эдэлдэг мөн израиль үндэстэнийг Эзэн Бурхантай холбодог тусгай бүлэг хүмүүс байв. Зөвхөн тэд ариун газарт орж хуулинд заасан өргөлүүдийг өргөдөг байжээ.

Христ итгэлт ертөнцөд энэ бүхэн өөрчлөгдсөн аж. Шинэ Гэрээнд заасан ёсоор бол итгэгч бүх хүн тахилч юм. 1 Петр 2:5-д ийн өгүүлжээ: *“Иймд амьд чулуу мэт болсон та нар ч Есүс Христээр дамжуулан Бурханд тааламжит, сүнслэг тахилуудыг өргөх ариун тахилч болохын тулд сүнслэг байшин болон баригдагтун”*. Бас 1 Петр 2:9-д *“Харин та нар бол сонгогдсон угсаа, хаант тахилч нар, ариун үндэстэн, Бурханы эзэмшлийн ард түмэн юм. Ингэснээр харанхуйгаас та нарыг Өөрийн гайхамшигт гэрэл уруу дуудсан Түүний давуу чанаруудыг та нар тунхаглах юм”* гэсэн байхад Илчлэлт 1:5-6-д *“мөн итгэмжит гэрч ба үхэгсдээс анх төрсөн бөгөөд газрын хаадын захирагч Есүс*

*Христээс нигүүлсэл ба амар тайван нь та нарт байх болтугай. Биднийг хайрладаг бөгөөд Өөрийнхөө цусаар биднийг нүглээс минь чөлөөлж, биднийг хаанчлал болоод Бурхан ба Өөрийн Эцэгийн төлөөх **тахилч** нар болгосон Түүнд үеэс үед алдар хийгээд ноёрхол нь байх болтугай. Амен”.*

Мартин Лютер, итгэгч бүх хүн тахилч гэсэн үнэнийг чин сэтгэлээсээ хамгаалан ийн бичиж байжээ: “Итгэгч бүх хүн тахилч юм. Итгэгч хүнээс өөр тахилчийн тухай ямар ч яриа байх ёсгүй. Учир нь ийм санааг Бурханы үг нотлохгүй бөгөөд зүгээр л хэн нэгний хэлсэн үг эсвэл эртний уламжлал эсвэл олон хүний бодол тул ямар ч эрх мэдэлгүй юм”

## **2. Итгэгч бидний өргөл**

Тахилч хүний гүйцэтгэдэг чухал ажил үүргүүдийн нэг бол өргөл юм. Хуучин Гэрээнд өргөлийг голдуу мал нядлах замаар өргөдөг байсан. Өнөөдөр харин итгэгч хүмүүсийн өргөл бол:

- Өөрийн биеийг өргөх өргөл (Ром 12:1). Энэ бол амьгүй өргөл биш харин “Бурханд тааламжит, амьд, ариун өргөл” юм.
- Өөрийн материаллаг баялагийг өргөх өргөл (Еврей 13:16). “Сайныг үйлдэхээ болон хуваалцахаа бүү март. *Учир нь ийм тахилууд Бурханд тааламжтай”.*
- Магтаалын өргөл юм (Еврей 13:15). “*Түүгээр дамжуулан Бурханд Түүний нэрийг хүлээн зөвшөөрдөг уруулын үр жимс буюу магтаалын тахилыг үргэлж өргөцгөөе”.* Магтаалын энэ өргөл хувь хүнийх мөн хамтынх байх ёстой. Итгэгч хүн бүр чөлөөтэй оролцож болох хамтын магтаал өнөө үеийн хатуу хяналт дор явагддаг цуглаанаас бараг арчигдан алга болсон билээ. Үүний дүнд Бичээсийн хаана ч байхгүй, “дүйнгэ” тахилчдын шинэ эрин үе бий болсон юм.

## **3. Тахилч хүний бусад ажил үүрэг**

Тахилч хүний бусад ажил үүрэгт залбирах, Бурханыг

гэрчлэх, Бурханы хүмүүсийг халамжлах зэрэг нь багтана. Тиймээс итгэгчид энэ ариун үүргийг тогтмол биелүүлдэг байх ёстой. Эрик Соер ийн хэлсэн байдаг: “Энэ сэдвийг хөндсөн Бичээсийн бүх сургаал (Ром 8:14, Галат 5:18, Иохан 16:13) үүнийг бид зөвхөн Эзэний өдөр биш харин бүх амьдралынхаа турш, өдөр бүр өглөөнөөс орой хүртэл хэрэгжүүлж байх ёстойг тодорхой харуулж байна. Мэдээж хэрэг үүнийг чуулганы цугларалтын эхлэлээс эцэс хүртэлх цаг мөн магтаал хүндэтгэлийн цаг, Библи уншилт эсвэл залбирал зэргээр хязгаарлаж болохгүй ба харин үүнд өрөө тасалгаа, хонгил, залбиралын жижиг өрөө, чуулганы барилга зэргийн дотор ба гадна байгаа хүн өөрөө бүхлээрээ багтдаг. Шинэ Гэрээний итгэгчид бүрэн утгаараа Бурханд *“тахилч нарын хаанчлал, ариун үндэстэн”* юм (Египетээс гарсан нь 19:6, 1 Петр 2:5-9)”

#### **4. Итгэгч бидний Тэргүүн Тахилч**

Итгэгч хүн бүр тахилч гэдэг нь үнэн боловч бас итгэгч хүн бүрд тахилч хэрэгтэй гэдэг нь ч үнэн. Бидний энэ хэрэгцээг Эзэн Есүс Христ бүрэн хангаж өгдөг. Еврейчүүдэд бичсэн захидалд *“бидэнд байгаа нь бидний мөхөс байдлыг хуваалцаж чаддаггүй тэргүүн тахилч бус, харин нүгээлгүй атлаа бүх талаар бидэн шиг соригдсон Нэгэн билээ”* (Еврей 4:15) гэж бидний Агуу Тэргүүн Тахилчийг дүрсэлсэн байдаг.

#### **5. Христ итгэгчдийн хийсэн буруу үйл**

Орон нутгийн чуулган бүр Эзэн Есүсийг Агуу Тэргүүн Тахилч гэдгийг бас итгэгч хүн бүр хаант угсааны ариун тахилч гэдгийг хүлээн зөвшөөрөх ёстой. Гэвч өнөөгийн Христ итгэлт ертөнцөд энэ нь биелэлээ олдог уу? Чуулган эсрэгээр нь иудизмийн тахилчлалын тогтолцоо руу эргэн орсон аж. Итгэгч бүх хүн тахилч мөн гэдэгт итгэдэг гэж хэлэх атал Мосегийн тогтолцоон дээр ихээхэн суурилсан, өөрийн гэсэн тусгай тахилчийн тогтолцоог бий болгосон чуулган олон бий. Ингэж, тэнгэрлэг үйлчлэлд зориулагдан тусгаарлагдсан, энгийн иргэдээс өөрсдийг нь ялгаатай болгож өгдөг өндөр цол гуншинтай, бусдаас өөрийг нь ялгаж өгөх онцгой өмсгөлтэй сүмийн шатлан захирах ёсны зэрэгтнүүдийн бүхэл бүтэн анги бий болсон ажээ.

Мөн чуулган иудизмаас уран нарийн хийцтэй тахилын ширээ бүхий ариун барилга, сүм дуганы гоёл чимэглэл, мөргөлд зориулсан материаллаг тусламж, сүрлэг зан үйл, ариун өдрүүд болон улирлуудыг тэмдэглэсэн шашны хуанли зэрэг хүмүүсийн сэтгэлийг татах зүйлсийг зээлдэн авч хэрэглэх болсон.

Иудизм болон Христ итгэлийг хооронд нь холисон энэхүү муу үзэгдлийн талаар доктор Скофилд ийн бичсэн байдаг. “Христийн чуулганыг иудичлах нь өөр юунаас ч илүү түүний өсөлт хөгжлийг сааруулж, ажил үйлчлэлийг гажуудуулж, сүнслэг байдлыг үгүй хийдэг гэж хэлэхэд болно. Ийм байдалд орсон чуулган дэлхий ертөнцөөс салж, тэнгэрлэг дуудлагынхаа дагуу Эзэнийг дагах тавилант замаа орхидог бөгөөд өөрийн зоригийг хорвоогийн соёл иргэншил, эд баялаг худалдан авах, сүржин зан үйл, сүмийн агуу сүрлэг байшин, мөргөлдөж буй цэргийн хүчүүдийн дээр ивээлээ хайрлахыг Бурханаас гуйх, эн тэнцүү ах дүүсийн барилдлагыг “санваартан”, “энгийн хүмүүс” хэмээн хуваах зэрэг рүү эргэснийгээ зөвтгөхийн тулд иудей Бичээсийг ашигладаг”.

## **6. Тэгвэл яах ёстой вэ?**

Бурхан өнөө үед чуулганыг Эзэн Есүсийн нэрээр тусгаар байдлаа олохын тулд энэ мэт шашны сүг сүүдрээс хол байхыг чуулганаас хүсдэггүй гэж үү? Зөвхөн ийм чуулган л Шинэ Гэрээнд заасан бүх нийтээрээ тахилч байх ойлголтонд багтах ба энэ бол Эрик Соерын бичсэнээр:

“сүнсээр дүүрэн, залбирлын цуглаанд тогтмол сайн оролцдог чуулган юм.”

“Дэлхийг хамарсан ургацын талбайд Эзэний зарц нартай хамт ажилладаг бодит туслагчид ба хамтран зүтгэгч гишүүдтэй чуулган юм”

“Ном товхимол тараах, өөрийн биеэр гэрчлэн ярих, боломж олдох бүрт гадаа гудамжинд хүмүүст сайн мэдээ ярих зэргээр сайн мэдээг дэлгэрүүлэх үйл ажиллагаанд

эрч хүчтэй, идэвхтэй, цөхрөлтгүй оролцдог чуулган юм”

“Хүн бүр харилцан бие биедээ энэрэнгүй сэтгэлээр санаа тавьж туслахыг хичээдэг, залбирал дотор “бие биеэ сайн үйлсэд хөхүүлэн урамшуулахад анхаардаг”, сүнслэг болон сайхан сэтгэлийн уур амьсгалыг бүрдүүлсэн чуулган юм”

“Ийм чуулганд цугларалт болон үйлчлэл нь Ариун Сүнсний удирдлага дор явагддаг ба Эзэний Өөрийнх нь тараан өгсөн сүнслэг бэлгүүд Бурханы өгсөн олон янзын хэлбэр, ах дүүсийн нөхөрлөл, Христэд түшиглэх байдал болон Сүнсний ариун эрх чөлөөн дотор хөгжин цэцэглэдэг (1 Коринт 12:4-11, 14:26). Чуулган нь Голготад өргөгдсөн тахилчлалын өргөлийг магтан дуулсаар Эзэний ширээний өмнө хуран чуулахад тахилчлалын магтаал хүндэтгэл тэнгэр дэх ариун газар хүртэл өргөгдөх ба ингэснээр бүх нийтээрээ чуулганы тахилч байх онцгой эрх өргөмжлөн дээдлэгддэг”

## **7. Урагш тэмүүлэхүй**

Тахилчлалын тухай өгүүлсэн энэ хэсэгт бид орон нутгийн чуулган тус бүрдээ тусган харуулахыг хичээх ёстой даяар чуулгантай холбоотой долоон үнэнийг судлах судалгаагаа төгсгөж байна. Үүнтэй холбоотой өөр бусад үнэнүүдийг дурьдаж болох ч эдгээр нь Христийн бүхэл бие ямар байх ёстойг цуглаан нарийн дүрслэн харуулахад хангалттай гэдгийг хэлэхэд илүүц биз ээ. Бид дараа дараагийн хуудаснуудад чуулганы зан үйл, залбирлын цуглаан, харгазагч болон үйлчлэгчид, чуулганы санхүү, эмэгтэйчүүдийн ажил үйлчлэл зэргийг үзэх болно. Эцэст нь “Христийн зүг урагшаа” гэсэн гарчигтай төгсгөлийн хичээл бий.

## **Баптисм**

Христ итгэлт чуулганы гүйцэтгэх ёстой хоёр зан үйл бий. Энэ бол баптисм ба Эзэний зоог юм. Энэ хоёр зан үйл хэрхэн эхэлснийг Сайн мэдээний номуудаас (Матай 28:19, Лук 22:19-20), эдгээрийг эртний итгэгчид хэрхэн хэрэгжүүлж байсныг Үйлс номоос (Үйлс 10:47-48, 20:7), хэрхэн



нарийвчлан тайлбарлагдсаныг захидлын номуудаас (Ром 6:3-10, 1 Коринт 11:23-32) олж болно.

## **1. Гурван төрлийн баптисм**

Шинэ Гэрээнд баптисмын гурван гол төрлийг бичсэн байдаг.

Нэгдүгээрт, Иоханы баптисм гэж бий (Марк 1:4). Иохан нь ирж буй Хааны зарлагын ёсоор израилийн ард түмнийг гэм нүгэлдээ гэмшиж, гэмшилд зохистой үр жимс ургуулахыг уриалж байсан (Матай 3:8). Гэм нүглээ гэмшин хүлээн түүн руу очиж байсан хүмүүс гэмшил рүү баптисм хүртэж байсан ба ингэснээр өөрсдийгөө израиль үндэстний бурханлаг бус байдлаас салгаж байв. Эзэн Есүс Иоханаар баптисм хийлгэсэн нь гэмших ёстой гэм нүгэлтэй байсандаа биш харин израилийн гэмшиж буй хүмүүстэй нэгдэхийн тулд мөн түүнчлэн бүх зөвт байдлыг гүйцэлдүүлэхийн тулд байсан юм (Матай 3:15).

Хоёрдугаарт, итгэгчдийн баптисм гэж бий (Ром 6:3,4). Энэ нь Христийн үхэлтэй нэгдсэн нэгдлийг илэрхийлдэг ба дараа бид дэлгэрүүлж үзэх болно.

Гуравдугаарт, Ариун Сүнсний баптисм гэж бий (1 Коринт 12:13). Энэ бол Бурханы Сүнсний агуу дээд үйлс бөгөөд энэ нь Аврагч Эзэнд итгэсэн бүх хүнийг Христийн бие рүү нэгтгэдэг.

## **2. Чухал ялгаа**

Дээр дурьдсан гурван төрлийн баптисмтай холбоотой дараах зүйлсийг анхаарах нь чухал:

- Иоханы баптисм Сүнсний баптисмаас өөр юм. Энэ хоёрын ялгааг Матай 3:11-г тодорхой бичсэн байдаг.
- Иоханы баптисм итгэгчдийн баптисмаас өөр юм. Иоханы дагалдагчийн ёсоор хэдийнээ баптисм хүртсэн хүмүүс Христэд итгэгчдийн баптисмыг дахин хийлгэх ёстой болсон тухай Үйлс номын 19:1-5 –д өгүүлдэг.

- Ариун Сүнсний баптисм итгэгчдийн баптисмаас өөр юм. Усан баптисмыг Сүнсний баптисмын дүр зураг гэсэн бүдэг бадаг ойлголттой хүн олон бий. Үнэндээ бол тэс ондоо зүйлс юм. Итгэгчийн баптисм нь үхлийн билэгдэл байдаг бол Сүнсний баптисм нь Христийн биетэй нэгтгэн нийлүүлэх үйлдэл байдаг.

Товчхондоо, баптисмын энэ гурван төрөл өөр хоорондоо ялгаатай бөгөөд хооронд нь хольж хутгаж болохгүй.

### **3. Итгэгчдийн баптисм**

Пентекостын өдрөөс хойш Эзэн Есүст итгэдэг хүмүүсээс өөр баптисм хүртсэн хүмүүсийн тухай Шинэ Гэрээнд өгүүлсэн зүйл ганц ч байхгүй. Дараах ишлэлүүдийг ажиглан харж уншина уу: *“Ийнхүү түүний үгийг хүлээн авсан хүмүүс баптисм хүртэцгээв”* (Үйлс 2:41), *“Харин Бурханы хаанчлал болон Есүс Христийн нэрийн тухай сайн мэдээг тунхагласан Филипп итгэсэн эрэгтэй, эмэгтэй олон хүмүүс баптисм хүртэцгээж байлаа”* (Үйлс 8:12). Нэгэн гэр бүлийн гишүүд бүгд баптисм хийлгэсэн тухай бичсэн байдаг нь үнэн ч (Үйлс 16:15, 1 Коринт 1:16) тухайн гэр бүлд Эзэн Есүст хэзээ ч итгэж байгаагүй хүүхдүүд байсан гэж бодож болох зүйл ганц ч байхгүй.

### **4. Түүний ач хобогдол**

Итгэгчдийн баптисмын гол утга санааг Ром 6:10-д хамгийн тод томруунаар гарган бичсэн байдаг. Уг сургаалыг доорх маягаар товчлон дүгнэж болох юм: Есүс үхээд Бурханы уур хилэнгийн хүчтэй давалгаа, долгион дунд орсон (Дуулал 42:7). Ингэхдээ биднийг төлөөлсөн аж. Христ үнэхээр биднийг орлон нас барсан тул Түүнийг үхэхэд бид хамт үхсэн гэж хэлж болно. Есүс ингэж үхэхдээ гэм нүгэлтэй холбоотой бүх асуудлыг бүх хүний өмнөөс нэг мөсөн шийдсэн. Тиймээс бид гэм нүглийн бүх асуудалд үхсэн аж. Бид гэм нүгэлд дахин захирагдахаа больсон хэрэг (Ром 6:14). Бурхан итгэгч хүн бүрийг Христтэй хамт цовдлуулсан хэмээн үздэг ба махан биедээ, гэм нүгэл дотор байсан хүн загалмай дээр цовдлогдсон ажээ (Галат 2:20, Колоссай 2:14-15).

Итгэгч хүн энэ бүх болсон явдлыг баптисмаар дүрслэн харуулдаг. Усан дор орсноор "Гэм нүгэлтэй миний бие үхвэл зохих байсан. Гэвч Есүсийг нас барахад би хамт үхсэн. Миний хуучин хүн буюу хуучин би Түүнтэй хамт цовдлогдсон. Есүс оршуулагдахад би ч бас оршуулагдсан ба өдөр тутмын амьдрал дээр миний хуучин би Бурханы нүднээс үүрд зайлуулагдах ёстойг би одоо ойлгон хүлээн зөвшөөрч байна" хэмээн хэлж буй хэрэг юм. Дараа нь, Есүс үхлээс амилсаны адилаар итгэгч хүн баптисмын уснаас "амилан" гарч ирдэг. Ингэснээр, шинэ амьдралаар амьдрах шийдвэрээ илэрхийлэн харуулдаг. Үүнээс хойш итгэгч хүн өөрийн тааллаар амьдрахаа больж амьдралаа Аврагч Эзэнд өгдөг ба ингэж Аврагч Эзэн тухайн итгэгчийн амьдралаар дамжуулан амьдардаг.

Иймээс баптисмыг өмнө байсан амьдралын хэв маягийг эцэслэн дуусгаж буйг илэрхийлэх зан үйл гэж хэлж болно. Баптисм бол тухайн итгэгчийг Христтэй хамт үхсэнийг дүрсэлдэг, Эзэний хүсэлд дуулгавартай захирагдаж буйг олон нийтэд харуулдаг үйлдэл юм (Матай 28:19,20). Баптисмд авралын ямар нэгэн хүч байхгүй бөгөөд харин авралыг хэдийнээ авсан итгэгч хүнд зориулагддаг.

## **5. Баптисм хийх аргачлал**

Баптисмыг яаж хийх ёстой вэ, ус цацах байдлаар уу эсвэл усанд живүүлэн дүрэх байдлаар хийх үү гэсэн асуултын талаар эцэс төгсгөлгүй маргаан өрнөсөөр ирсэн. Үүний хариуг олоход дараах баримтууд тустай байх болно. "Баптисм" гэдэг нь "дүрэх, умбах, угаах" гэсэн утгатай грек үгнээс үүссэн ажээ. Христ хэрхэн баптисм хүртсэн тухай Библид ийн бичсэн байдаг: *"Есүс баптисм хүртээд, голын уснаас тэр даруй гарах үед тэнгэр заагдаж, Бурханы Сүнс тагтаа лугаа адил бууж, Түүн дээр ирэхийг тэр хараа"* (Матай 3:16). Иохан *"Салимын ойролцоо Аенонд баптисм хүртээж байв. Учир нь тэнд ус ихтэй ажээ"* (Иохан 3:23). Этиопын тайган амбаны хийлгэсэн баптисмд Бичээс анхааралтай хандаж *"тэд хоёулаа ус уруу орж, Филип түүнд баптисм хүртээжээ. Тэд уснаас гарч ирэх үед..."* гэсэн байдаг. Баптисм нь оршуулгыг дүрсэлсэн дүр зураг гэдийг бид үзсэн (Ром 6:3). Усанд булхуулан дүрэх үйлдэл

оршуулгын дүр зургийг нарийн сайн дүрслэн илэрхийлж чаддаг бол усаар цацах үйлдэл үгүй аж.

## **6. Анхаарвал зохих чухал зүйл**

Гэвч баптисмын арга хэлбэрээс илүү чухал зүйл бол баптисм хийлгэж буй хүний зүрх сэтгэлийн байдал юм. Усанд булхуулан дүрүүлсэн боловч жинхэнэ ёсоор баптисм хүртээгүй хүн олон бий. Жинхэнэ ёсоор баптисм хүртсэн хүн гэж зүгээр нэг баптисм хүртэх зан үйлийг ил гүйцээсэн биш харин махан бие буюу хуучин мөн чанараа үхүүлсэн гэдгээ амьдралаараа илтгэн харуулдаг хүн юм. Баптисм нь зөвхөн ил харагдах үйлдэл төдийгүй бас зүрх сэтгэлийн асуудал байх ёстой. Ром 2:25-29-д өгүүлсэн хөвч хөндөлтийг баптисмаар солин өөрчилсөн гэвэл илүү хурц илэрхийлэгдэх болов уу. “Хэрэв та Хуулийг биелүүлбэл баптисм тустай ажээ. Харин та Хуулийг зөрчигч бол таны баптисм баптисм биш болдог. Тиймээс хэрэв баптисм хүртээгүй хүн Хуулийн шаардлагуудыг сахивал тэр хүнийг баптисм хүртээгүй бус харин баптисм хүртсэн гэж үзэх бус уу? Баптисмыг биедээ хийлгээгүй хүн хэрэв Хуулийг сахивал, Хуулийн үсэг болон баптисмтай атлаа Хуулийг зөрчигч таныг шүүх бус уу? Учир нь гаднах байдлаараа иудей нь иудей хүн биш бөгөөд махан биеийн гаднах баптисм нь ч баптисм биш. Харин доторх байдлаараа иудей нь иудей хүн мөн. Үсгээр бус, Сүнсээр хийлгэсэн зүрх сэтгэлийн баптисм нь баптисм мөн. Тэр хүний магтаал нь хүнээс бус, харин Бурханаас ирдэг юм”

## **7. Зан үйлийг гүйцэтгэх нь**

Баптисмыг Бурханаар томилогдсон сайн мэдээний үйлчлэгч хүн хийх ёстой гэсэн санаа бол Бичээсийн дагуу санаа биш юм. Итгэгч ямар ч хүн өөр нэг итгэгч хүнд баптисм хүртээж болно.

## **Гарах золиосыг тооцож үзэх нь**

Чуулганы эхэн үед баптисм хийлгэсэн итгэгч хүн тэр даруй хавчигдан гадуурхагдах буюу алуулах нь их байсан. Гэсэн ч шинээр аврагдсан хүмүүс тарчлал зовлон эдлэгсдийн эгнээнд орохоор эргэлзэж тээнэгэлзэлгүй урагш алхан гарч баптисм хийлгэдэг байсан.

Өнөө үед ч зарим газар нутагт баптисм нь аймшигт хавчилгын эхлэлийг илэрхийлэх нь бий. Олон улс оронд итгэгч хүн зөвхөн амаараа Христийг хүлээн зөвшөөрөхөөс өөр аргагүйд хүрдэг. Баптисм хүртэх замаар Христийнх гэдгээ мөн өнгөрсөн амьдралаа таягдан хаяж байгаагаа олны өмнө харуулах бүрд загалмайн өстөн дайснууд тэдний эсрэг дайтаж эхэлдэг.

Гэсэн ч, төлөх үнэ ямар байхаас үл хамааран баптисм хийлгэсэн хүн этиоп тайганы тухай “*баяр баясалтайгаар замд гарчээ*” (Үйлс 8:39) хэмээн бичсэнтэй адил баяр баясгаланг амсдаг.

## БУРХАНЫ ӨМНӨ ОЧИХ НЬ

### Эзэний зоог

Эзэн Есүсийг дурсан санах энэхүү агуу үйлийг Өөрийг нь барьж өгсөн тэр өдөр эхлүүлсэн аж. Тэрээр дагалдагчидтайгаа хамт сүүлчийн удаа Дээгүүр өнгөрөх баярыг тэмдэглэж байхдаа Эзэний зоог хэмээн бидний нэрлэдэг энэ зан үйлийг анх танилцуулсан юм. *“Тэр талх авч, талархал өргөөд, тэдэнд хуваан өгөхдөө —Энэ бол та нарын төлөө өгөх Миний бие мөн. Намайг дурсаж үүнийг үйлд гэж айлдав. Тийн идэцгээсний дараа Тэр мөн аяга авч, —Энэ нь та нарын төлөө асгагдах Миний цусаар тогтоох шинэ гэрээ юм”* (Лук 22:19-20).

### 1. Эзэний зоогийг яах гэж барьдаг вэ?

Уг зан үйлийн чухал ач холбогдолтой холбоотой зарим баримт нотолгоо байдаг. Аврагч Эзэн маань: “Намайг дурсаж үүнийг үйлд” гэсэн. Энэ бол Түүний эдэлсэн зовлон, үхэл, Өөрийгөө өргөсөн өргөл, урсгасан цусыг дурсан санах цаг юм. Энэ үеэр Эзэний зоогийг барьж буй итгэгчид Есүсийг цовдолсон “Гавал” хэмээх газар болсон явдлыг дурсан санах ба энэ нь улмаар түүнтэй холбоотой ариун бүхнийг сануулж өгдөг. Тиймээс, Эзэн Бурханд магтаал ба хүндэтгэлийг өргөхгүйгээр Эзэн Есүсийн амссан асар их зовлонг дурсан санах аргагүй. Ийм учраас Эзэний зоог бол хийсэн бүхнийх нь төлөө Эзэн Бурханд хүндэтгэл өргөх, Бурханыг олны өмнө ил тодоор магтан хүндлэх цаг юм.

Эзэний зоог бол Христийн биеийн эв нэгдлийг харуулах үйлдэл юм. Талхаар бүх итгэгчдээс бүрдсэн Христийн биеийг дүрсэлдэг. Талхнаас авч байгаа итгэгч хүн бүр өөрийгөө Бурханы жинхэнэ хүүхдүүдийн нэг гэдгийг гэрчлэн баталж буй хэрэг. Аяганаас уух нь Есүсийн ариун нандин цусаар угаагдсан хүмүүсийн нэг гэдгээ ойлгон, хүлээн зөвшөөрч буй хэрэг юм (1 Коринт 10:16-17).

Эзэний зоог нь Өөрийгөө дурсан сануулахын тулд түүнийг эхлүүлсэн Тэр Нэгэн удахгүй эргэж ирнэ гэдгийг байнга сануулдаг. *“Учир нь энэ талхыг идэж, энэ аяганаас уух бүрдээ та нар Түүнийг ирэх хүртэл Эзэний үхлийг тунхагладаг”* (1 Коринт 11:26).

Тиймээс Эзэний зоог барьж буй хүн зөвхөн арагш харан “Гавал” хэмээх газар Эзэн Есүс хэрхэн нас барсаныг эргэн дурсах биш, зөвхөн дээш Бурханы сэнтий өөд харан хийж гүйцээсэн авралынх нь төлөө Түүнд магтаал өргөх биш, харин урагш Эзэн Есүс тэнгэрээс буун ирж Өөрийг нь хүлээн буй хүмүүсийг Өөрийнхөө байгаа газар буюу Ариун орон уруу авч явах тэр мөчийг хардаг.

## **2. Эзэний зоогийг барих давтамж**

Эзэний зоогийг хэзээ, ямар давтамжтай хийж байх тухай Бичээст хуулийн хэлээр биш харин нигүүлслийн хэлээр бичсэн байдаг. Үйлс 20:7-д *“Долоо хоногийн эхний өдөр талх хуваахаар хамтдаа цуглах үед....”* гэжээ. Долоо хоногийн эхний өдөр бол Эзэний өдөр буюу Ням гараг юм. Энэ бол Эзэн Есүсийн үхлээс амилсан өдөр тул дагалдагчид нь магтаал хүндэтгэл өргөж, Түүнийг дурсан санахаар цуглахад тохирох өдөр ажээ. Библид *“...энэ талхыг идэж, энэ аяганаас уух бүрдээ...”* (1 Коринт 11:26) гэсэн байдаг. Эзэний зоогийг долоо хоног бүр эсвэл сар бүр эсвэл улиралд нэг удаа гэж хэлэх хүн Библи дээр өөрийн санааг нэмж байгаа хэрэг. Мөн түүнчлэн эртний дагалдагчид Эзэнийг дурсахаар долоо хоног бүр цугладаг байсан байх магадлал өндөр юм.

Эзэний зоогийг долоо хоног бүр барих тал дээр Чарльз Хаддон Спержен хатуу зогсож ийн бичсэн байдаг. “Зөвхөн миний бие төдийгүй бас долоо хоног бүр талх хуваахаар цугладаг итгэгч өөр олон хүн, түүний ач холбогдол алдагдаагүй харин ч үргэлж шинээрээ байдаг гэдгийг батлан хэлж чадна. Энэ өдөр чухам юуны тухай ярьсан ч, Синаи уул толгой дээгүүр нүргэлж, “Гавал” хэмээх газар болсон явдлын сэтгэл өвтгөм түүх зүрх сэтгэлийг хөндсөн ч эцэстээ талх хуваах нь зүй ёсных байдаг. Эзэний зоогийг сард нэг удаа болгон хойш тавьдаг чуулган ичгүүртэй аж. Тэд нөхөрлөж, талх хувааж, Эзэн Есүсийг дахин ирэх хүртэл

Түүний үхлийг тунхаглахаар цугладаг долоо хоногийн эхний өдрийн суу алдрыг үгүй хийн сэвтүүлж байна. Эзэний зоогийг барьдаг Эзэний өдрийн сайхныг нэгэнтээ амсаж мэдсэн хүмүүс түүнийг жилийн дөрвөн улирлаас бага болгохыг яагаад ч зөвшөөрөхгүй гэж би баттай итгэдэг.”

Жонотан Эдвард, Эзэнийг дурсан санах үйлийг долоо хоног бүр хийх явдлыг өмгөөлөн ийн бичжээ. “Эртний итгэгчид өөрсдийн дотны хайртай Чөлөөлөгчийн эдэлсэн зовлонг дурсан санах үйл хэргийг Эзэний өдөр бүр тэмдэглэж байсныг Бичээст тодорхой өгүүлсэн байдаг ба ирэх өдрүүдэд ч Христийн чуулган үүнийг тийнхүү тэмдэглэнэ гэдэгт би итгэдэг” гэсэн байдаг.

### **3. Эзэний зоогт оролцох эрхтэй хүмүүс**

Эзэний зоог зөвхөн итгэгч хүмүүст зориулагдсан гэдгийг дурьтах бараг шаардлагагүй биз ээ. Эзэний авралаар чөлөөлөгдсөн хүмүүс л түүний ариун утга учрыг ойлгож чадна. Түүнд оролцож буй итгэгч хүн өөрийгөө шалган шүүх ёстой (1 Коринт 11:28). Гэм нүлээ гэмшин хүлээж, түүнийг орхих ёстой бөгөөд талхыг зөв зохистойгоор авч хэрэглэх учиртай (1 Коринт 11:21). Өөрийгөө шалган шүүхгүйгээр Эзэний зоогт оролцсон хүн Эзэний шийтгэлийг хүртэх аюултай (1 Коринт 11:27, 29-32).

Эзэнийг жинхэнэ ёсоор дурсан санахгүйгээр талхнаас идэж, дарснаас ууж мэдэх магадлалтай гэдгийг өөртөө дахин сануулах нь чухал. Хийж байгаа зүйлдээ зүрх сэтгэлээрээ хандахгүй байх нь Эзэний зоогийг жирийн нэг ёс төдий зүйл болгон бууруулах магадлалтай аж. Хэрэв бид “Намайг дурсан сана” гэсэн Бурханы үгийг үнэхээр дуулгавартай биелүүлдэг бол амьдрал маань Бурхантай харьцах нөхөрсөг харьцаатай байх болно.

### **Залбирлын цуглаан**

Орон нутгийн чуулгануудтай холбоотой мэдээ мэдээлэл Шинэ Гэрээнд нэг их байхгүй. Итгэгчид нөхөрлөж, залбирч, Бурханы Үгийг дамжуулж, талх хуваахын тулд цугладаг байсныг бид ямар ч байсан мэднэ (Үйлс 2:42). Гэвч үүнээс цааш хөшиг татсан мэт бүрхэг аж. Сайн мэдээг аврагдаагүй хүмүүст хүргэх ажлыг цуглааны хил хязгаарын гадна талд



байдаг итгэгч хүмүүс хийсээр ирсэн мэт боловч тэд аврагдсан хүмүүсийг орон нутгийн чуулганы нөхөрлөлд аваачих бодолтойгоор үүнийг хийдэг билээ.

Эртний чуулгануудын бүх цугларалтуудаас залбирлын цугларалтаас илүү тогтмол, байнга хийгддэг цугларалт гэж байгаагүй. Үнэндээ бол, чуулган анх залбирлын цуглааны сэргэлтээс төрсөн (Үйлс 1:14) бөгөөд түүнээс хойш итгэгчид “...байнга .....залбирцгааж байлаа” (Үйлс 2:42). Чуулганы түүх бүхэлдээ залбиралд хариулдаг Бурханы итгэмжит байдалтай холбоотой ажээ.

## **1. Тусгай амлалт**

Хамтын залбирал зөвхөн тэнгэрлэг баталгааг дагуулах төдийгүй Эзэний Өөрийнх нь оршихуй бидэнтэй хамт байна гэсэн тусгай амлалтыг тээдэг гэдгийг бид үргэлж, сайн санах ёстой. Матай 18:19-20-д ийн бичжээ: “*Би та нарт дахин хэлье. Хэрэв та нараас хоёр чинь ямар нэгэн зүйлийг гуйх талаар газар дээр санаа нийлбэл, тэнгэр дэх Миний Эцэг үүнийг чинь тэдний төлөө биелүүлэх болно. Учир нь хоёр буюу гурван хүн Миний нэрээр хаана цуглана, тэнд Би тэдний дунд байна гэж айлдав*” Үүнээс илүү ойлгомжтой хэлнэ гэж бараг үгүй биз ээ. Энд хоёр амлалт өгөгдсөн аж: Нэгдүгээрт, Итгэгч хоёр хүн нийлэн гуйлтаа Эзэн Бурханд өргөвөл тэр гуйлтанд Эзэн заавал хариулна. Хоёрдугаарт, итгэгч хүмүүс Эзэн Есүсийн нэрээр цугларвал Эзэн Есүс тэнд, тэдний дунд байна. Үүнд бид итгэж өгдөггүй нь л гол зовлон юм. Хэрэв бид үүнд эргэлт буцалтгүй итгэдэг бол залбирлын цуглаан маань дүүрч, чуулган маань Бурханд зориулдсан өргөл мэт байх байсан.

## **2. Бүлгээр хийх залбирал**

Бүлгээр хийх залбирлын тухай ярихаас өмнө эхлээд үүнтэй холбоотой энгийн хэдэн зүйлийг таницуулъя.

Нэгдүгээрт, залбирлын цуглаан дээр бүх хүн дотроо залбирах боловч чимээгүй байж нэг хүн удирдан явуулна. Сонсогдохуйцаар залбирч байгаа хүн тухайн бүлгийн залбирлыг илэрхийлэн хэлэхэд бусад нь түүний хэлж байгаа үгийг өөрсдийнх болгон дотроо давтан хэлж

залбирдаг. Залбирч буй хүмүүс нэг санаатай байгаагаа илэрхийлэн “Амен” гэж үе үе хэлнэ.

Хоёрдугаарт, “залбирал хэлэх”, “залбирах” хоёр хоорондоо маш их ялгаатайг тэмдэглэх нь зүйтэй болов уу. Үүний ялгааг тод илтгэн харуулсан хүүхдийн нэг магтан дуу бий. Энэ дуунд ингэж өгүүлдэг:

Заримдаа би залбирал хэлдэг ч  
Үнэндээ би залбирдаг бил үү?  
Амнаас гарах үгс маань  
Амин зүрхний минь хүсэлтэй таардаг бил үү?

Амьд Бурханд өргөхийн адил  
Амьгүй чулуун бурханд мөргөж  
Залбирлын хоосон үгийг өргөж  
Сөгдөн залбирч болох ч

Зүрх сэтгэлээс гараагүй, амьгүй хоосон үгийг  
Амьд Эзэн огт сонсохгүй  
Чин сэтгэлээр залбирдаггүй хүмүүсийн  
Ам хэлний зугаа болохгүй

Зүрх сэтгэлийн чин хүсэл сонирхолыг илэрхийлээгүй цуварсан олон залбирлыг давтан хэлэх залбирлаас өөр залбирлын цуглааныг хурдан үгүй хийх зүйл гэж үгүй. Бид залбирч байна гээд нэг янзын гуйлтуудыг дахин дахин өргөдөг ба ийм гуйлтууд өрөөний таазнаас хэтрэхгүй байх нь их. Шинэхэн итгэгч хүмүүсийн залбирал шинэлэг, гал цогтой байдаг бол итгээд удсан зарим хуучин итгэгч хүний залбирал Бурханд ч, хүнд ч хэрэггүй хоосон хэв загварт баригдсан байх нь бий. “Залбирлыг зөвхөн албан үүрэг мэт үзэн өргөдөг залбирлын цуглааныг хаавал зохино” гэсэн үг байдаг нь тун оносон үг аж.

Залбиралтай холбоотой, зайлсхийвэл зохих өөр нэг зүйл бий. Энэ бол урт залбирал юм. Бичээст “Зогсолтгүй залбир” гэсэн байдаг нь үнэн. Гэвч энэ бол хэн нэгэнд залбирлын цуглааны цагийг ганцаараа давамгайлан эдлэх эрх олгож буй хэрэг биш. Олон янзын хүн товчхон залбирах нь

залбирах сонирхолыг бусдад төрүүлж өгдөг.

Мөн түүнчлэн, бидний гуйлт хүсэлтүүд тодорхой байх ёстой. “Бурхан минь, дэлхий даяар олон хүний сүнсийг авраач” хэмээн залбирахын оронд “Эзэн минь, миний ах Доржийг авраач” хэмээн залбирах нь илүү дээр юм. Тэгвэл Доржийг аврагдах үед залбиралд тань Бурхан хариулсаныг та мэдэж, өөр тодорхой хүмүүсийг нэрлэн залбирах урам зориг төрөх болно.

### **3. Тодорхой бай**

Залбирлын цуглаанууд уйтгартай байх албагүй. Нигүүлслийн ширээнд өргөн барьж болох тодорхой гуйлт хүсэлтүүд олон бий. Заримыг нь жишээ болгон харуулъя:

Дарга, удирдах ажилтан болон бусад эрх мэдэлтнүүдийн төлөө тэдний нэрсийг дурьдан залбирч болно. Тэд аврагдахын төлөө, бас бид өөрсдөө сүсэглэл ба хүндлэлтэйгээр амар тайван, төвшин амьдралаар амьдрахын төлөө залбир (1 Тимот 2:2).

Цулааныхаа өвчин зовлонтой хүмүүсийн төлөө залбир. Хэн өвчтэй байгааг Эзэн мэдэх ч итгэгчид мэдэхгүй байж болох тул нэрсийг нь дуудан залбир.

Аврагдаагүй байгаа садан төрлийн хүмүүс ба найз нөхдийнхөө төлөө залбир. Залбирлын цулаан дээр хайрладаг хүмүүсийнхээ нэрийг дурьдахаас хэзээ ч ичих хэрэггүй. Хэрэв бид тэднийгээ үнэхээр авралтай болгохыг хүсдэг бол цуглааны зүгээс ирэх дэмжлэгийг найр тавин хүлээн авах болно.

Чуулганы ахлагчдын төлөө залбир. Тэд бол мэргэн ухаан ба тэсвэр тэвчээр шаардах чухал үүрэг хариуцлагатай хүмүүс бөгөөд таны гуйлтанд багтах зохистой улс юм.

Танай чуулганаас илгээлт аван гадагш явсан сайн мэдээ дэлгэрүүлэгчдийн төлөө залбир. Хэрэв та тэдэнтэй захидлаар харилцдаг бол тэдэнд ямар бэрхшээл зовлон

тулгарч байгааг, ямар хэрэгцээ гарч байгааг мэднэ.

Хүүхдийн цуглааны төлөө, удирдаж байгаа хүмүүс, багш нар болон Бурханы Үгийг заалгаж байгаа охид хөвгүүдийн төлөө залбир.

Тарчиг ядуу хүмүүсийн төлөө залбир. Хэн нэгний нэрийг дурьдах нь цуглаанд оролцогсдын аль нэгийг ичихэд хүргэх бол нэрийг нь дурьдахгүй байх нь дээр.

Өөрийн цуглаанаас цэргийн алба хаадаг хүмүүсийн төлөө залбир. Тэд аюул осол, сорилт, шалгууртай нүүр тулдаг учраас та бүхний залбирал тэдэнд хэрэгтэй.

Авралын зар тараах, Бурханы Үгийг заах зэрэг Эзэний ажил үйлсийг эрхэлдэг хүмүүсийн төлөө залбир.

Залбиралдаа заавал талархалыг багтаах ёстой. Энэ тухай Филиппой 4:6-д *“Юунд ч бүү санаа зов. Харин аливаа зүйлд залбирлаараа болон гуйлтаараа талархалтайгаар хүсэлтээ Бурханд мэдүүл”* гэж бичсэн байдаг. Эзэн Бурхан Өөрийн хүмүүсээс талархах сэтгэлийг хүлээн авах бүрэн эрхтэй. Түүний хайр өршөөлд үл талархах нь гэм нүгэл юм.

#### **4. Чухал нөхцөл**

Залбирал маань тодорхой нөхцлүүдэд хариулагддаг. Эдгээр нөхцлүүдийг дурьдвал:

Нэгдүгээрт, бид Христ дотор байх ёстой. Эзэн Есүс <sup>7</sup>*Хэрэв та нар Миний дотор, Миний үгс та нарын дотор байвал та нар юу хүссэнээ гуй. Тэгвэл та нарын төлөө биелэх болно”* (Иохан 15:7) гэж хэлсэн. Христ дотор байна гэдэг Түүний тушаалуудыг сахиж, хүслийг хийж, Үгийг нь дуулгавартай дагахыг хэлнэ.

Хоёрдугаарт, Түүний хүслийн дагуу залбирах ёстой. *“Бид Түүний хүслийн дагуу юуг ч гуйсан, Тэр биднийг сонсдог гэдэг нь Түүний өмнө бидэнд байгаа итгэл зориг юм”* (1 Иохан 5:14). Бурханы хүслийн ерөнхий тоймыг Библид өгсөн байдаг тул бидний гуйлт хүсэлт Бичээсийн дагуу байх

ёстой.

Гуравдугаарт, гуйлт хүсэлтүүдээ Эзэн Есүс Христийн нэрээр өргөх ёстой. *“Та нар Миний нэрээр юуг ч гуйсан, Эцэг Хүүгээрээ алдаршуулагдахын тулд Би түүнийг хийнэ”* (Иохан 14:13), *“Үнэнээр, үнэнээр Би та нарт хэлье. Хэрэв та нар Миний нэрээр Эцэгээс минь юу ч гуйвал Тэр түүнийг чинь өгнө”* (Иохан 16:23). Хэрэв бид үнэхээр Есүсийн Нэрээр гуйвал энэ нь Тэр Өөрөө Бурханд хүсэлт гаргаж байгаатай адил юм.

Эцэст нь, Бидний сэдэл цэвэр ариун байх ёстой. Иаков бидэнд *“Та нар гуйгаад хүлээн авдаггүй. Учир нь та нар өөрсдийн тааламжид зарцуулъя хэмээн буруу хандлагаар гуйдаг”* (Иаков 4:3) хэмээн анхааруулсан байдаг.

## **5. Санаж байвал зохих тогтсон хэдэн журам**

Энэхүү бүлгийг төгсгөхөөс өмнө, залбирлын цуглааныг “чуулганы эрчим хүчний өргөө” болгохын тулд хийж болох, болохгүй зарим зүйлсийг дурьдах нь зүйтэй болов уу.

Жишээлбэл, бусдад харуулахын тулд залбирч болохгүй. Хэрэв та санаж байгаа бол, хоёр нүүртэнгүүд өөрсдийгөө хэрхэн албирч буйг хүмүүст харуулахын тулд гудамжны захад зогсоод залбирах дуртай байдаг (Матай 6:5).

Бас өөрийн хүчээр хийж чадах зүйлийг Бурханаас бүү гуй. Бид аврагдаагүй хүмүүсийг сайн мэдээ тараах цуглаанд авчрахыг Бурханаас гуйдаг. Бурхан биднээс тийм хүмүүсийг амаараа урьж, машин унаагаараа авчрахыг хүсдэггүй гэж үү?

Мөн түүнчлэн өөртөө авах ёсгүй гэж бодож байгаа зүйлийг авах гэж Бурханаас бүү гуй. Бурхан ийм хүсэлтийг биелүүлж өгч болох ч сэтгэлийн шаналал зовлонг илгээдэг (Дуулал 106:15).

Залбирлын хариу тэр даруй ирэхгүй байх тохиолдолд итгэл бүү алд. Бурханы хариулт Түүнийг хүлээх ерөөлийг алдагдуулахаар хэт эрт ирэхгүй бөгөөд дэмий хүлээж дээ

гэж цөхрөхөөр хэт оройтож ирдэггүй юм.

Мөн хэрэв Бурханы өгөх хариу таны хүссэн зүйл биш байвал үүнийг сана! Хүссэн зүйлээс маань илүү дээр зүйлийг өгөхөөр хадгалах эрх Түүнд бий. Өөрсдөд маань чухам юу хамгийн сайн байхыг бид мэддэггүй боловч Тэр мэднэ. Тиймээс Тэр бидэнд Өөрөөс нь гуйх болон санаанд маань орох бүх зүйлээс илүү ихийг өгдөг.

Залбиралгүйгээр чуулган жинхэнэ ёсоор өсөж хөгжихгүй гэдгийг эцэст нь онцлон тэмдэглэе. Бид тогтсон ёс журмаар явж ямар нэгэн үр дүнд хүрч болох ч зуучлан залбирах залбиралгүйгээр Бурханы төлөө юу ч хийж чадахгүй. Энэ үнэнийг бид Бичээсээс олж харж чадахгүй бол удахгүй хэрэгцээ шаардлага өөрөө бидэнд үүнийг аяндаа харуулах болно.

## ХАРГАЛЗАГЧИД

Бурханаар томилогдсон, чуулганы сүнслэг байдалд анхаарал тавьдаг хүмүүсийн тухай ярихгүйгээр чуулганы тухай бүрэн гүйцэд ярьж чадахгүй. Энэ ажлыг харгалзагчид буюу ахлагчид хийж гүйцэтгэдгийг бид олж мэдэх болно. Эхлээд, зарим нэг зүйлийг тодруулцгаая.

### Харгалзагч гэж юу вэ?

Юуны өмнө, харгалзагчийн тухай Шинэ Гэрээний ойлголт болон өнөө үед хэрэглэгддэг цол хэргэмийн хоорондын ялгааг олж мэдэх нь чухал. Элч нарын үеийн чуулганд харгалзагч гэж чуулганы сүнслэг байдалд анхаарал тавьдаг, тухайн чуулганы төлөвшсөн итгэгчдийн нэгийг хэлдэг байсан. Өнөө үеийн чуулганы тогтолцоонд харгалзагч гэж томилогдсон, тусгай хэргэм зэрэгтнийг хэлдэг ба тэрээр эрх мэдлийнхээ хүрээнд хэд хэдэн чуулганыг захирдаг. Барнес ийн хэлсэн байдаг: “Шинэ Гэрээнд хэрэглэгдсэн *харгалзагч* гэдэг үг хэзээ ч өнөө үеийн нийтлэг ойлголт болох *ширээт лам* гэсэн утгыг илэрхийлж байгаагүй. 1 Тимот номын 3-р бүлэг болон Шинэ Гэрээний өөр хаана ч харгалзагч гэж аль нэг бүс нутгийн хэд хэдэн чуулганаас бүрдсэн засаг захиргааг хариуцан захирдаг хүнийг хэлсэн зүйл байхгүй”.

Шинэ Гэрээнд харгалзагч гэж Бурхан хүн хоёрыг зуучилдаг тусгай анги давхрагын бүлэг хүн байгаагүй. Элч Паул Филиппой 1:1-д “...Христ Есүс доторх бүх ариун хүмүүст болон *харгалзагчид*, *үйлчлэгч нарт илгээв*” гэсэн нь ирээдүйд харгалзагчийг нэгдүгээрт тавих байдал гарч болзошгүйг Ариун Сүнс анхааруулан түүнийг хоёрдугаарт жагсаан бичсэн байж болох юм.

Шинэ Гэрээнд албаны хүнд сурталтай удирдлагын тухай өгүүлсэн зүйл байхгүй. Харин сүржин цол хэргэмтэй өндөр албан тушаалын оронд Бурханы хүмүүс дунд даруу төлөв

байдлаар үйлчлэх тухай өгүүлдэг. Тиймээс ч “Хэрэв хэн нэгэн нь харгалзагч болохыг эрмэлзвэл, тэр сайн ажлыг хүсдэг хүн байна” (1 Тимот 3:1) гэсэн агаад харгалзагч гэдэг албаны өндөр цол хэргэм биш харин ажил хөдөлмөр юм.

Эцэст нь, “ахлагч”, “харгалзагч” хэмээн орчуулагдсан “bishop”, “elder”, “overseer”, “presbyter” гэсэн англи үгсийг Шинэ Гэрээнд нэг хүнд хамааруулсан байдаг. Үйлс 20:17-д чуулганы “ахлагчдын” тухай өгүүлсэн бол дараахан нь Үйлс 20:28-д мөн тэр хүмүүсийг “харгалзагчид” гэжээ. Тит 1:5-д элч Паул “ахлагчдыг” томилох тухай Титэд хэлээд дараа нь 7-р ишлэлд харгалзагч хүнд тавигдах шаардлагуудыг тоочсон нь “ахлагчид” бол “харгалзагчидтай” адил гэдгийг харуулсан аж.

### **Харгалзагчдыг сонгох нь**

Одоо ахлагчдыг сонгох буюу томилох тухай үзэцгээе. Эцсийн дүнд, хүнийг зөвхөн Ариун Сүнс ахлагч болгож чадна (Үйлс 20:28). Чуулган сүрлэгээр хуран чуулж ахлагчдыг томилж болох ч хүмүүсийн өгөх санал аливаа хүнд харгалзагчийн зүрх сэтгэлийг өгөхгүй. Бичээсийн дэс дарааллаар бол эхлээд Бурхан хүмүүсийг ахлагч болгох ба тэднийг ажил үүргээ гүйцэтгэх явцад чуулган тэднийг тэнгэрээс томилогдсон харгалзагчид мөн болохыг хүлээн зөвшөөрдөг байна.

Элч Паул болон өөр бусад хүмүүс харгалзагчдыг томилж байсан хэмээн маргаж болох юм (Үйлс 14:23, Тит 1:5). Тэгвэл, тэр явдал Шинэ Гэрээ бичгийн хэлбэрээр бий болохоос өмнө байсан гэдгийг хэлэх байна. Чуулганы хувьд ахлагчдад тавигдах шаардлагууд бичгийн хэлбэрээр байхгүй байсан тул чуулган энэ тал дээр элч нарт эсвэл элч нарын төлөөлөгчдөд түшиглэхээс өөр арга байгаагүй. Мөн түүнчлэн Паул аль нэг чуулганд анх удаа очихдоо ахлагчдыг томилж байгаагүйг тэмдэглэх нь зүйтэй. Харин оронд нь, Бурханы томилсон ахлагчдад өөрсдийгөө ажил үйлсээрээ илэрхийлэн харуулах боломж олгон цаг хугацааг өгч байжээ. Дараа нь чуулганаар хүлээн зөвшөөрөгдсөн хүмүүсийг шилэн гаргасан байдаг.



## **Харгалзагчид тавигдах шаардлагууд**

Шинэ Гэрээ жинхэнэ хараглазагч буюу ахлагчид тавигдах шаардлагуудын талаар эргэлзэх зүйл бидэнд үлдээгээгүй. Эдгээр шаардлагуудыг 1 Тимот 3:7 ба Тит 1:6-9-өөс харж болох ба эдгээрийг товчлон дүгнэвэл:

Нэгдүгээрт, харгалзагч хүн гэм зэмгүй байх ёстой. Түүний нэр хүнд өндөр байх ёстой аж. Харгалзагч хүнийг гэм нүгэлгүй байх ёстой гээгүй харин гэм зэмгүй байх ёстой гэжээ. Хэрэв түүнийг олон нийт буруутгавал харгалзагчийнх нь үүргээс түдгэлзүүлэх ёстой.

Хоёрдугаарт, харгалзагч хүн нэг эхнэртэй байх ёстой. Зарим хүн үүнийг заавал гэрлэсэн хүн байх ёстой гэж ойлгодог байхад зарим нь үүнийг олон эхнэртэй байх үзлийг дэмжигч хүн харгалзагч болохын эсрэг тавьсан хориг гэж үздэг. Хоёр дахь нь яах аргагүй үнэн. Гэвч эхнийхийг ягштал баримтлана гэвэл бас хэцүү аж.

Дараа нь, харгалзагч хүн түргэн зантай байж болохгүй. Тэрээр биеэ барьж чаддаг байх ёстой. Зарим хүнд биеэ барих хэцүү байдаг ба тийм хүмүүс үргэлж хэт туйлшрах нь бий. Ийм хүмүүс чуулганд байж болох ч харгалзагч байж болохгүй.

Ахлагч хүн эрүүл сэтгэлгээтэй байх ёстой. Итгэгч хүний амьдрал бол зүгээр нэг хобби биш, хөнгөн зугаа биш гэдгийг амьдралаараа гэрчлэн харуулах ёстой. Ахлагч хүн мөнхийн ач холбогдолтой зүйлтэй зууралддаг.

Ахлагч хүн сайн зан байдалтай буюу өөрөөр хэлбэл, “эмх цэгцтэй” байх ёстой. Хайхрамжгүй, хайш яайш хүн эмх журмын өргөөнд үйлчлэхэд зохимжгүй юм.

Ахлагч хүн “зочломтгой” буюу “зочин хүлээн авах дуртай” байх ёстой. Орон гэр нь Есүсийн зочлон очих дуртай байсан Бетаны Лазар, Марта, Мариа нарын орон гэр шиг Эзэний хүмүүст үргэлж нээлттэй байх ёстой.

Харгалзагч хүн заах чадвартай байх ёстой. Багшлах гоц авьяас бэлэггүй байсан ч Бурханы хүмүүст хэцүү цагт туслаж чадахуйцаар Бичээсийг хангалттай сайн мэддэг

байх ёстой.

Архи дарсанд шунадаггүй буюу Библийн өөр орчуулгуудад өгүүлсэнчлэн “хэрүүлч” биш байх ёстой. Энэ хоёр хоорондоо холбоотой аж. Дур хүслээ захирч чаддаггүй хүн чуулганы итгэл найдвар хүлээх байр сууринд тохирохгүй.

Тэрээр зодоонч биш байх ёстой. Өөрөөр хэлбэл, хүч хэрэглэгч байж болохгүй. Жишээ нь, дагалдагчаа зодох нь ахлагч хүнд байж болшгүй зан юм.

Ахлагч хүн олз ашигт шунахайрдаггүй байх ёстой. Жинхэнэ харгалзагч хүн мөнгийг Эзэний төлөө, Түүний хүсэл сонирхлыг хөгжүүлэхийн төлөө ашиглах ёстойг ойлгодог. Харамч, шунахай итгэгч хүн өөрөө зөрчил юм.

Ахлагч хүн тэвчээртэй байх ёстой. Түүний Их Эзэн номхон зөөлөн байсан ба зарц нь Эзэнээсээ илүү биш билээ. Номхон зөөлөн байдал, тэвчээртэй зан энэ дэлхийн хувьд тийм ч сайн зүйл биш байж болох ч Бурханы Хаанчлалд сайн зүйл юм.

Тэрээр хэрүүлч буюу хэл амтай байж болохгүй. Зарим хүн гар өргөх төдийд зодолдоход бэлэн, өчүүхэн жижиг зүйл дээр ч маргамтгай байдаг. Харгалзагч хүн ийм байж таарахгүй.

Ахлагч хүн шунахай байж болохгүй. Шунана гэдэг өөрт нь Бурханы өгөөгүй зүйлийг авах хүсэл юм. Шунана гэдэг хиймэл шүтээн шүтэхтэй адил бөгөөд өөрийн хүслийг Бурханыхаас дээгүүр тавьж буй хэрэг.

Ахлагч хүн өөрийн гэрийг сайн захирч чаддаг, итгэгч, дураар авирладаггүй буюу даруулгагүй биш хүүхдүүдтэй, тэднийг төлөв байдал дотор дуулгавартай байлгадаг байх ёстой. Яагаад ийм шаардлага тавигдаж байгаа нь тодорхой аж. Учир нь Библид *“Хэрэв хүн өөрийн гэрийг хэрхэн захирахыг мэдэхгүй бол яаж Бурханы чуулганыг халамжлах билээ?”* (1 Тимот 3:5) гэсэн байдаг.

Ахлагч нь шинэхэн итгэгч байж болохгүй “Ахлагч” гэсэн үг ч энэ санааг илэрхийлж байна. Сүнсний төлөвшил нэн чухал.

Насны тоо олон байж болох ч итгэгч хүний хувьд туршилгагүй учир сүнслэг байдлын харгалзагч болох шаардлага хангахгүй. Шинэхэн итгэгч хүнийг харгалзагч болгох аваас бардам зангаар биеэ тоож муу ёрын сүнсний шийтгэлд унаж болох талтай.

Чуулганы гадна байгсадын дунд буюу итгэгч биш хүмүүсийн дунд сайн нэр хүндтэй байх ёстой. Дэлхий ертөнц түүнийг итгэгч зан чанартай, шударга үнэнч хүн гэж мэддэг байх ёстой.

Мөн түүнчлэн дураараа авирладаггүй, түргэн уурладаггүй, сайн бүхэнд дуртай, шударга бөгөөд ариун байх ёстой. Эцэст нь, Бурханы Үгнээс итгэмжтэйгээр бат барьдаг, итгэлийг өмгөөлөгч байх ёстой.

Ахлагч хүнд тавигдах шаардлагуудыг эцэслэн дүгнэхийн тулд тэрээр өөрийгөө болон гэр орноо захирах чадвартай, Бурханы Үгийн төлөө тэмцэгч байх ёстойг хэлэх нь зүйтэй.

Библид ахлагч хүнийг сахил хүртсэн санваартан эсвэл их сургуулийн дипломтой эсвэл амжилтанд хүрсэн бизнесмэн хүн байх ёстой гэж хэлээгүй. Ахлагч хүн олон нийтэд алдартай эсэх нь чухал биш. Түүний гадаад төрх ямар байх эсвэл хэтэвч нь нимгэн, зузаан байх талаар өгүүлсэн зүйл ганц ч байхгүй. Тэрээр бөгтөр, эв хавгүй, ядуу тарчиг, гудамжны хөгшин хог цэвэрлэгч байж болох ч Бурханы чуулганы ахлагч байх боломжтой. Өнөө үед сүнслэг байдалд тавигдах шаардлага хангаагүй хүнийг чуулганы ахлагчаар хүлээн зөвшөөрдөг нь чуулганыг асар ихээр мөхөөж буй зүйлсийн нэг гэдэг нь эргэлзээгүй юм. Хэн нэгэн хүнийг бизнест амжилт олсон учраас сүнслэг байдал нь ямар байхаас үл хамааран түүнийг чуулганы удирдлагад тавих нь бий. Үүний дүнд мөнгөөр худалдан авч болох бүхнийг элбэг хангалуунаар олж авч болох ч сүнсний хүч үгүй болох болно.

### **Харгалзагч хүний албан үүргүүд**

Ахлагч хүн ямар албан үүргүүдтэй вэ?

Нэгдүгээрт, Бурханы хүмүүсийг хариулах үүрэгтэй (1 Петр

5:2, Үйлс 20:28). Үүнийг Бурханы Үгийг дамжуулах замаар хийх ба заавал олон нийтэд биш харин айлаас айлд очих замаар хийж болно.

Хоёрдугаарт, ахлагчид харгалзагчийн хийдэг ажлыг хийх ёстой. “Харгалзагчийн ёсоор үйлчил” гэж Петр бичсэн байдаг. Тэгвэл энэ ямар утгатай вэ? Ямар утгатай, ямар утгатай биш болохыг 1 Петр 5:2-4-т тайлбарласан аж. Энэ бол албадлагаар бус харин сайн дураар хийх үйлчлэл байх ёстой гэсэн утгатай. Мөнгөний ашиг сонирхолын төлөө биш харин хичээл зүтгэлээр хийх ёстой гэсэн утгатай. Бурханы хүмүүсийг ноёлох ёстой гэсэн утгатай биш. Ахлагч бол дарангуйлагч ч, бригадын дарга ч, захирал ч биш юм. Ахлагч байна гэдэг Бурханы хонин сүрэгт үлгэр дуурайл болно гэсэн үг. Сайн Хоньчин маань хонин сүргээ дагуулж биш харин дагаж явдгийг ахлагч хүн санаж байх ёстой бөгөөд Сайн Хоньчины доорх хоньчин бүр мөн тийнхүү үйлдэх ёстой. Хүний үзэл бодлоор бол удирдах зөвлөлөөс захирамж тушаал гаргаж түүнийг нь үг дуугүй даган биелүүлдэг байхын тулд чуулганд төвлөрсөн удирдлагыг бий болгох нь илүү хялбар байхсан. Гэвч энэ бол Бурханы арга зам биш юм. Ахлагчид хонин сүрэгт үлгэр дуурайл болох замаар чуулганыг харгалздаг.

Шууд утгаараа ахлагчид чуулганы хөг аялгуу ямар байхыг тогтоодог. Сүнслэг, Эзэнийг амьдралынхаа нэн тэргүүнд тавьдаг, Эзэн Есүсийн нигүүлслийг өөрөөсөө цацруулдаг ахлагчидтай чуулган эрүүл, сүнслэг байдаг бол нөгөө талаас ахлагчид нь энэ дэлхийн хэрэг явдалд умбасан, гадаад сонирхолд автсан, Бурханы Үгийг унших эсвэл залбирах завгүй чуулганы хонин сүрэг дунд хүйтэн хөндий, үхмэл байдал бий болдог нь харагддаг. .

Дахин хэлэхэд ахлагчид сул дорой нэгэнд тусалдаг байх ёстой. *“Ийм маягаар шаргуу хөдөлмөрлөж байж л сул дорой нэгэндээ тус болох ёстойг би та нарт бүх талаар үзүүлсэн. Мөн Эзэн Есүсийн айлдсан “Авахаасаа өгөх нь илүү ерөөлтэй” гэсэн үгийг санагтун”* (Үйлс 20:35). Хам сэдвээс нь үзвэл ахлагчид гачигдалтай хүмүүст өглөг өгөх замаар туслахад бэлэн байх ёстой гэсэн санаа харагдаж

байна. Тэд хонин сүргийг амжиргаа болгохын оронд амжиргаагаа хонин сүрэгтэйгээ хуваалцах ёстой ажээ.

Эцэст нь, ахлагчид зэмлэж, сануулж, сэнхрүүлдэг байх ёстой (2 Тимот 4:2, Тит 1:13, 2:15). Итгэлийн эсрэг хандсан ямар ч зүйлийг бүрэн эрхийнхээ дагуу зэмлэх ёстой. Эрүүл, зөв номлолыг дааж чадахгүй хүмүүст сануулж, тэднийг сэнхрүүлдэг байх ёстой бөгөөд ахлагчид итгэлийн төлөө шаргуу тэмцдэг байх ёстой.

Ахлагчдад хандах чуулганы хандлага ямар байх ёстой вэ? Зарим ахлагчид чуулганы санхүүгийн дэмжлэгээр ажлаа хийдгийг 1 Тимот 5:17-18-аас тодорхой харж болно. *“Сайн удирдаж байгаа ахлагчид, ялангуяа үг ба сургаал дотор шаргуу ажиллаж буй хүмүүс хоёр дахин хүндэтгэл авах зохистой хэмээн үз. Учир нь Судар “Буудай цайруулж байгаа үхрийн аманд хошуувч бүү хий”, “Ажилчин хөлсөө авах нь зохистой” гэж хэлдэг”* Бас зарим ахлагчид өөрийнхөө хүчээр ажилдаг нь мөн адил тодорхой байна. Үүний нэг тод жишээ бол Паул Өөрөө юм (1 Коринт 4:12).

Нэмж хэлэхэд, ахлагчийг зэмлэхгүйгээр түүнд эцэг хүний ёсоор хандах ёстой ажээ (1 Тимот 5:1). Ахлагчийг хоёр буюу гурван хүн буруутгахаас нааш ганц хүний буруутгалыг итгэгчид хүлээн авах ёсгүй (1 Тимот 5:19).

Харгалзагчдыг санаж, хүлээн зөвшөөрч, дуулгавартай дагах ёстой. *“Мөн тэдний ажил хөдөлмөрийнх нь төлөө та нар хайр дотор тэднийг үлэмж өндрөөр үнэлэхийг хүсэж байна”* (1 Тесалоник 5:13). *“Та нарт Бурханы үгийг ярьж, та нарыг тэргүүлж явсан хүмүүсийг сана. Тэдний биеэ хэрхэн авч явсны үр дүнг санаж, итгэлийг нь дуурай. Есүс Христ өчигдөр ч, өнөөдөр ч хэвээрээ бөгөөд мөнхөд хэвээрээ байна.”* (Еврей 13:7-8).

Эцэст нь ахлагчдын шагнал ямар байхыг дурдая. *“Ахлах Хоньчинг үзэгдэхэд та нар алдрын гандашгүй титмийг хүлээн авна”* (1 Петр 5:4).

## ҮЙЛЧЛЭГЧИД

### Үйлчлэгчид (deacons)

Харгалзагчид Бурханы өргөөний сүнслэг байдлыг харгалзан сахих үүрэгтэй болохыг бид харгалзагчийн тухай хичээлээс үзсэн. Харгалзагчдыг бас ахлагчид гэдгийг, хэд хэдэн чуулганыг нэг харгалзагч хариуцдаггүй харин нэг чуулганд хэд хэдэн харгалзагч байдгийг бид тэмдэглэсэн.

Харин энэ удаа үйлчлэгчид гэж хэн болох, тэд ямар үүрэг хариуцлагатай болохыг үзнэ.

#### 1. Үйлчлэгч гэж хэн вэ?

“Deacon” гэдэг үг үйлчлэгч гэсэн утгатай бөгөөд зарим нэг ажил үйлчлэл эрхэлдэг хүнийг хэлдэг. Шинэ Гэрээнд үйлчлэгч нь ерөнхий энэ утгаараа олонтаа хэрэглэгдсэн байдаг. Тухайлбал, иргэний олон нийтийн хэрэг явдлыг захиран шийтгэдэг, албан ёсоор томилогдсон хүнийг Бурханы үйлчлэгч гэдэг байжээ (Ром 15:8). Фойбе гэгч эмэгтэйг Кенхрей дахь чуулганы үйлчлэгч гэсэн байдаг (Ром 16:1). Христийг Бурханы үнэний төлөө хөвч хөндүүлэгчдийн зарц (үйлчлэгч) хэмээн дүрсэлжээ. Үйлс 6:1-7-д чуулганы санхүүг хариуцахаар сонгогдсон долоон хүнд энэ үгийг хэрэглэсэн байдаг. Ер нь бол “үйлчлэгч” гэсэн үг энэ ишлэлүүдэд бичигдээгүй ч түүний утга өргөн хүрээгээр илэрхийлэгдсэн агаад нэр заан дурдагдсан үйлчлэлээс гадна өөр ямар ч төрлийн үйлчлэлд хэрэглэгддэг аж.

#### 2. Үйлчлэгчид тавигдах шаардлагууд

Үйлчлэгч нарын гүйцэтгэх үүргийн талаар тодорхой өгүүлсэн зүйл байхгүй ч тэдэнд тавигдах шаардлагыг 1 Тимот 3-т нарийвчлан өгүүлсэн ба 8-р ишлэлээс эхлэн ийн бичжээ. *“Үүнчлэн үйлчлэгчид хүндэтгэлтэй хүмүүс байх ёстой. Тэд хоёр хэлтэй биш, дарсанд шунахайрдаггүй, бузар олз ашиг хайдаггүй бөгөөд итгэлийн нууцыг цэвэр*

*мөс чанараар сахих учиртай. Эхлээд эдгээр нь шалгагддаг. Тэгээд хэрэв тэд гэм зэмгүй бол үйлчлэгчид болог. Түүнчлэн эмэгтэйчүүд нь хүндэтгэлтэй, хов жив хөөцөлддөггүй, тэвчээртэй, бүх юманд итгэмжтэй байх ёстой. Үйлчлэгч хүн нэг л эхнэрийн нөхөр байх ёстой бөгөөд хүүхдүүдээ болон өөрийн гэр бүлийг сайн захирдаг хүмүүс байг. Учир нь сайн үйлчилсэн хүмүүс нь сайн байр суурийг олдог бөгөөд Христ Есүст итгэх итгэлдээ үлэмж их зоригтой болдог.”*

Хүндэтгэлтэй байх нь тавигдах эхний шаардлага аж. Хөнгөн хийсвэр хүн үйлчилж буй хүмүүсийнхээ итгэлийг олж чадахгүй байх магадлалтай.

Хоёрдугаарт, үйлчлэгч хүн хоёр хэлтэй байх ёсгүй буюу өөрөөр хэлбэл хэлсэн үгэндээ эзэн болдог байх ёстой. Нэг хүнд нэг зүйл хэлээд нөгөө хүнд өөрийг ярьдаг байж болохгүй. Үнэнч шударга байдал бол зайлшгүй шаардагдах чанар юм. Ялангуяа санхүүтэй холбоотой үйлчлэлд сэжиг төрүүлэх эсвэл үл итгэх байдал төрүүлэх байдлаас сэргийлэх арга замыг ашиглах нь чухал.

Үйлчлэгч хүн дарсанд шунадаггүй байх ёстой. Биеэ барьж чаддаггүй хүнд хэн ч итгэл хүлээлгэхгүй. Туршилгаас үзэхэд архи дарс болон аливааг хэтрүүлэн хэрэглэх нь нарийн нягт болон найдвартай байдлын дайсан болдгийг харж болох ба эдгээр нь Бурханыг гэрчлэх гэрчлэлийг сүйрүүлж, тухайн хүнийг үйлчлэлд тохирохгүй болгодог.

Мөн түүнчлэн үйлчлэгч хүн мөнгөнд шунадаггүй байх ёстой. Ховдог шунахай сэтгэл бол урхи юм. Хэрэв аливаа хүн эд баялаг хураахад зүрх сэтгэлээ зориулах аваас удахгүй мөнөөх хүсэл шуналдаа бүрэн автагдаж амьдралын өөр бусад зүйлийг нэн тэргүүнд тавихад хүрдэг. Тийм хүний амьдралд Бурханы хаанчлал болон Түүний зөвт байдал нэн тэргүүнд тавигдахаа больж Бурханы төлөө хийсэн ажил нь чанаргүй, муу болдог.

Үйлчлэгч нь итгэлийн нууцыг цэвэр мөс чанараар сахидаг байх ёстой. Энэ бол нэн чухал зүйл. Үйлчлэгч хүн үнэнийг зөвхөн мэддэг байх нь хангалтгүй ба харин Бурханы эсрэг

хоосон гомдол тээгээгүй цэвэр мөс чанараар үнэнийг бодит амьдрал дээр хэрэгжүүлдэг байх нь чухал. Хүменай, Александр хоёр хоёулаа Бурханы Үгийг мэддэг байсан ч тэд бузар муу сургаал номлол болох гэм нүгэлтэй зууралдсан байв (2 Тимот 2:17). Тэд цэвэр мөс чанарын дуу хоолойг живүүлж, итгэлийн усан онгоцыг сүйрүүлсэн юм (1 Тимот 1:19,20). Бурханы таалалд үл нийцэх зүйлийг ялган харж, түүний эсрэг Эзэний талд зогсоход хүргэдэг эелдэг зөөлөн мөс чанарыг орлуулах зүйл гэж байхгүй.

Дараа нь 10-р ишлэлд: *“Эхлээд эдгээр нь шалгагдаг. Тэгээд хэрэв тэд гэм зэмгүй бол үйлчлэгчид болог”* гэжээ. Энэ бол ихээхэн чухал ач холбогдолтой тэнгэрлэг зарчим юм. Өөр нэг ишлэлд: *“Хэн дээр ч яаран гараа бүү тавь”* (1 Тимот 5:22) гэжээ. Үүнийг бид бүгд сайн санаж байх ёстой. Бид хэн нэгэнтээ анх уулзаад л өндөр сэтгэгдэл төрж тэр даруй түүнийг хариуцлагатай байр суурь дээр тавих хандлага гаргадаг. Дараа нь хэтэрхий яарсанаа ойлгох нь их. “Гялалзаж байгаа бүхэн алт биш”.

Үйлчлэгч хүнд тавигдах хоёр дахь шаардлага түүний эхнэрт хамаатай мэт ажээ. Англи хэл дээрх Жеймс хаан Библид *“Түүнчлэн эхнэрүүд нь хүндэтгэлтэй, хов жив хөөцөлддөггүй, тэвчээртэй, бүх юманд итгэмжтэй байх ёстой”* гэсэн байдаг. Гэтэл, Ж. Н Дарбигийн орчуулга гол санааг илүү оновчтой гарган ийн бичжээ. *“Түүнчлэн эмэгтэйчүүд нь хүндэтгэлтэй, хов жив хөөцөлддөггүй, тэвчээртэй, бүх юманд итгэмжтэй байх ёстой”*. Энд дурдагдсан эмэгтэйчүүд гэдэг нь үйлчлэгч нарын эхнэрүүдийг биш харин өөрсдөө үйлчлэгч эмэгтэйчүүдийг хэлсэн аж. Фойбе гэгч эмэгтэй үйлчлэгч байсан (Ром 16:1). Харгалзагч хүний эхнэрт ямар нэгэн шаардлага тавигдаагүй атал яагаад үйлчлэгч хүний эхнэрт тодорхой шаардлагууд тавигдаж байгааг ойлгоход бэрх юм. Харин энэ ишлэл орон нутгийн чуулганд үйлчилж буй эмэгтэйчүүдийн тухай өгүүлсэн аваас ойлгоход хэцүү зүйл байхгүй.

Үйлчлэгч хүн ахлагч хүний адил нэг эхнэртэй, өөрийн хүүхдүүд болон орон гэрээ захирдаг байх ёстойг бид үзсэн.



Мөн түүнчлэн өөрийн гэрт хүндэтгэл хүлээж, эрх мэдлээ тогтоож чадаагүй эр хүн чуулганд тийм байж чадна гэхэд хэцүү.

### **3. Үйлчлэгч нарын шагнал**

Үйлчлэгч хүний шагнал хоёр хэсгээс бүрддэг. Үйлчлэгчийн ажлыг сайн хийсэн хүн ариун хүмүүсийнхээ дунд нэр төртэй байж Христийн шүүхийн ширээний өмнө сайн шагнал авна. Хоёрдугаарт, Есүс Христ доторх итгэл дотроо агуу их эр зоригийг олж авна. Энэ дэлхий ийм зорилтыг дорд үздэг нь үнэн. Энэ бол дэлхийн хувьд дэндүү нууцархаг, үл ойлгогдох, бүдэг бадаг зүйл юм. Гэвч Бурханы хүүхдүүдийн тухайд алт ба үнэт чулуунаас ч илүү үнэ цэнэтэй зүйл.

Үйлчлэгч нарын санхүүгийн дэмжлэгийн тухайд тэд харгалзагч нартай адил юм. Зарим нь энгийн ажил эрхлэж өөрсдийн хэрэгцээг хангадаг байхад зарим нь өөрсдийгөө Эзэнд бүхэлд нь зориулдаг ба ийм хүмүүсийн тухайд *“Түүнчлэн сайн мэдээг тунхаглагчид сайн мэдээгээр амь зуухыг Эзэн тогтоосон ажээ.”* (1 Кориинт 9:14). *“Үгэнд суралцагч нь сургаагчтайгаа сайн бүхнээ хуваалцаг”* (Галат 6:6) гэсэн байдаг.

### **4. Дүгнэлт**

Үйлчлэгчийн тухай энэ судалгаагаа дуусгахын өмнө Филиппой 1:1-ийг дахин харцгаая. Бурханы чуулганд ариун хүмүүс, харгалзагчид, үйлчлэгчид гэсэн гурван төрлийн хүмүүс байдаг ажээ. Энд зөвхөн ийм гурван ангилалын хүмүүсийг онцлон дурдсаныг анхаарууштай. Эхлээд ариун хүмүүс, дараа нь харгалзагчид, тэгээд үйлчлэгчид.

Санваартан гэсэн өөр нэг ангилалын хүмүүс дурдагдаагүйг анхаарах нь зүйтэй. Үүнийг “Шинэ Гэрээний тайлбар толь” номондоо Барнес ийн бичжээ: “Элч Паул энэхүү бүлэгт (1 Тимот 3) чуулганыг хариуцах ёстой хүмүүсийн шинж чанарыг нэн тодорхой өгүүлэхдээ “харгалзагч” ба “үйлчлэгч”-ийг зөвхөн онцлон өгүүлсэн байна.

Эхнийх нь чуулганы сүнслэг байдлыг хариуцаж Үгийг дамжуулах ажил үйлчлэл эрхэлдэг бол хоёр дахь нь үйлчлэгчид бөгөөд тэд сургаал номлол заахаар томилогдсон тухай гэрчлэх зүйл ганц ч үгүй. Өөр гурав дахь алба гэж байхгүй. “Харгалзагч” ба “үйлчлэгч” хүмүүсээс дээд “албан тушаалтай” хэн нэгний талаар дурьдсан зүйл байхгүй.

Хэрэв чуулганд гурав дахь буюу “санваартаны” албан тушаал гэж байх ёстой байсан бол элч Паул чуулганы зохион байгуулалттай холбоотой тов тодорхой зааварчилгаа өгч байхдаа ийм чухал зүйлийг орхигдуулна гэж үү? Тэдний тухай дурьдсан зүйл яагаад байдаггүй вэ? Тэдэнд тавигдах шаардлагуудын талаар яагаад юу ч өгүүлээгүй вэ? Хэрэв Тимот өөрөө “санваартан” байсан бол тухайн албан тушаалыг өөр бусдад шилжүүлэх тал дээр ямар нэгэн зүйл хийхгүй байх байсан гэж үү? Хэрэв ийм албан тушаал гэж байсан бол түүнд тавигдах шаардлагын талаар дурьтах нь зүй ёсных биш гэж үү? Тимот ийм албан тушаалын талаар зарим зүйлийг орхигдуулсан байлаа гэхэд тийн орхигдуулах нь Паулд өөрт нь зохистой байх уу?”

Хэрэв Шинэ Гэрээний чуулганы зохион байгуулалтанд харгалзагч болон үйлчлэгчээс өөр албан тушаал гэж байсан бол Паул үүнийг заавал дурьтах байсан. Өнөө үеийн сүмийн нүсэр зохион байгуулалт бол Бурханы Үгтэй холбоогүй, хүний бодол санаанаас гарсан зүйл юм.

### **Чуулганы санхүү**

Чуулганы санхүү түүнд хамрагдах хүмүүсээс бүрддэг тухай Шинэ Гэрээний эхнээс дуустал өгүүлсэн байдаг. Чуулганыг итгэгч бус хүн санхүүгээр дэмжих санааг цухуйлгасан зүйл байхгүй. Итгэгч хүний өргөл бол магтаал хүндэтгэлийн үйлдэл бөгөөд тиймээс ч Христийн үнэт цусаар аврагдсан хүмүүсээр хязгаарлагддаг ажээ. Мөн түүнчлэн орон нутгийн чуулганыг өөр бусад чуулган, эсвэл хэсэг бүлэг чуулган, эсвэл зөвлөл санхүүжүүлэх буюу тэтгэн дэмжих тухай ч өгүүлсэн зүйл байхгүй. Орон нутгийн чуулган бүр бие даасан байх ёстой. Чуулганы санхүүгийн тухай энэхүү чухал сэдэвтэй холбоотой Шинэ Гэрээний гол

сургаалуудыг дараах маягаар тоймлож болох юм:

### **1. Хэнд юу байдаг вэ?**

Итгэгч хүнд байгаа бүхэн Бурханаас ирдэг. Итгэгч хүн нярав шиг байж өөрт байгаа бүхнийг бүх арга замаар Эзэний суу алдрын төлөө ашиглах ёстой. (Лук 16:1-12-ыг үзнэ үү). Энэхүү үнэнийг Ф. Б. Мейер ийнхүү илэрхийлэн бичжээ: “Бид нярав шиг байх ёстой. Эзэний мөнгийг өөрсдийн хэрэгцээнд зориулан хурааж хуримтлуулахгүйгээр өөрсдийн болон хайртай, дотны хүмүүсийнхээ хэрэгцээнээс бусад бүх мөнгийг Эзэнд, Өөрт нь захиран зарцуулах ёстой. Эзэн маань биднээс мөнгийг нь хэрхэн захиран зарцуулсныг асуухаар ирэх үед Түүнд баяр хөөртэйгөөр тайлагнахын тулд бид Эзэний мөнгийг дээд зэргийн үр ашигтай ашиглах ёстой ба энэ бол бидний цорын ганц материаллаг зорилго юм.”

### **2. Хэзээ, хаана өгөх вэ?**

Итгэгч хүмүүсийг Эзэний ажил үйлсэд зориулан мөнгө өгөх хэрэгтэй гэж Библид заадаг. Тэгвэл хэзээ өгөх вэ? *“долоо хоног бүрийн эхний өдөр хүн болгон бололцоогоороо цааш нь хийж хадгал”* (1 Коринт 16:2).

Хир зэргийг өгөх вэ? Бурханы өгсөн хэмжээгээр мөн (1 Коринт 16:2) Христийн өгсөн хэмжээгээр өгнө. Есүс баян байсан ч биднийг баян болгохын тулд Өөрөө ядуу болсон юм (2 Коринт 8:9).

Есүс бол бидний үлгэр дуурайл бөгөөд бид элбэг дэлбэг байгаа зүйлээсээ илүүчлэх биш харин хэрэгцээ шаардлаганаасаа өгөх ёстой (Марк 12:44). Товчхондоо, итгэгч хүн харамгүйгээр өгөх учиртай. Израильчуудийн өргөдөг байсан аравны нэг бол тэдний өгч байсан өргөлийн хамгийн бага хэмжээ байсан. Ямар ч итгэгч хүн хуульд зааснаас багыг өгч байгаадаа сэтгэл амрах ёсгүй.

### **3. Яаж өгөх вэ?**

Ямар сэтгэлээр өгөх вэ? Эхлээд өөрийгөө Эзэнд өгч (2 Коринт 8:5) бүх зүйл Түүнийх гэдгийг хүлээн зөвшөөрөх ёстой. Хайраар өгөх ёстой (1 Коринт 13:3). Эс бөгөөс ямар

ч үнэ цэнэгүй байх болно. Мөн нууцаар (Матай 6:1-4), утгачлан хэлбэл, зүүн гар нь баруун гарынхаа юу хийж байгааг мэдэхгүй байхаар нууцаар өгөх ёстой. Бас гар татаж биш харин баяр хөөртэйгөөр өгөх ёстой (2 Коринт 9:7). Эртний итгэгчид эд хөрөнгөө зарж нэг нэгэнтэйгээ хуваалцаж байсныг бид мэднэ (Үйлс 2:44-45, 4:31-37). Энэ бол тэдний сүнслэг нэгдлийн илэрхийлэл юм. Ийм зүйл хийхийг тушаасан зүйл Шинэ Гэрээнд байхгүй. Үнэндээ бол итгэгч хүний өглөгтэй холбоотой Шинэ Гэрээний зааврууд итгэгч хүн хувийн өмчтэй байж болохыг хориогүй билээ. Эртний чуулганы хийж байсан зүйлс цэвэр сайн дурын үндсэн дээр хийгддэг байсан. Үүнийг өнөө үеийн “сүм хийд” эсвэл “социализм”-тай хутган ойлгож болохгүй.

#### **4. Хариу шагнал**

Өгөхийн хариу шагнал юу байх вэ? Биднийг зөвт бус эд баялагт (мөнгийг ашиглах тал дээр) итгэмжит байх аваас Бурхан бидэнд жинхэнэ баялагийг (сүнслэг эрдэнэс) итгэн даатгах болно (Лук 16:11). Ийм хүний бэлэг *“Бурханд таашаагдах тааламжит тахил ба анхилуун үнэр”* (Филиппой 4:18) байдаг тул тэрээр тэнгэрт эд баялагтай байх болно (Матай 6:19-21).

#### **5. Эрдэнэсийн санг хариуцагч**

Чуулганы сан хөмрөгийг хариуцагч хүний ажлын арга барил нь гэм зэмгүй байх ёстой. *“Учир нь бид зөвхөн Эзэний өмнө төдийгүй мөн хүмүүсийн өмнө хүндлүүштэй зүйлсийг ч анхаарч үздэг.”* (2 Коринт 8:21). Өргөлийг доод тал нь хоёр хүн хариуцах учиртай аж. Цуглааны бэлэвсэн эмэгтэйчүүдэд чуулганы сан хөмрөгөөс тараан өгөх ажлыг долоон хүн хариуцан хийхээр томилогдсон тухай Үйлс 6:1-6-д өгүүлсэн байдаг. Чуулганы мөнгийг хэдэн хүн хариуцахыг Шинэ Гэрээний захидлуудад нарийн гаргаж хэлээгүй ч үүнийг нэгээс олон хүнд хариуцуулдаг байсныг 1 Коринт 16:3,4 мөн 2 Коринт 8:18,19-аас тодорхой харж болно. 1 Коринт 16:3 ба 4-т Паул тэдний зөвшөөрсөн хүнээр бэлэг сэлт явуулна гээд шаардлагатай бол би өөрөө бас хамт явна гэжээ. 3,4-р ишлэлүүдэд “хүмүүс”, “тэд” гэсэн олон тоонд хэрэглэгдснийг анхаарна уу. 2 Коринт 8:18,19-т

Паул чуулганаас өгч буй бэлгийг тараах үйлсэд өөртэй нь хамт өөр нэг итгэгч анд нөхөр явахаар сонгогдсон тухай өгүүлсэн байдаг.

## **6. Орон нутгийн чуулганы өргөл**

Шинэ Гэрээнд чуулганы сан хөмрөгийг зарцуулах гурван гол зорилгыг өгүүлсэн байдаг. Нэгдүгээрт, цуглааны бэлэвсэн эмэгтэйчүүд, хоёрдугаарт, тарчиг ядуу ариун хүмүүс, гуравдугаарт, өөрсдийн цаг завьг Бурханы Үгийг заан номлоход зориулсан хүмүүс.

*Цуглааны бэлэвсэн эмэгтэйчүүдийн тухайд* (Үйлс 6:1-6). Үүнд тохирохын тулд (1 Тимот 5:3-16) бэлэвсэн эмэгтэй нь дараах шаардлагуудыг хангасан байна:

- (1) Тэрээр өөрийг нь тэтгэж дэмжих хамаатан садангүй, орхигдсон ба тиймээс хэрэгцээгээ Эзэнд даатган өгөхөөс өөр аргагүй болсон байх ёстой (4,5-р ишлэлүүд).
- (2) жараас доошгүй настай байна
- (3) *сайн үйлсээрээ гэрчлэгдсэн, үр хүүхдүүдээ өсгөн хүмүүжүүлсэн, танихгүй хүмүүст зочломтгой байж, ариун хүмүүсийн хөлийг угаасан, зовсон хүмүүст тусламж үзүүлсэн ба аливаа сайн үйлсэд өөрийгөө зориулсан байх учиртай* (10-р ишлэл).

*Тарчиг ядуу ариун хүмүүсийн тухайд* Бурхан Өөрийнхөө Үгэнд тарчиг ядуу хүмүүсийг санаж байхыг олонтаа уриалдаг (жишээ нь, Галат 2:10, Ром 12:13) ба Хуучин Гэрээнд Өөрийнх нь ард түмний хөгжил цэцэглэл гачигдалтай “ах дүүст” хэрхэн хандахтай шууд холбоотой байсан (Дэд хууль 14:29). МЭ 45 оны үед Иудейн олон арван итгэгчид ядууралд өртөж байжээ. Энэ нь хатуу ширүүн хавчилга ба өргөн тархсан ган гачигаас болсон байх магадлалтай. Антиохийн ариун хүмүүс Барнаб, Саул хоёрын гараар Иудейн итгэгч ах дүү нарт тусламж илгээжээ (Үйлс 11:27-30). Коринтын цуглааныг бас тийнхүү үйлдэхийг уриалсан байдаг (1 Коринт 16:1-3, 2 Коринт 8 ба 9). Үүнтэй нэгэн адилаар бид ч бас гачигдалтай байгаа итгэгч ах дүүсээ анхаарах ёстой. Эзэн Есүс “*та нар үргэлж ядуустай цуг байна*” (Марк 14:7) гэсэн. Цуглаан нь бурханлаг

байдлаар халамж анхаарал тавих ядуу амьдралтай гишүүдтэй байх нь сайн хэрэг юм. Барнес энэ талаар бичихдээ, “Итгэгчдийг хооронд нь нэгтгэж, дунд нь хагарал, атаархал гарахаас сэргийлэх нэг зүйл бол бүх хүн хувь нэмрээ оруулсан, бүх хүний сонирхол татсан сайн үйлсийн аян юм” гэсэн байдаг. Гэвч ажил хийх хүсэлгүй учраас ядуу тарчиг амьдардаг хүмүүсийн төлөө цуглаан хариуцлага хүлээх хэрэггүй. Ийм тохиолдолд “хэн нэг нь ажил хийхгүй бол бүү идээ” (2 Тесалоник 3:10) гэсэн тэнгэрлэг зарлиг үйлчилнэ.

*Өөрсдийн цаг завьыг Эзний ажил үйлсэд зориулдаг хүмүүсийн тухайд* Сайн мэдээг дэлгэрүүлдэг эсвэл Бурханы Үгийг заадаг хүмүүс ариун хүмүүсийн тусламж дэмжлэгийг авах эрхтэй. Энэ бол тэнгэрлэг зарчим юм. “*Үгэнд суралцагч нь сургагчтайгаа сайн бүхнээ хуваалцаг*” (Галат 6:6), (Мөн 1 Коринт 9:4-13, 1 Тимот 5:17,18-ыг үзнэ үү).

Гэвч элч Паул цуглаануудаас дэмжлэг авахын оронд өөрийн гараар хөдөлмөрлөдөг байсан (Үйлс 18:3). Ингэх шалтгаан нь ч энгийн байв. Тэрээр Ефесийн итгэгчид ч бас сул дорой нэгэнд тусалдаг, бусдад өгөхийн хариу ивээлийг мэддэг байгаасай гэсэндээ тэдэнд өөрийн биеэр үлгэр дуурайл болохыг хүссэн аж (Үйлс 20:33-35). Түүнээс гадна Коринт хотын шүүмжлэгчид түүнийг хөлсөөр ажилладаг хэмээн буруутгахаас сэргийлсэн ба (2 Коринт 11:7-12) мөн Тесалоник хотын итгэгчдэд дарамт болохоос болгоомжилсон ажээ (1 Тесалоник 2:9, 2 Тесалоник 3:7-9). Тэндэхийн итгэгчид ядуу бас их хавчигдмал байсан юм.

Филиппой хотын цуглаан Паулд тусалсныхаа төлөө сайшаагдаж байсан. (Филиппой 4:10-19). Паул тэдний нөхөрлөлийг хэрэгцээнээсээ болж эрээгүй харин тэдэнд үр жимс арвин байхыг хүссэн юм.

Элч Паул хувийн хэрэгцээ шаардлагаа хэзээ ч зарлаж байгаагүй ч бусад ариун хүмүүсийнхийг эргэлзэлгүй мэдүүлдэг байсныг анхаарах нь зүйтэй (2 Коринт 8 ба 9). Мэдээлэл өгөх, ямар нэг зүйл хийхэд уриалах хоёр өөр юм.

## **7. Дүгнэлт**

Чуулганыг санхүүжүүлнэ гэдэг гайхалтай энгийн зүйл болохыг Шинэ Гэрээг уншсан хүн олж мэдэх болно. Ягштал мөрдөх хүнд хэцүү хууль дүрэм эсвэл санхүүгийн нарийн зохион байгуулалттай байгууллага гэж байх хэрэггүй ажээ. Бичээсийн энгийн заавруудыг дагаж мөрдөх тохиолдолд хоёр чухал үр дүнд хүрнэ. Чуулганы хэрэгцээ шаардлага аяндаа, хэнийг ч уриалах шаардлагагүйгээр хангагдаж, дэлхий ертөнц чуулганыг мөнгө олдог байгууллага хэмээн зэмлэх аргагүй болно.

## БИДНИЙ ӨМНӨӨС

### Эмэгтэйчүүдийн ажил үйлчлэл

Чуулганд эзлэх эмэгтэй хүний байр суурь ба үйлчлэлийн тухай тодорхой зааврууд Шинэ Гэрээнд байдаг ба эдгээрийг дүгнэвэл:

#### 1. Гол асуудал

Аврал ба Бурханд хүлээн авагдах мэт асуудал дээр эмэгтэй хүн эрэгтэй хүнтэй эн тэнцүү юм. *“эр ч гэж байхгүй, эм ч гэж байхгүй. Учир нь та нар бүгд Христ Есүс дотор нэг болой”* (Галат 3:28). Гэвч энэ бол чуулганд хүйсийн ялгаа арилдаг гэсэн үг биш юм шүү. Бичээс өдөр тутмын амьдралтай холбоотой асуудал дээр эрэгтэй, эмэгтэй хүнийг ялгасан байдаг. Жишээлбэл, Ефес 5-р бүлэг *“Эхнэрүүд ээ, Эзэнд захирагддаг шиг нөхрүүддээ захирагд”* (22-р ишлэл), *“Нөхрүүд ээ, Христ чуулганыг хайрлаад түүний төлөө Өөрийгөө өгсний адил эхнэрүүддээ хайрла”* (25-р ишлэл) гэж бидэнд сургадаг. Тиймээс, Бурханы өмнө зогсох тал дээр эмэгтэй хүн эрэгтэй хүнтэй адил боловч чуулганд эзлэх түүний байр суурь эрэгтэй хүнийхээс ялгаатай гэж хэлж болох юм. Товчхондоо, эмэгтэй хүн эрэгтэй хүнд захирагддаг нь гол ялгаа ажээ (1 Коринт 11:3).

#### 2. Хориотой зүйлс

Библийн дараах тушаал заавруудад эмэгтэй хүн ямар байдлуудад яаж захирагдах ёстойг тодорхой өгүүлжээ. Эмэгтэй хүн чуулганд дуугүй байх ёстой (1 Коринт 14:34-35). Яагаад дуугүй байх ёстойг дараагийн ишлэлүүдэд тайлбарласан аж. Эмэгтэй хүн сургаал зааж болохгүй (1 Тимот 2:12).

Олны өмнө асуулт асууж болохгүй (1 Коринт 14:35). Эмэгтэй хүн дуугүй байж, бүрэн дуулгавартайгаар суралцах ёстой (1 Тимот 2:11).

Эмэгтэй хүн эр хүнийг захирч болохгүй (1 Тимот 2:12).



Толгойгоо бүтээхгүйгээр залбирах буюу эш үзүүлж болохгүй (1 Коринт 11:5). Эмэгтэй хүн чуулганд олны өмнө залбирч болохгүй гэсэн энэ санааг 1 Тимот 2:8 нэн хүчтэй илэрхийлж *“Иймд би эрчүүдийг уур хилэнгүй, маргалдалгүйгээр, ариун гараа өргөж, газар бүрд залбираасай гэж хүсдэг”* гэжээ. “Эрчүүд” гэсэн үгэнд хэрэглэгдсэн грек үг бол эмэгтэйчүүдийг оруулаагүй, цэвэр эр хүйсийг заасан үг юм.

Эдгээр заавруудыг эмэгтэйчүүдэд хэт ёсчлон, хатуу чангаар хүчлэн хэрэгжүүлэх тохиолдолд хоёр үр дагавар гарна. Бурхан зүрх сэтгэлээсээ биш харин албан хүчээр дуулгавартай байхад дургүй (Дуулал 51:17). Эдгээр зааврыг хүчээр хэрэгжүүлбэл эмэгтэй хүн удалгүй шаналан зовж, дургүйцэх хандлагатай болно. Нөгөө талаар, эдгээр заавар тушаалуудын утга учрыг тодорхой ойлгох тохиолдолд хайраар дүүрэн, хүлцэнгүй сэтгэлийн дуулгавартай байдал бий болох ба энэ бол Эзэний нүдэнд агуу, үнэ цэнэтэй өргөл юм (1 Самуел 15:22).

### **3. Учир шалтгаан**

Бурхан, Өөрийн Үгэндээ итгэгч эмэгтэй хүн яагаад эр хүнд захирагдах ёстойг тайлбарлаж тодорхой хэдэн зарчмыг эелдэг зөөлнөөр гарган тавьсан байдаг.

Нэгдүгээрт, бүтээлийн дэс дарааллын тухайд эхлээд эрэгтэй хүн дараа нь эмэгтэй хүн бүтээгдсэн. *“Учир нь эхлээд Адам, дараа нь Ева бүтээгдсэн билээ”* (1 Тимот 2:13). *“Учир нь эр хүн эмэгтэй хүнээс бус, харин эмэгтэй хүн эр хүнээс бий болсон”* (1 Коринт 11:8). Бүтээлийн үед тогтоогдсон энэ дэс дараалал чуулганд бас мөрдөгдөхийг Эзэн Бурхан хүссэн ажээ.

Өөрөөр хэлбэл, эмэгтэй хүний тэргүүн бол эр хүн юм (1 Коринт 11:3).

Хоёрдугаарт, эр хүн эмэгтэй хүний тэргүүнд байдгийг бүтээлийн зорилго харуулж байна. *“Үнэндээ эр хүн эмэгтэй хүний төлөө бүтээгдсэн бус, харин эмэгтэй хүн эр хүний*

*төлөө бүтээгдсэн юм” (1 Коринт 11:9).*

Гуравдугаарт, Еваг анх эр нөхөр Адамынхаа эрхийг булаан авах үед дэлхийд гэм нүгэл орж ирсэн. *“Адам мэхлэгдээгүй. Харин эмэгтэй нь мэхлэгдэж, гэм буруу дотор унасан юм” (1 тимот 2:14)* Өөрийнх нь шинэ бүтээл үл захирагдах байдлаар дамжуулан гажуудан муудахыг хүсээгүй тул Эзэн эмэгтэй хүнийг эр хүнд захирагдаж байхаар болгожээ.

Дөрөвдүгээрт, элч Паул эмэгтэй хүн эр хүнд захирагдах ёстойг Хуучин Гэрээний гэрчлэлүүдээс харуулдаг байсан (1 Коринт 14:34). *“Харин Хууль юу хэлдэг шиг тэд захирагдаж байг”* Энэ тухай өгүүлсэн тодорхой тушаал байхгүй ч Хуучин Гэрээний чиглэл ийм аж.

#### **4. Толгойгоо бүтээх нь**

Эмэгтэй хүн залбирах буюу эш үзүүлэхдээ толгойгоо бүтээх тухай тушаалтай холбоотой хоёр учир шалтгаан бий.

Нэгдүгээрт тэнгэр элчүүд түүнийг дээрээс нь харж байдаг. *“Тиймээс тэнгэр элч нарын улмаас эмэгтэй хүн толгой дээрээ эрх мэдлийн тэмдэг байлгах ёстой” (1 Коринт 11:10).* Бурханы тогтоосон зарлиг тушаал газар дээр хэрхэн хэрэгжиж байгааг тэнгэр элч нар ажиглан харж байдгийг энэ ишлэл илэрхийлэх мэт агаад эмэгтэй хүн эр хүний эрх мэдэлд байдгийн шинж тэмдэг болгож толгойдоо гивлүүр зүүх ёстой гэжээ. Ингэж, бүтээлийн эхний үед Евагийн үйлдсэн хууль бус үйлдэл шинэ бүтээлд үүрд хадгалагдаагүйг тэнгэр элчүүд хардаг байна.

Үүнийг хүний төрөлх байдал өөрөө сургадаг ажээ. *“.....төрөлх байдал өөрөө та нарт сургадаг бус уу?”(1 Коринт 11:14).* Бурхан анх хүнийг бүтээхдээ эмэгтэй хүнд өвөрмөц бүтээлэг болох урт үсийг өгсөн. Эмэгтэй хүн залбирах буюу эш үзүүлэхдээ толгойгоо бүтээх ёстой гэсэн тэнгэрлэг зарчим үүнээс илэрхийлэгдэж байгааг элч Паул нотолсон аж.

#### **5. Эерэг чанарууд**

Эмэгтэй хүн эр хүний эрх мэдэлд байдаг гэсэн энэ бодит үнэн түүнийг Бурханы эдийн засагт ямар ч үүрэг гүйцэтгэдэггүй гэсэн бодлыг зарим хүнд төрүүлж болох юм. Гэвч, эмэгтэй хүний ажил үйлчлэл олон нийтийн биш ч бодит бөгөөд чухал байдгийг Бичээс харуулдаг. Эмэгтэй хүн хүүхэд төрүүлснээр байр суурь нь аврагддаг (1 Тимот 2:15). Ойлгоход хэцүү энэ ишлэл, сүнслэг эх хүн олон нийтийн ажил үйлчлэл эрхлэх хориотой ч хэнд ч хэрэггүйд тооцогдохоос аврагддаг гэсэн утгатай байж болох юм. Гэр бүлээ Эзэнээс эмээдэг, Эзэнээр сургамжлуулдаг болгож өсгөн хүмүүжүүлэх нь түүний байр суурь аж. Хэрэв түүний эр нөхөр итгэл дотроо үргэлжлүүлэн амьдрах аваас нэг л өдөр Бурханы Үгийг бусдад зааж сургадаг хөвгүүдтэй болох болно. Тиймээс “аврагдах болно” гэсэн үг түүний сүнстэй биш, тэр ч бүү хэл хүүхэд төрүүлснээр махан биеийн үхлээс аврагдахтай ч биш харин эмэгтэй хүний байр суурь ба эдлэх эрхний авралтай холбоотой юм. Тэрээр эс орших ямар нэг зүйл биш харин Бурханы алдрын төлөө амьдрах хүүхдүүдийг өсгөж хүмүүжүүлэх суу алдарт ажил үйлчлэлтэй болох ажээ.

Өөрсдийн өмч хөрөнгөөр тус болох (Лук 8:3), зочин хүлээн авч дайлах (Ром 16:1), залуу бүсгүйчүүдийг сургах (Тит 2:4) гэх мэт ажил үйлчлэлүүд эрхэлж байсан өөр эмэгтэйчүүдийн жишээ Шинэ Гэрээнд олон бий.

## **6. Зарим нийтлэг эсэргүүцэл**

Эмэгтэйчүүдийн ажил үйлчлэлтэй холбоотой эсэргүүцэл болон элдэв асуултууд олон гардаг. Паулын энэ тухай заасан сургаалыг эмэгтэйчүүдийг ялгаварладаг гоонь эрийн үзэл бодол гэж маргах нь их бий. Үгүй ээ! Энэ бол Бурханы Ариун Сүнсний сургаал буюу 1 Коринт 14:37-д Паулын хэлсэнчлэн “*энэ зүйлс нь Эзэний тушаал*” юм.

Тэгвэл Паул заасан зүйлээ өнөөгийн бидэнд бас ашиглагдах ёстой гэдгийг бодолгүйгээр зүгээр л тэр үеийн ёс заншлын дагуу заан сургаж байсан уу? Үгүй. Учир нь Коринт хотын итгэгчдэд хандан бичсэн түүний эхний захидал зөвхөн тэдэнд биш харин “*хаа сайгүй бидний Эзэн Есүс Христийн нэрийг дуудагч....*” (1 Коринт 1:2) бүхэнд

зориулагдсан байсан. Тиймээс энэ сургаал бүх нийтийнх аж.

Паул 1 Коринт 11:16-д өөрийнх нь зааж сургасан зүйлийг заавал биелүүлэх албагүй, Бурханы чуулганууд дунд тийм зуршил байхгүй гэж хэлээгүй гэж үү хэмээн хүмүүс биднээс асуух нь бий. (*“Хэрэв хэн нэг нь маргаантай байхыг боддог бол тийм ёс заншил бидэнд ч, Бурханы чуулгануудад ч байхгүй билээ”*). Уг ишлэлийг ингэж тайлбарлах нь Библийн эрх мэдэл ба сүр хүчийг бууруулж буй хэрэг юм. Тухайн ишлэл чухам юу өгүүлж байна вэ гэвэл, Эзэний тушаалуудын талаар маргах нь чуулгануудад зуршил болсон зүйл биш гэдгийг илэрхийлж байгаа ажээ. Эзэний тушаалуудыг чуулганууд маргалдалгүй, тайлбар өгөлгүй тэр чигээр нь хүлээн авдаг байсан.

Хэрэв эмэгтэй хүнд толгойг нь бүтээх хэрэгсэл болгон үсийг өгсөн бол толгой бүтээх өөр зүйл шаардлагагүй бус уу гэж бас маргадаг. 1 Коринт 11-д толгойны хоёр төрлийн бүтээлэг бичигджээ. 15-р ишлэлд эмэгтэй хүний үсийг бүтээлэг хэмээн өгүүлсэн боловч 5-р ишлэлээс үзвэл гивлүүр бас хэрэгтэй аж. Тийм биш аваас 6-р ишлэл “Хэрэв эмэгтэй хүн толгойгоо үсээр бүтээхгүй бол үсээ бас хяргаг. Гэвч үсээ хяргах, хусуулах нь эмэгтэй хүнд ичгэвтэр байвал тэр өөрийн толгойг үсээр бүтээг” гэсэн утгатай байхсан. Ийм утга санаа илэрхийлсэн байх мэдээж боломжгүй бөгөөд эмэгтэй хүн толгойгоо үснээс өөр зүйлээр бүтээх ёстой гэсэн санааг илэрхийлж байгаа нь мэдээж.

Эмэгтэйчүүдийг чуулганд дуугүй байх ёстой гэсэн нь (1 Коринт 14:34) зүгээр л үйлчлэлийн үеэр тэднийг хоорондоо чалчих буюу хов жив ярихыг хориглосон хэрэг биш үү? Үгүй! Уг ишлэлд *“чуулгануудад эмэгтэйчүүд чимээгүй байг (бүү яриг)”* гэсэн. “Чимээгүй байг буюу бүү яриг” хэмээн орчуулагдсан үг Шинэ Гэрээнд “чалчих” эсвэл “юм бувтнах” гэсэн утга огт илэрхийлдэггүй бөгөөд мөн энэ үгийг 21-р ишлэлд *“Би .....харь хүмүүсийн амаар дамжуулж энэ хүмүүст ярина”* хэмээн Бурханы хэлсэн үгэнд ашигласан байдаг.

Эмэгтэйчүүд олны өмнө гэрчлэлээ ярих, сайн мэдээний

үйлчлэлийнхээ тайланг тавих, гоцлон дуулах зэрэг нь байж болох зүйл үү гэх мэт өөр асуулт гарч ирдэг. Тухайн хэргүүдийн талаар Библид тусгайлан заагаагүй бол тэдгээрийг Бурханы Үгийн ерөнхий зарчмын дагуу шийднэ. Харин эргэлзээтэй нөхцөл байдал үүсэх үед, эр хүний эрх мэдэл эмэгтэй хүнд очиж байна уу? Эмэгтэй хүн удирдлаганд гарч байна уу? Тухайн эмэгтэй Бурханы Үгийг зааж байна уу? гэсэн асуултуудыг асуух нь зүйтэй. Эдгээр нь нэгэнт хориотой зүйлс тул бид Бурханы Үгийн эдгээр сургаалын үнэн утга учрыг зөрчих ямар нэг зүйлээс зайлсхийх хэрэгтэй.

## **7. Бурханы мэргэн ухаан**

Бурхан Өөрийн хүмүүсийн сайн сайхны төлөө мөн Өөрийн суу алдрын төлөө эдгээр заавар тушаалуудыг өгсөн ажээ. Түүний Үгийг үл тоох буюу зориудаар зөрчих үед элдэв хэрүүл маргаан, эмх замбараагүй байдлууд үүсдэг. Эмэгтэйчүүд эрх мэдлийг булаан авах, олны өмнө сургаал заахын уршигт муу үр дагаварыг өнөө үед их хэмжээгээр өсөн нэмэгдэх болсон буруу урсгалуудаас харж болно. Тухайлбал, эмэгтэйчүүд онцгой үүрэг гүйцэтгэдэг Долоо дахь өдрийн Адвентизм, Теософи, Христэч шинжлэх ухаан зэргийг нэрлэж болно.

Нөгөө талаар, Бурханаас заяасан байр сууриа эзэлж, *“дөлгөөн ба даруу сэтгэлийн мөхөшгүй чанараар...”* (1 Петр 3:4) чимэглэсэн Христ итгэлт эмэгтэйчүүдийг харахаас илүү сэтгэл татам, таатай зүйл гэж үгүй.

## **Христийн зүг урагшаа**

Өмнөх хуудсуудад бид даяар чуулган болон орон нутгийн чуулганы тухай ярилцсан. Мөн Шинэ Гэрээнд заагдсан чуулганы гол зарчмуудтай танилцаж, элч нарын үед оршин байсан цуглаан хичнээн энгийн, хичээл зүтгэлтэй, сүнслэг байсныг олж мэдэхийг хичээсэн. Харин одоо “Энэ бүхнийг өнөө үеийн бүх итгэгч хүн яаж хэрэгжүүлэх вэ?” гэсэн асуулт үлдэж байна.

### **1. Өнөөгийн чуулган**

Энэхүү асуултад хариулахын тулд эхлээд өнөө үеийн

чуулганууд ямар байдалтай байгааг товч харцгаая. Хаашаа ч харсан чуулганаа орхин явах, үнэнээс татгалзах, унах сүйрэх байдлууд харагдах аж. Материаллаг эд баялаг болон улс төрийн сонирхолтой ихээр хутгалдсан ч сүнслэг байдлын хүч маш их дутмаг шашны том байгууллагууд, өөр өөрсдийн үзэл баримтлалыг дэмждэг, түүндээ үнэнч хэмээн нотолдог боловч чуулганы тухай итгэмээргүй, мушгин гуйвуулсан үзэл санааг заадаг шашны урсгалууд, төрөл бүрийн сектүүд олон бий. Бас чуулганы цугларалтууд сүмийн үхмэл ёслол, зан үйлээр дүүрсэн, хүмүүст Христийг өгөхийн оронд Түүний сүүдрийг өгдөг. Өнөө үеийн санваартны систем нь жирийн хүнийг зүгээр нэг мөнгө түгээдэг машин биш гэхэд дүйнгэ тахилч лам болгодог. Бас жинхэнэ итгэгч болон амьд Аврагчтай амин чухал холбоогоор холбогдоогүй хүмүүсийг багтаасан итгэгч ба итгэгч биш хүмүүсийг гишүүнээрээ элсүүлсэн чуулганууд олон бий. Эцэст нь, авралын нигүүлслийг нийгмийн сайн мэдээгээр орлуулдаг модернизмын исгэгч хөрөнгө нэвчсэн чуулганууд ч бас бий.

## **2. Холдож салах хэрэгцээ**

Ийм байдалд орсон итгэгч хүн яах ёстой вэ гэсэн асуулт гарч ирнэ. Үүнд өгөх ганц л хариу бий. Тэндээс холдож Христийн зүг урагш яв! Итгэгч хүн шашны ч бай, сургаалын ч бай, ёс суртахууны ч бай аливаа бузар муугаас хол байхыг Бурханы Үг эргэлт буцалтгүй, тууштай ятган сургадаг. *“Үл итгээгчдийн хамт нэг буулганд бүү орогтун. Зөвт байдал ба ёс бус нь яаж хамтрах билээ? Гэрэл ба харанхуйн хооронд ямар нөхөрлөл байдаг билээ? Христ ба Белиалын хооронд ямар зохицол байх билээ? Итгээгч хүн итгээгч бус хүнтэй юугаараа адил билээ? Бурханы сүм ба шүтээнүүдийн хооронд ямар зөвшилцөл байх билээ? Учир нь бид амьд Бурханы сүм мөн. Бурхан айлдахдаа: “Би тэдний дотор оршино. Би тэдний дунд алхана. Би тэдний Бурхан болно. Тэд Миний ард түмэн болно. Тиймээс тэдний дундаас гарч тусгаар бай” гэж Эзэн айлддаг. «Бузар юманд бүү хүр. Би та нарыг хүлээн авч, Та нарын Эцэг чинь болно. Та нар ч Миний хөвгүүд, охид болно» гэж Төгс хүчит Эзэн айлддаг”* (2 Коринт 6:14-18).

Итгэгч хүн Бурханы дуу хоолой болохын тулд бузар муу чуулгандаа үлдэх ёстой хэмээн маргадаг нь дэмий зүйл юм. Амьдарч байсан цаг үеэ орвонгоор нь эргүүлсэн, “Ганц дайчин ганцаардахгүй... Урагшаа” хэмээн хэлээгүй нэг ч баатар, нэг ч ариун хүн байгаагүй. .... Энэ дэлхийг засаж сайжруулахаар дэлхий рүү очсон хүн өөрөө сүүлд нь муудаж, дордсон байдаг... Хамгийн аюулгүй, хүчирхэг байрлал бол буудлын гадна тал юм. Архмед, “Надад тулах цэг өгвөл би дэлхийг эргүүлнэ” хэмээн хэлж байсан. Үүнтэй адилаар өөрийнхөө цаг үед бүх амьдралаа талбайн гадна өнгөрөөсөн Елиатай ижилхэн Бурханы цөөхөн хэдэн зарц бас цаг үедээ хүчтэй нөлөөлж чадна”.

“Чуулганд эзлэх байр суурь нь буруу гэдгийг мэдсээр байж үргэлжлүүлэн эзлэхийг хүсэгч бүх хүнд Самуел *“Харагтун, дуулгавартай дагах нь тахил өргөхөөс илүү, сонсож дагах нь хуцын өөхнөөс илүү”*” (1 Самуел 15:22) гэсэн хүчирхэг хариуг өгч байна.

### **3. Дараа нь яах вэ?**

Итгэгч хүн “гарч явах” тухай Бичээсийн тушаалыг даган биелүүлснийхээ дараа яах ёстой вэ гэсэн асуулт хэвээр үлдэнэ. Энэ асуултад хариулахын тулд Бичээсийн дагуу дараах төлөвлөгөөг танилцуулая:

Ижил бодол санаатай бусад итгэгч хүмүүстэй энгийн байдлаар цуглан уулзаж болно.

Зөвхөн Христ дээр цуглаж, ганцхан Түүнийг татагдах цорын ганц зүйл болго. Ийм бодлого хэдийгээр олон хүнийг цуглуулахгүй ч наад тал нь, сорилт ба урам хугаралтанд амархан бууж өгөхгүй, үнэнч итгэлтэй итгэгч хүмүүсийн цөмийг үүсгэж чадна.

Цуглах байрны тухайд айлын гэр байхад хангалттай бөгөөд Библид ийм жишээ олон бий (Ром 16:5, 1 Коринт 16:19, Колоссай 4:15, Филимон 2). Шашинаар иж бүрэн тоноглогдсон, сүмийн сүрлэг байшин барилга хүсдэг хүмүүс Өөрийнх нь хүмүүсийн цугладаг Эзэн Есүс Өөрөө бүгдэд хангалттай болохыг олж мэдээгүй байдаг.

Жинхэнэ итгэгч хүнийг итгэгчдийн нөхөрлөлөөс хасах ямар нэгэн нэр эсвэл бодлогыг бүү авч ашигла.

Шашны ямар нэгэн урсгалтай бүү нэгд. Орон нутгийн чуулганы хараат бус байдалд халдаж болох гадны ямар нэгэн удирдлага ба хөндлөнгийн оролцооноос татгалз.

Ажил үйлчлэлийг ганц хүний гарт шилжүүлж болох байнгын чиг хандлагыг сөрөн зогс. Үүний оронд, чуулганд Христийн өгсөн олон төрлийн сүнслэг бэлгүүдийг ашиглан ажиллах боломжийг Ариун Сүнсэнд олгож, бүх итгэгч хүнд тахилч гэдгээ илэрхийлэн харуулах боломж олго.

Залбирахаар, Үгийг судлахаар, талх хувааж, нөхөрлөхөөр тогтмол цугла. Мөн түүнчлэн сайн мэдээ ганцаар болон хамт олноороо тараах үйлсэд идэвхтэй оролц.

Товчхондоо, жинхэнэ утгаар нь Христийн биеийг итгэлтэйгээр төлөөлж мөн Эзэний тушаалуудыг дуулгавартай даган биелүүлэх замаар Шинэ Гэрээний чуулганууд шиг цуглахыг эрэлхийлэх хэрэгтэй.

#### **4. Гарч явагсад**

Чухам үүнийг дэлхий даяар итгэгчид хийсээр ирсэн нь сонирхолтой. Тэд Библээс өөр ямар нэг гарын авлагагүйгээр эдгээрийг тэнгэрлэг зарчим мөн болохыг мэдэж, зэмлэл, доромжлолоос үл хамааран даган мөрдсөөр ирсэн. Тэдэнд Христээс өөр ямар ч тэргүүн, Ариун Сүнснээс өөр ямар ч нөхөрлөл, Түүний сэнтийнээс өөр ямар ч удирдлага байхгүй. Тэд даруу төлөв байдлаар Христийн биеийн эв нэгдлийг гэрчлэн харуулахыг хичээдэг. Модернизм ба түүнтэй холбоотой өөр бусад бузар муугийн дарангуйлалд өртсөн жинхэнэ итгэгч хүмүүст өөрсдийн нөхөрлөлийг хорогдох ариун газар болгон өргөхийг хичээдэг. Ийм чуулгануудыг жагсаан бичсэн лавлах бичиг газар дээр байхгүй бөгөөд тэд газар дэлхийн зүйлээр хоорондоо холбогдоогүй юм. Тэднийг нэгтгэдэг, эв нэгдлийг нь хадгалдаг цорын ганц зүйл бол Ариун Сүнс бөгөөд ийм байхад ч тэд дуртай, сэтгэл хангалуун байдаг.



Үүнтэй адил олон зуун нөхөрлөлүүдийг Өөрийнх нь хүмүүсийн аминч бус залбирлаар дамжуулан чуулганы Тэргүүн болох Христ үүсгэн байгуулахгүй байх шалтаг үгүй. Итгэгч хүмүүс ийм зөн харааг аваад, үүний төлөө зовлон амсахад бэлэн байх үед Эзэн тэдний хичээл зүтгэлийг үнэлэн шагнаж Өөрийг нь алдаршуулах гэсэн тэдний их хүслийг биелүүлж өгнө.

Эзэнийг буцаж ирэх яг тэр агшинд Христ итгэлт ертөнцийн урвалтын эсрэг Ариун Сүнсний үүсгэсэн агуу бослого ба Библийг хайрладаг итгэгчдийн бие даасан жижиг нөхөрлөлүүдийг бий болгосон Түүний нигүүлслийн цоо шинэ хөдөлгөөнийг бид харах боломжгүй гэж үү?

**Чуулганыг хайрлаж, Түүний төлөө Өөрийгөө өгсөн Тэр Нэгэн Өөрийн алдарын төлөө үүнийг биелүүлэх болтугай!**



**ЕСҮС ХРИСТ ЧУУЛГАНЫГ ХАЙРЛАСАН**  
**Виллиам МайкДоналд**

**ҮЛ УСТАХ ҮГС**

**Утас: 91228571; 96320262**

**Цахим шуудан: [ulustahugs@gmail.com](mailto:ulustahugs@gmail.com)**